



Европын Холбоо  
санхүүжүүлэв



Food and Agriculture  
Organization of the  
United Nations

НУБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын  
Хөдөлмөрийн  
Байгууллага



UN  
DP

ЕВРОПЫН ХОЛБООНЫ  
САНХҮҮЖИЛТТЭЙ  
“МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТой  
УЯЛДСАН ТӨСВИЙН  
ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР  
ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ  
ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

# СОЁЛЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

---

## СОЁЛЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

### Тайланг боловсруулсан:

Багийн ахлагч **Л.Мөнхзул**

Зөвлөх **Ж.Ганбаатар**

Зөвлөх **Г.Амаржаргал**

### Хянан тохиолдуулсан:

**М. Санжаадорж**, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Энэхүү “Соёлын салбарын төсвийн зарлагын шинжилгээ” судалгааны тайланг Европын Холбооны санхүүжилттэй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

НҮБХХ нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

### Ерөнхий мэдэгдэл

ISBN 978-9919-9059-3-4

Тус тайлан нь Европын Холбооны санхүүжилтээр хэвлэгдсэн болно. Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд ЕХ болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбоо, НҮБХХ хариуцлага хүлээхгүй болно. НҮБХХ-ийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.



## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГС	6
ОРШИЛ	7
1. СОЁЛЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ	8
1.1. Төсвийн зарлагын шинжилгээ зорилго	8
1.2. Зарлагын шинжилгээний хамрах хүрээ	8
1.3. Зарлагын шинжилгээний арга зүй	8
2. СОЁЛЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН	10
2.1. Монгол Улсын соёлын салбарын урт ба дунд хугацааны бодлогууд	10
2.2. Салбарын хууль эрх орчин	16
2.3. Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилго 2030 ба соёлын салбарын бодлогын уялдаа	19
3. СОЁЛЫН САЛБАРЫН ИНСТИТУЦ	21
3.1. Соёлын салбарын байгууллагын тогтолцоо	21
3.2. Соёлын салбарт ажиллагчид	23
4. СОЁЛЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН МАКРО ҮЗҮҮЛЭЛТҮҮД	27
5. СОЁЛЫН САЛБАРЫН ТӨСВИЙН НАЙДВАРТАЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	29
5.1. Нийт зарлагын гүйцэтгэл	29
5.2. Төсвийн зарлагын гүйцэтгэл, зардлын ангиллаар	31
5.3. Төсвийн орлогын гүйцэтгэл	35
6. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХӨТӨЛБӨР, ЗОРИУЛАЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ	37
7. СОЁЛЫН САЛБАРЫН УРСГАЛ БА ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ЧИГ ХАНДЛАГА, ХУВААРИЛАЛТ	42
7.1. Салбарын нийт төсвийн зарлагын хуваарилалт	44
7.2. Салбарын урсгал зардлын бүтэц	46
7.2.1. Салбарын урсгал зардалд цалин хөлсний зардлын эзлэх харьцаа	47
7.2.2. Салбарын урсгал зардалд тогтмол зардлын эзлэх харьцаа	50
7.3. Салбарын хөрөнгийн зардлын чиг хандлага	51
8. ТӨСВИЙН ХАНГАЛТТАЙ БАЙДАЛ	56
9. СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ	58
9.1. Театр, чуулгын соёлын үйлчилгээний үр дүн, зардлын өгөөж	60
9.2. Музейн үйлчилгээний үр дүн, зардлын өгөөж	63
9.3. Номын сангийн үйлчилгээний үр дүн, зардлын өгөөж	66
9.4. Соёлын төвийн үйлчилгээ үр дүн, зардлын өгөөж	67
9.5. Соёлын бүтээлч үйлдвэрлэл	72
10. ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ	78
11. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТой УЯЛДСАН СОЁЛЫН САЛБАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД	80
12. ДҮГНЭЛТ	96
ЗӨВЛӨМЖ	101
АШИГЛАСАН НОМ ЗҮЙ	104

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- 10 Хүснэгт 1. Соёлын салбарын урт ба дунд хугацааны бодлогын зорилтууд
- 11 Хүснэгт 2. “Алсын хараа 2050” хөгжлийн бодлого, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээ
- 14 Хүснэгт 3. Алсын хараа 2050 хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтээс
- 15 Хүснэгт 4. “МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин
- 16 Хүснэгт 5. Соёлын салбарт хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиуд
- 24 Хүснэгт 6. Соёлын байгууллагад ажиллагчдын тоо, байгууллагын төрлөөр
- 26 Хүснэгт 7. Үндэсний урлаг, соёлын удирдах албан тушаалтны хүйсийн харьцаа
- 27 Хүснэгт 8. Харьяалах Төсвийн ерөнхийлөн захирагч
- 30 Хүснэгт 9. Нийт зарлагын батлагдсан төсөв ба гүйцэтгэл
- 31 Хүснэгт 12. Зарлагын төсвийн гүйцэтгэл, байгууллагаар, 2020 он
- 32 Хүснэгт 13. Зарлагын төсвийн гүйцэтгэл, байгууллагаар, 2021 он
- 33 Хүснэгт 14. Зарлагын төсвийн гүйцэтгэл, байгууллагаар, 2022 он
- 34 Хүснэгт 15. Салбарын төсөв ба гүйцэтгэл, ЭЗ-ийн ангиллаар (сая төгрөгөөр)
- 34 Хүснэгт 16. Зарлагын төсвийн гүйцэтгэл, ЭЗ-ийн ангиллаар, 2020 он
- 34 Хүснэгт 17. Зарлагын төсвийн гүйцэтгэл, ЭЗ-ийн ангиллаар, 2021 он
- 35 Хүснэгт 18. Зарлагын төсвийн гүйцэтгэл, ЭЗ-ийн ангиллаар, 2022 он
- 35 Хүснэгт 20. Нийт орлогын гүйцэтгэл, сая төгрөгөөр
- 37 Хүснэгт 22. Хөтөлбөрийн ангиллын харьцуулалт
- 38 Хүснэгт 23. Салбарын зарлагын гүйцэтгэл, хөтөлбөрөөр, сая төгрөгөөр
- 38 Хүснэгт 24. Соёлын салбарын төсвийн зарлагын хөтөлбөр, зардлын зориулалт, арга хэмжээний ангиллаар /сая. төг/
- 42 Хүснэгт 25. Салбарын урсгал ба хөрөнгийн зардлын гүйцэтгэл, сая төгрөгөөр
- 45 Хүснэгт 26. Соёлын байгууллагуудад улсын төсвөөс олгосон зардал, 2022 оноор, сая төг.
- 46 Хүснэгт 27. Соёлын сайдын шууд зардлын бүтэц
- 48 Хүснэгт 28. Салбарын цалин хөлсний зардлын гүйцэтгэл, сая төгрөгөөр
- 50 Хүснэгт 29. Цалин хөлсний зөрүү (мянган төг.)
- 50 Хүснэгт 30. Төрийн өмчит соёлын байгууллагын байр ашиглалтын тогтмол зардал, сая төгрөгөөр
- 51 Хүснэгт 31. Орон нутгийн өмчит соёлын байгууллагын байр ашиглалтын тогтмол зардал, сая төг.
- 52 Хүснэгт 32. Хөрөнгө оруулалтын төсөв ба гүйцэтгэл /сая.төг/
- 52 Хүснэгт 33. Хөрөнгө оруулалт байгууллагын төрлөөр
- 53 Хүснэгт 34. Хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэл, оноор
- 56 Хүснэгт 35. Нийт өр, авлага, байгууллагын төрлөөр, сая төгрөгөөр, 2022 он
- 58 Хүснэгт 36. Соёл урлаг хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд
- 60 Хүснэгт 37. Хамаарлын шинжилгээ
- 61 Хүснэгт 38. Мэргэжлийн урлагийн байгууллагуудын зардлын өгөөж
- 64 Хүснэгт 39. Музейн урсгал зардлын өгөөж
- 66 Хүснэгт 40. Нийтийн номын сангийн үзүүлэлт
- 74 Хүснэгт 41. Интернэтэд 1 минутад эргэлдэж буй мэдээллийн хэмжээ
- 84 Хүснэгт 42. Соёлын салбарын хөдөлмөр эрхлэлт
- 94 Хүснэгт 43. Тоон болон чанарын үзүүлэлтийн товчоо

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- 21 **Зураг 1.** Соёлын салбарын байгууллагууд
- 22 **Зураг 2.** Соёлын яамны бүтэц
- 23 **Зураг 3.** Соёл, урлагийн байгууллагын ажилтнуудын тоо, 2012-2022 он
- 23 **Зураг 4.** Соёл, урлагийн байгууллагын ажиллагчдын тоо, 2022 он
- 24 **Зураг 5.** Соёлын байгууллагын ажилтны орон тоо, 2022 он
- 25 **Зураг 6.** Соёлын байгууллагын ажилтнууд боловсролын түвшнээр, эзлэх хувиар
- 25 **Зураг 7.** Соёлын салбарт хөдөлмөр эрхлэгчдийн нийт ажиллагчдын тоонд эзлэх хувь
- 26 **Зураг 8.** Соёлын салбарын ажилтнуудын тоо, хүйсээр 2022 он
- 28 **Зураг 9.** Салбарын төсвийн зарлагын ДНБ ба улсын нэгдсэн төсөвт эзлэх хувь /тэрбум төг./
- 28 **Зураг 10.** “Соёлын үйлчилгээ”, “нэвтрүүлэх, түгээх үйлчилгээ”-нд улсын төсвөөс зарцуулсан зардлын ДНБ-д эзлэх хувь
- 29 **Зураг 11.** Салбарын батлагдсан төсөв, гүйцэтгэл /тэрбум.төг/
- 30 **Зураг 12.** Төсвийн зарлагын гүйцэтгэл, жилийн өсөлтийн хувь /тэрбум төг./
- 40 **Зураг 13.** Соёлын арга хэмжээ, зарлагын төрлөөр, сая төгрөгөөр
- 42 **Зураг 14.** Урсгал ба хөрөнгийн зардлын жилийн өсөлт, хувиар
- 43 **Зураг 15.** Төсвийн нийт зарлагын гүйцэтгэлд урсгал ба хөрөнгийн зардлын эзлэх хувь
- 44 **Зураг 16.** Салбарын урсгал ба хөрөнгийн зардлын төсвийн гүйцэтгэлийн хувь
- 44 **Зураг 18.** Нийт төсвийн зарлагын хуваарилалт, 2022
- 44 **Зураг 17.** Урсгал төсвийн зарлагын хуваарилалт, 2022
- 47 **Зураг 19.** Салбарын урсгал зардлын бүтэц /хувиар/
- 47 **Зураг 20.** Салбарын бараа үйлчилгээний зардлын бүтэц, хувиар
- 49 **Зураг 21.** Соёлын байгууллагын ажилтны дундаж цалин хөлс, мянган төгрөгөөр
- 49 **Зураг 22.** Соёл ба бусад салбарын цалин хөлс, мянган төгрөгөөр
- 54 **Зураг 23.** 2010-2023 онд баригдсан барилгын тоо, зориулалтаар
- 56 **Зураг 24.** Салбарын нийт өр төлбөр ба авлага, сая төгрөгөөр
- 61 **Зураг 25.** Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолтын ба үзэгчдийн тоо
- 63 **Зураг 26.** Музейн үзмэрийн ба үзэгчдийн тоо
- 66 **Зураг 27.** Номын сангийн уншигчдын тоо болон суудлын тооны харьцаа
- 66 **Зураг 28.** Номын сангийн тоо болон номын фондны тооны харьцаа
- 67 **Зураг 29.** Соёлын төвийн үзүүлэлтүүдийн харьцуулалт
- 69 **Зураг 30.** Австралийн Брисбане хотын урлагийн төв
- 69 **Зураг 31.** Урлагийн төвийн дотор тал
- 74 **Зураг 32.** Дижитал орчинд соёлын салбарыг дэмжих төрийн дэмжлэг

---

---

## ТОВЧИЛСОН ҮГС

---

<b>ДНБ</b>	Дотоодын нийт бүтээгдэхүүн
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>ЗЦХЗ</b>	Зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа
<b>МУ</b>	Монгол Улс
<b>НҮБ</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллага
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>СБ</b>	Соёлын байгууллага
<b>СБҮ</b>	Соёлын бүтээлч үйлдвэрлэл
<b>СУГ</b>	Соёл урлагийн газар
<b>СУДС</b>	Соёл урлагийг дэмжих сан
<b>ТХЗ</b>	Тогтвортой хөгжлийн зорилго
<b>ТЭСХ</b>	Төсвийн зарлага, санхүүгийн хариуцлага
<b>ТТХГНХЗ</b>	Төрийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа
<b>ТӨҮГ</b>	Төрийн өмчит үйлдвэрийн газар
<b>ТЭЗҮ</b>	Техник эдийн засгийн үндэслэл
<b>ҮДСТТ</b>	Үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт
<b>ЭЗХАХБ</b>	Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагууд

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) нь “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” техникийн туслалцааны төслийг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлж байна. Сангийн яам нь энэхүү төслийн “А” бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааг НҮБХХ-тэй хамтран хэрэгжүүлж байна.

Төслийн дэмжлэгийн хүрээнд Монгол Улсад бодлого ба төсвийн уялдааг хангах, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг ТХЗ-ийн тэргүүлэх салбар, хөтөлбөрүүдэд нэвтрүүлэх, дунд хугацааны зарлагын хүрээнд шилжих бодлогын хувилбарыг тодорхойлохоор ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 2023 оны төсвийн төслийг үр дүнд суурилсан төсөвлөлтийн аргачлалаар боловсруулж, амжилттай туршиж, төсвийг батлуулсан.

Цаашид ТХЗ-ын тэргүүлэх салбаруудын хөтөлбөрийн бодлого, төсвийг уялдуулан үр дүнд суурилсан төлөвлөлтөд шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах, нотолгоонд суурилсан төсөв боловсруулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор соёлын салбарын хөтөлбөрт институтийн болон зарлагын шинжилгээг дотоодын зөвлөхүүдийн тусламжтайгаар хийлээ. Энэхүү зарлагын шинжилгээнд соёлын салбарын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс зарцуулсан төсвийн зарлагын хэмжээ, өсөлт, бууралтад нөлөөлж буй гол хүчин зүйлс, салбарын төсвийн хуваарилалт, төсвийн зардлын үр өгөөжийг тодорхойлж, төсвийн найдвартай байдлын үнэлгээг хийсэн бөгөөд цаашид соёлын салбарт зарцуулж байгаа төсвийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр бодлогын зөвлөмжийг орууллаа.

Тайланг боловсруулахад санхүүгийн болон статистик тоо мэдээллээр хангаж хамтарч ажилласан Соёлын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, салбарын Ерөнхий нягтлан бодогч Г.Эрдэнэсүрэн болон бусад дарга, мэргэжилтнүүд, “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн зөвлөхүүдэд талархлаа илэрхийлэе.

**САНГИЙН ЯАМНЫ ТӨСВИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР**

---

# 1. СОЁЛЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

---

## 1.1. Төсвийн зарлагын шинжилгээ зорилго

Соёлын салбарын төсвийн зарлагын шинжилгээний зорилго нь соёлын салбарын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс зарцуулсан төсвийн зарлагын хэмжээ, чиг хандлага, төсвийн ил тод, найдвартай байдал, төсвийн хуваарилалт ба бодлогын уялдаа, соёлын үйлчилгээний төсвийн үр өгөөжид дүн шинжилгээ хийж Соёлын яам болон СЯ-ны бодлого боловсруулагч, мэргэжилтнүүдэд бодлогын санал дэвшүүлэх, зөвлөмж өгөх зорилготой.

Түүнчлэн энэхүү дүн шинжилгээгээр салбарын төсвийг бодлогын зорилттой уялдуулан үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт (ҮДСТТ)-ийн аргачлалаар төлөвлөдөг зарчимд шилжихийн тулд хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ, урьдчилсан нөхцөлийг тодорхойлох зорилготой болно.

## 1.2. Зарлагын шинжилгээний хамрах хүрээ

Энэхүү сэдэвчилсэн зарлагын шинжилгээнд соёлын салбарт 2012-2022 онд улсын төсвөөс баталсан нийт төсөв, түүний зарцуулалт, урсгал ба хөрөнгийн зардал, урсгал зардлын бүтцийн шинжилгээг хамруулна. Салбарын төсвийн найдвартай байдлыг үнэлэхдээ олон улсын аргачлалын дагуу сүүлийн 3 жилийн буюу 2020-2022 оны төсвийн мэдээлэлд үндэслэнэ.

Энэхүү зарлагын шинжилгээнд соёлын салбарын төрийн ба орон нутгийн өмчит 450 орчим байгууллагууд болох мэргэжлийн урлагийн байгууллагууд, музей, номын сан, соёлын ордон, соёлын төвийн төсөв ба гүйцэтгэлийн мэдээг хамруулсан болно.

Орон нутгийн өмчит соёлын байгууллагуудын төсөв 2012, 2019-2021 онуудад соёлын сайдын төсвийн багцад тусгагдалгүй орон нутгийн төсөвт шилжсэн, 2022 оноос соёлын сайдын төсвийн урсгал шилжүүлэгт орон нутгийн байгууллагуудын төсөв батлагдах болсон. Иймд орон нутгийн соёлын байгууллагуудын төсөвтэй холбоотой зарим дүн шинжилгээг зөвхөн 2022 оноор хийсэн болно.

Соёлын салбарт ажиллагч төрийн албан хаагчдын 2012-2022 оны тоо, мэдээллийг энэхүү шинжилгээнд хамрууллаа.

## 1.3. Зарлагын шинжилгээний арга зүй

Соёлын салбарын төсвийн зарлагын шинжилгээнд хүчин зүйлсийн хамаарлын регрессийн шинжилгээ, энгийн нийцлийн шинжилгээ, чиг хандлагын шинжилгээ, болон дүн шинжилгээний бусад арга зүйг ашиглалаа. Түүнчлэн салбарын урт ба дунд хугацааны бодлого, хууль эрх зүйн орчин, дотоод, гадаадын судалгааны байгууллага, судлаачдын боловсруулсан ном, тайлангуудыг уншиж



---

судлан бусад орнуудын орчин үеийн чиг хандлагыг манай өнөөгийн нөхцөл байдалтай харьцуулан дүгнэлт хийв.

Түүнчлэн салбарын статистикийн тоон ба чанарын өөрчлөлтийн үзүүлэлтүүдийг харьцуулах, хүчин зүйлүүд ба үзүүлэлтийн хамаарлыг графикаар илэрхийлэх арга зүйг ашигласан болно. Энэхүү шинжилгээний хүрээнд асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтнууд, соёлын үйлчилгээ үзүүлж байгаа орон нутгийн байгууллагын төлөөлөгчидтэй санал солилцох уулзалт, ярилцлагууд хийж, дүгнэлт хийлээ.

---

## 2. СОЁЛЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

---

### 2.1. Монгол Улсын соёлын салбарын урт ба дунд хугацааны бодлогууд

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-д нийгэм, соёл, эдийн засаг, байгаль орчны асуудлыг цогцоор нь авч үзэн, хөгжлийн үр шимийг иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүргэх зарчмыг баримтлан бүх салбарын оролцоог ханган, тогтвортой хөгжлийн үндсийг хангахад чиглэсэн.

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Үндэсний нэгдмэл үнэт зүйл” нэгдүгээр бүлгийн “Зорилго 1. Орчин үеийн шинжлэх ухааны арга зүйгээр нарийвчлан судалж, хөдөлшгүй бодит баримтад үндэслэсэн “эх хэл, эх түүх, өв соёлыг” нийт хүн амд төлөвшүүлж, үндэсний ижилсэл-ондоошлын гүн ухамсар, дархлаатай үндэстэн-улс байгуулахад тулгуур болохуйц нэгдмэл үнэт зүйлсийг цогцлооно.” гэж заажээ. Монгол Улс нь үндэсний өв соёлоо нийт хүн амд төлөвшүүлж, дархлаатай, нэгдмэл үнэт зүйлстэй үндэстэн болохыг зорилгыг тэргүүнд тавьсан байна.

Түүнчлэн уг зорилгод хүрэхийн тулд 2030 болон 2050 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн. Алсын хараа 2050 хөгжлийн бодлогыг 2030 он хүртэл хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгаж, УИХ-аас 2020 онд баталсан. Түүнчлэн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг УИХ-аас 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр 24 дүгээр тогтоолоор баталсан. Соёлын салбарт баримтлах урт ба дунд хугацааны бодлогын гол зорилтуудыг дараах хүснэгт 1-д харуулав.

#### *Хүснэгт 1. Соёлын салбарын урт ба дунд хугацааны бодлогын зорилтууд*

##### **Алсын хараа 2050 (2020.05.07)**

Үндэсний нэгдмэл үнэт зүйлс  
Нүүдлийн соёл иргэншилт Монгол  
Дэлхийн Монгол

##### **МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2020.08.28)**

Үндэсний нэгдмэл үнэт зүйлс  
Нүүдлийн соёл иргэншилт Монгол  
Дэлхийн Монгол

##### **Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр (2020.08.28)**

Үндэсний бахархал, өв соёл

Соёлын салбарын урт ба дунд хугацааны бодлогын гол зорилтууд нь түүх, өв соёлоороо дамжуулан үндэсний нэгдмэл үнэт зүйлтэй болох, нүүдлийн соёл иргэншлээ хадгалах, монгол соёлыг гадаадад түгээх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болоход чиглэж байна.

*Хүснэгт 2. “Алсын хараа 2050” хөгжлийн бодлого, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээ*

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” (2020.05.07)	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2020.08.28)
<p><b>ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ</b></p> <p><b>Зорилт 1.1.</b> Төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна.</p> <p><u>Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн</u></p> <p><b>I үе шат (2021-2030):</b> Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлэх үе.</p> <ol style="list-style-type: none"><li>1.Монголчуудын уламжлалт төрт ёсоо дээдлэх эх оронч үзэл, үндэсний эв нэгдэл сэргэнэ.</li><li>2.Өв тэгш, үндэсний ухамсарт эх оронч монгол хүнийг төлөвшүүлнэ.</li><li>3.Төрийн ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагаанд үндэсний онцлог, соёлын хүрээг өргөжүүлнэ.</li><li>4.Түүх, соёлын дурсгал, урлагийн бүтээл, утга зохиолд тулгуурлан үндэсний бахархлыг сэргээж, биет болон биет бус өвийг хадгалан хамгаалж, өвлүүлж хэвшинэ.</li><li>5.Соёл урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлсэн байна.</li></ol>	<p><b>ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ</b></p> <p><b>Зорилт 1.1.</b> Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлнэ:</p> <ol style="list-style-type: none"><li>1.1.уран бүтээл, утга зохиолд үндэсний бахархлыг сэргээх агуулгыг тусгаж, Монголчуудын уламжлалт төрт ёсоо дээдлэх эх оронч үзлийг сэргээнэ.</li><li>1.1.2.үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгоно.</li><li>1.1.3.төрийн ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагааг үндэсний онцлогийг шингээсэн агуулгаар баяжуулна.</li><li>1.1.4.соёлын өвийг хамгаалах тогтвортой механизм бүрдүүлнэ.</li><li>1.1.5.соёл урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.</li></ol>

### НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШИЛТ МОНГОЛ

**Зорилт 1.2.** Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно.

#### **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**

##### **I үе шат (2021-2030):**

Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх үе.

1. Хүмүүнлэг, оюунлаг, ёс суртахуунтай, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг бэлтгэнэ.

2. Нүүдлийн соёл иргэншлийг хамгаалахад чиглэсэн төрөлжсөн байгууллагуудтай болно.

3. Үндэсний сор бүтээл, брэнд, үндэсний шинэлэг бүтээл зэргийг монголын нүүдлийн соёлын онцлогт тохируулан бүтээнэ.

4. Хүүхдийн соёлын өв, хөгжлийн төвийг байгуулна.

#### **ДЭЛХИЙН МОНГОЛ**

**Зорилт 1.5.** Дэлхий дахинд монгол үндэсний үнэт зүйлсийн дархлаа тогтож, монгол соёлыг түгээн дэлгэрүүлж, гадаад нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлж, хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатны хамтын ажиллагаа төлөвшинө.

**Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**

**I үе шат (2021-2030):** Олон улс дахь монгол үндэсний үнэт зүйлсийн

### НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШИЛТ МОНГОЛ

**Зорилт 1.2.** Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ:

1.2.1. өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг төлөвшүүлж, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх цогц арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ.

1.2.2. нүүдлийн соёл, иргэншлийн судалгааны төв байгуулах ажлыг эхлүүлсэн байна.

1.2.3. үндэсний сор бүтээл, брэнд, үндэсний шинэлэг бүтээл зэргийг монгол үндэсний нүүдлийн соёлын онцлогт тохируулан бүтээнэ.

1.2.4. хүүхдийн соёлын өв, хөгжлийн төвийг байгуулах ажлыг эхлүүлнэ.

#### **ДЭЛХИЙН МОНГОЛ**

**Зорилт 1.5.** Олон улс дахь Монгол үндэсний үнэт зүйлсийн дархлааг бэхжүүлж, монгол соёлын хүрээг тэлнэ:

1.5.1. Монгол хүний онцлог, давуу тал, үнэт зүйлийг тодорхойлж, олон нийтэд түгээн дэлгэрүүлнэ.

1.5.2. хилийн чанадад байгаа Монгол Улсын соёлын өвийг бүртгэх ажлыг зохион байгуулна.

1.5.3. үндэсний соёл, урлаг, зан заншил,

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” (2020.05.07)	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2020.08.28)
<p>дархлааг бэхжүүлж, монгол соёлын хүрээг тэлэх үе.</p> <p>1.Монгол хүн бүр үнэт зүйлээ эрхэмлэж, бусдаас ялгарах онцлог, давуу талаа дэлхий нийтэд таниулна.</p> <p>2.Монголын түүх, соёлыг олон улсад сурталчлан таниулах Монголын Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгтэй болсон байна.</p> <p>3.Хилийн чанад дахь Монгол Улсын соёлын өвийг хамгаалах тогтолцоо бүрдсэн байна.</p> <p>4. Үндэсний соёл, спорт, хоол хүнс судлал хөгжиж, дэлхий нийтэд танигдсан байна.</p>	<p>ахуй, спорт, хоол хүнс судлалыг хөгжүүлж, өргөжүүлнэ.</p>

Түүнчлэн Засгийн газраас 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө соёлын салбарт дараах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнд:

#### “Үндэсний бахархал, өв соёл

2.6.Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно.

2.6.1.Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцсэн дараах барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулна:

2.6.2.Соёл, урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн үндэсний зорилтот арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, харилцан уялдаатай, үр дүнтэй хэрэгжүүлнэ:

2.6.3.Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл-инновацын салбарыг хөгжүүлж, монгол брэндийг бий болгож, соёл, урлагийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ:

.....2.6.3.3. “үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч

үйлдвэрлэлийг дэмжиж, соёлын аялал жуулчлал, кино урлаг, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эдийн засгийн эргэлтэд оруулна.

2.6.4.Хэвлэл мэдээллийн салбарыг үнэн бодит мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх чиглэлээр хөгжүүлнэ.”

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ЗГ-ын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталж, гурван зорилтын хүрээнд 30 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ<sup>1</sup>. Соёлын салбарын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгээс харахад салбарын тэргүүлэх бодлого, стратегийг дараах 4 чиглэлээр тодорхойлжээ гэж дүгнэж болохоор байна. Үүнд:

- 1) Үндэсний нэгдмэл үнэт зүйлсийг цогцлоох;
- 2) Бүх нийтийн соёлын боловсролыг олгох;
- 3) Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- 4) Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх.

Соёлын салбарт эдгээр тэргүүлэх бодлого, стратегийг хэрэгжүүлснээр соёлын эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлж, монгол брэндийг бий болгон дэлхийн зах зээлд нэвтрүүлэх, улмаар шинэ ажлын байрыг нэмэгдүүлэх зорилго дэвшүүлсэн байна.

Урт ба дунд хугацааны бодлогын баримт бичигт туссан зорилго, зорилтуудын үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг хүснэгт 3, 4-т харуулав.

“Алсын хараа 2050” хөгжлийн бодлогын “Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг цогцлоох” гэсэн нэгдүгээр бүлгийн зорилгод хүрэх үр дүнг дараах 3 шалгуур үзүүлэлтээр хэмжихээр тодорхойлжээ. Алсын хараа 2050 хөгжлийн бодлогын соёлын салбарт хэрэгжүүлэхээр тусгасан зорилтуудын хэрэгжилтийг тодорхойлох 3 шалгуур үзүүлэлтээс голлох шалгуур үзүүлэлт нь шинэ бүтээл патентын мэдүүлэг, дотоодын мэдүүлгийн тоо байна. Уг үзүүлэлтийг суурь онтой харьцуулахад 2025 онд 1.8 дахин, 2030 онд 2.4 дахин, 2050 он гэхэд 7.3 дахин өсгөх зорилт дэвшүүлжээ.

**Хүснэгт 3. Алсын хараа 2050 хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтээс**

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин		
			2025	2030	2050
Шинэ бүтээл патентын мэдүүлэг, дотоодын мэдүүлэг	тоо	82	150+	200+	600+
Номын сангийн нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь	хувь	0.3	5	7	15
1,000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудлын тоо	тоо	31.7	35	37	45

Харин “МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д туссан зорилго, зорилтын үр дүнгийн хэрэгжилтийг 6 шалгуур үзүүлэлтээр хэмжихээр тодорхойлсны 3 шалгуур үзүүлэлт нь Алсын хараа 2050 хөгжлийн бодлогын үр дүнгийн шалгуур үзүүлэлттэй ижил байна. Гэхдээ Алсын хараа 2050 хөгжлийн бодлогын үр дүнгийн 1 шалгуур үзүүлэлтийн 2030 онд хүрэх түвшинг таван жилийн үндсэн чиглэлд 2025 он гэхэд хүрэхээр тусгасан зөрүүтэй байна.

*Хүснэгт 4. “МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин*

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин (2025 он)	Шалгуур үзүүлэлтийн тайлбар
1	Шинэ бүтээл, патентын мэдүүлэг, дотоодын мэдүүлэг	тоо	82	150+	2019 оны суурь түвшин
2	Номын сангийн нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь	хувь	0.3	5	2019 оны суурь түвшин
3	1000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудлын тоо	тоо	32	37	2018 оны суурь түвшин
4	Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж	хувь	47.1	56.0	2018 оны суурь түвшин
5	Төрийн өмчийн музейн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо	хувь	21.6	23.9	2019 оны суурь түвшин
6	Урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд хүүхдийн эзлэх хувь	хувь	8.1	17.1	2019 оны суурь түвшин

Соёлын салбарт хэрэгжүүлэх дунд ба урт хугацааны бодлогын баримт бичигт томоохон зорилго, үр дүнд хүрэх зорилт дэвшүүлсэн боловч түүнд хүрч буй эсэхийг үнэлэх шалгуур үзүүлэлт нь үр дүнгийн шалгуураас илүүтэй гарц, үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжих шинжтэй шалгуур үзүүлэлтүүд байна.

Цаашид дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтүүдийг дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн хүрэх үр дүнг хэмжихэд аль болох ашиглах нь зүйтэй юм. Учир нь эдгээр үзүүлэлтүүд нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, тэдгээрт гарч байгаа ахиц дэвшлийг хэмжих боломжтой, бусад улс орнуудтай харьцуулалт хийхэд ч дөхөмтэй болох юм. Энэхүү тайлангийн сүүлийн бүлэгт Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан соёлын салбарын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн тодорхойлолт, тооцох аргачлалыг дэлгэрэнгүй оруулсан болно.

## 2.2. Салбарын хууль эрх орчин

Соёлын салбарт дээр дурдсан урт, дунд хугацааны бодлогоос гадна салбарын дараах хуулиуд үйлчилж байна. /Хүснэгт 5/

*Хүснэгт 5. Соёлын салбарт хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиуд*

№	Хуулийн нэр	Батлагдсан огноо	Хуулийн зорилго
1	Соёлын тухай хууль	2021.07.02	Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, зарчмыг тодорхойлж, соёлын үйл ажиллагаа эрхлэх, түүний удирдлага, зохион байгуулалт, оролцогчдын эрх, үүрэг, эдийн засгийн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулдаг.
2	Соёлын өвийг хамгаалах тухай хууль	2014.05.15	Соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, сэргээн уламжлуулах, өвлүүлэх, өмчлөх, эзэмших, ашиглах, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулна.
3	Монгол хэлний тухай хууль	2015.02.12	Монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.
4	Музейн тухай	2021.01.29	Музейн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндсийг тогтоох, музейн сан хөмрөг бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.



№	Хуулийн нэр	Батлагдсан огноо	Хуулийн зорилго
5	Кино урлагийг дэмжих тухай	2021.07.02	Кино үйлдвэрлэх үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, Монгол Улсад кино бүтээх таатай орчныг бий болгох, кино урлагийг хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.
6	Номын сангийн тухай хууль	2014.12.19	Номын сангийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, номын сангийн төрөл, зохион байгуулалт, чиг үүргийг тодорхойлж, уншигчийн эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.
7	Оюуны өмчийн тухай хууль	2020.01.23	Оюуны өмчийн эрхээр хамгаалагдах бүтээл, оюуны өмчийг хамгаалах зарчим, оюуны өмчийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тогтоох, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахыг дэмжихтэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулна.
8	Зохиогчийн эрхийн тухай хууль	2021.05.06	Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлтэй холбоотой үүсэх зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах, соёл, урлагийн бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх зорилгоор бүтээлийг ашиглах эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна.
9	Инновацын тухай хууль	2012.05.22	Инновацын үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, төрийн дэмжлэг, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулан эзэмших, ашиглах, эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна.

Салбарын дээрх хуулиудаас гадна Соёлын тухай хуульд үндэслэн Засгийн газраас 2022 оны 8 дугаар сарын 24-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор “Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл (2022-2027)”, “Соёлын

---

бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ (2022-2030 он)"-г тус тус батлан хэрэгжүүлж байна.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээг соёлын өв, утга зохиол, ном хэвлэл, дүрслэх урлаг, дуу, хөгжим, тайзны урлаг, кино, дуу дүрсний урлаг, хэвлэл мэдээлэл, хувцас загвар, архитектур, дизайн, дижитал контент, тоглоом хөгжүүлэлт, маркетинг, зар сурталчилгаа гэсэн үндсэн чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр тогтоосон байна. Ингэснээр соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үндэсний болон салбарын тогтвортой хөгжлийг бэхжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, бүтээлч авьяас, инновац шингэсэн үйлдвэрлэлийг бий болгохоор төлөвлөсөн байна. Соёлын бодлогыг бүх шатанд харилцан уялдаатай хэрэгжүүлснээр соёл, урлагийн салбар авьяас билиг, мэдлэгт суурилсан эдийн засгийн бие даасан салбар болж хөгжих, олон улсад соёлын экспортлогч улс болох, улмаар Монгол Улсын нэр хүндийг олон улсад өсгөх, улсаа гадаад улсад сурталчлах, соёлын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх бодит нөхцөл бүрдэнэ гэж үзжээ.

Соёлын яамнаас Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг 2022 онд боловсруулсан бөгөөд холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас санал авах үе шатанд байна. Монгол Улс Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуультай болсноор нэмүү өртөг шингэсэн соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадвар сайжрах, бүс, орон нутгийн өвөрмөц соёлын онцлогт тулгуурласан, эдийн засгийн хөгжлийг дэмжсэн бүтээлч кластерууд бий болж жижиг, дунд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг бодитоор дэмжих нөхцөл бүрдэнэ гэж Соёлын яамнаас төлөвлөж байна.

---

### 2.3. Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилго 2030 ба соёлын салбарын бодлогын уялдаа

Нэгдсэн Үндэстний байгууллага (НҮБ)-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг 2015 оны 9 дүгээр сард баталж, хөгжлөөс “хэнийг ч үл орхих” гэсэн зарчимтайгаар байгаль орчин, эх дэлхийгээ хайрлан хамгаалж, хүний эрхийг дээдлэн, байгалийн нөөцийг зохистой ашиглаж, хөгжил цэцэглэлтийг бий болгож, нийгэм, эдийн засаг зэрэг бүх салбарыг тэгш хөгжүүлэх зорилго дэвшүүлсэн.

Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) 2030-д соёлын зорилтуудыг хөгжлийн бодлогод анх удаа оруулж, соёлыг хамгаалах, сурталчлах нь ТХЗ төдийгүй аюулгүй, тогтвортой хот, зохистой хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн өсөлт, тэгш бус байдлыг бууруулах, хүрээлэн буй орчныг хамгаалах, жендерийн тэгш байдал, энх тайван, хүртээмжтэй хөгжлийг дэмжих зэрэг бусад олон ТХЗ-д шууд хувь нэмэр оруулах юм. Тухайлбал, Ээлтэй хот иргэдийн оролцоог дэмжих ТХЗ 11-д соёл чухал үүрэг гүйцэтгэх ба зорилт 11.4-д дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах хүчин чармайлтыг бэхжүүлэхийг уриалсан. Соёлын өвийг хамгаалж, соёлын зориулалттай олон нийтийн газар болгон ашиглахад тухайн орон нутгийн эдийн засагт эерэг нөлөө үзүүлдэг. Түүнчлэн орон нутагт соёлын өвийг хамгаалж, хөгжүүлэхийн тулд янз бүрийн хувь хүн, бүлгүүдийг нэгтгэснээр тэд нийгмийн эв нэгдлийг дэмждэг ТХЗ 17 буюу Тогтвортой хөгжлийн төлөөх дэлхийн түншлэлийг сэргээхэд хувь нэмэр оруулна. Соёлын аялал жуулчлал нь дэлхийн аялал жуулчлалын орлогын 40 хувийг бүрдүүлдэг<sup>2</sup>. (Hosagrahar, 2017). Дэлхийн зарим түүхэн хот суурин газрын эдийн засаг нь гар урлал, хөгжим, бүжиг, дүрслэх урлаг, уламжлалт хоол, театр зэрэг биет бус өвөөс ихээхэн хамааралтай байдаг. Соёлын аялал жуулчлал нь зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ТХЗ 8-д эдийн засгийн өсөлтийг хангахад чухал үүрэгтэй. Соёлын бүтээлч үйлдвэрлэл нь соёлын салбарт ажиллагчдын олонх болох эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төдийгүй Жендерийн тэгш байдлыг хангах ТХЗ 5-д хувь нэмэр оруулна.

Чанартай боловсролыг дэмжих зорилго ТХЗ 4-ын 4.7-д соёлыг тусгайлан заасан бөгөөд энх тайван, хүчирхийлэлгүй соёлыг сурталчлах, дэлхийн иргэн байх, тогтвортой хөгжилд соёлын оруулж буй хувь нэмэр соёлын олон төрөлд эергээр хандах хандлагад суралцахыг уриалсан.

Соёлын бараа, үйлчилгээний худалдааг бэхжүүлэх нь орон нутгийн болон үндэсний зах зээлд түлхэц болж, улмаар зохистой хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгож (ТХЗ 8-ын 8.3, 8.5 дахь зорилтууд) орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжинэ. Орон нутагт үйлдвэрлэсэн барааны худалдаанд давуу эрх олгохыг дэмжсэн соёлын бодлого нь улс орнуудын дотор болон улс хоорондын тэгш бус байдлыг бууруулах ТХЗ 10-д мөн хувь нэмэр оруулна. Соёл нь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад ч хувь нэмэр оруулна. Учир нь соёлын салбарын уламжлалт ажил мэргэжил, гар урлалын ихэнх нь бага түвшний технологи, эрчим хүч, хөрөнгө оруулалт шаарддаг тул тогтвортой амьжиргааг бий болгож, ногоон эдийн засагт хувь нэмэр оруулахад тусалдаг.

Монгол Улсын хувьд Алсын хараа 2050, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван

---

<sup>2</sup>Jyoti Hosagrahar. *Culture: at the heart of SDGs Culture: at the heart of SDGs* (unesco.org)

---

жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт зэрэг урт, дунд хугацааны бодлогод соёлын салбарыг хөгжүүлэх зорилтууд тусгасныг дээр дурдсан. Дэлхийн “Тогтвортой хөгжлийн зорилт 2030”-ын зорилтуудын ойролцоогоор 80 хувь нь Алсын хараа 2050, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээтэй уялдаатай байна гэж дүгнэсэн байдаг. (Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, 2021)<sup>3</sup> Тухайлбал, Тогтвортой хөгжлийн нийт 169 зорилтын 116 зорилт нь Алсын хараа 2050-тай бүрэн уялдаатай, 24 зорилттой нь агуулгаараа уялдаатай, 12 зорилт нь огт тусаагүй, 13 зорилт нь манай оронд шууд хамааралгүй, 4 зорилт нь бүрэн хэрэгжсэн байна гэж дүгнэсэн. Харин Тогтвортой хөгжлийн зорилгын 244 шалгуур үзүүлэлтийн 20 шалгуур үзүүлэлтийг буюу дөнгөж 8% нь манай хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд ашиглагдсан байна.

НҮБ-аас Монгол Улсад 2023-2027 онд хэрэгжүүлэх тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээг тодорхойлсон баримт бичгийн Стратегийн тэргүүлэх чиглэл 2-т “Ногоон, хүртээмжтэй, тогтвортой өсөлт”-ийн зорилтыг дэвшүүлсэн. Соёлын яам “Ногоон, хүртээмжтэй, тогтвортой өсөлт”-ийг хэрэгжүүлэхэд тогтвортой соёлын үйлчилгээ, бүтээлч үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийг төрөлжсөн, шинэлэг, бүтээмжтэй болгох чиглэлээр гол түнш байгууллагаар хамтран ажиллахаар болсон байна. Засгийн газар соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, 2030 он гэхэд соёлын салбарын үйлдвэрлэлийг ДНБ-ий 4 хувьд хүргэх зорилт тавьсан<sup>4</sup>. Энэ хүрээнд соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээг соёлын өв, утга зохиол, ном хэвлэл, дүрслэх урлаг, дуу, хөгжим, тайзны урлаг, кино, дуу дүрсний урлаг, хэвлэл мэдээлэл, хувцас загвар, архитектур, дизайн, дижитал контент, тоглоом хөгжүүлэлт, маркетинг, зар сурталчилгаа гэсэн үндсэн чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

### 3. СОЁЛЫН САЛБАРЫН ИНСТИТУЦ


#### 3.1. Соёлын салбарын байгууллагын тогтолцоо

Соёлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Соёлын үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо нь Засгийн газар, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, соёлын байгууллагын удирдлагаас бүрдэнэ.” гэж заасан байна.

Монгол Улс ардчилсан Үндсэн хуулиа 1992 онд батлан УИХ-ын сонгуулиа явуулж, Засгийн газрын бүтцийг шинэчлэн зохион байгуулсан. 1992-1996 оны Засгийн газрын бүтцэд Соёлын яамыг шинээр байгуулсан боловч 1996 онд Засгийн газар солигдох үед соёлын салбарын асуудлыг боловсролын сайдын эрхлэх хүрээний асуудалд нэгтгэн Гэгээрлийн яам байгуулагдсан. 2000-2012 онд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам болж яамны нэр өөрчлөгдсөн. 2012 онд шинээр байгуулагдсан Засгийн газрын бүтцэд Соёл, спорт, аялал жуулчлалын яамыг байгуулсан боловч 2014 онд татан буулдаж боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэсэн. Харин 2020 онд байгуулагдсан Засгийн газар нь бүтцэд бие даасан Соёлын яамтай байх хуулийг УИХ-аас баталсан. Одоо Соёлын яам, түүний харьяанд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газар ажиллаж байна.


Соёлын салбарт төрийн өмчийн 8 театр, чуулга, 12 музей, 2 номын сан, орон нутгийн өмчийн 26 театр, чуулга, 25 музей, 24 номын сан, 344 соёлын төв (өргөө, ордон) үйл ажиллагаа явуулж, 2022 оны эцсийн байдлаар 7305 ажилтан ажиллаж байна. /Зураг 1/

Зураг 1. Соёлын салбарын байгууллагууд



Засгийн газрын 2021 оны 300 дугаар тогтоолоор баталсан “Соёлын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн дагуу Соёлын яам нь Стратеги, бодлого, төлөвлөлтийн газар (Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацын хэлтэс, Цахим бодлого, мэдээллийн технологийн хэлтэстэй), Төрийн захиргааны удирдлагын газар (Хууль эрх зүйн хэлтэс, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэстэй), Соёлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Урлаг уран бүтээлийн хэрэгжилтийг зохицуулах газар, Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Хөрөнгө оруулалтын хэлтэстэй), Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Салбарын хяналтын газар (ЗГ-ийн 2022 оны 469 дүгээр тогтоолоор нэмсэн), Соёлын харилцаа, гадаад хамтын ажиллагааны газар (мэдээлэл, сурталчилгааны хэлтэстэй), (ЗГ-ийн 2023 оны 121 дүгээр тогтоолоор нэмсэн) гэсэн зохион байгуулалтын бүтэцтэй, 95 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 2. Соёлын яамны бүтэц




Яамны дэргэд орон тооны бус Сайдын зөвлөл, Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийг Засгийн газрын тухай хууль болон Яамны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу тус тус ажилладаг.

Хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газар нь Захиргааны хэлтэс, Соёл, соёлын өвийн хэлтэс, Урлаг уран бүтээлийн хэлтэс гэсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжтэй 17 орон тоотойгоор Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд соёл, урлагийн салбарын бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тайлагнах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг байна.

### 3.2. Соёлын салбарт ажиллагчид

Соёлын яам, түүний харьяа байгууллагууд болон төрийн болон орон нутгийн өмчийн, өмчийн бусад хэлбэрийн театр, чуулга, цирк, музей, номын сан, соёлын төв, ордон, киноны байгууллага болон бусад соёл, урлагийн байгууллагад 2022 онд 7305 хүн ажиллаж байгаа нь 2012 оныхоос 7%-аар өссөн үзүүлэлт байна. /Зураг 3/


Зураг 3. Соёл, урлагийн байгууллагын ажилтнуудын тоо, 2012-2022 он



Эх сурвалж: [www.opendata.gov.mn](http://www.opendata.gov.mn), 2023

2022 оны байдлаар соёлын салбарт ажиллагчдын 3 хувь нь яам, агентлагт, мөн 3 хувь нь аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газарт, 36 хувь нь мэргэжлийн урлагийн байгууллагад (театр, чуулга, цирк), 33 хувь нь сумын төвийн соёлын төв, ордонд, 11 хувь нь музейн байгууллагад, 7 хувь нь номын санд, 8 хувь нь киноны байгууллагад тус тус ажиллаж байна. /Зураг 4/

Зураг 4. Соёл, урлагийн байгууллагын ажиллагчдын тоо, 2022 он



Эх сурвалж: Соёлын яам, 2023

2012-2022 онд соёлын байгууллагууд 6,845-7,305 ажилтантай байснаас 54-56 хувь нь эмэгтэйчүүд буюу ажиллагчдын хүйсийн харьцаа ойролцоо байна. Нийт ажиллагчдын 35-40 хувь нь театр, чуулга, циркийн урлагийн байгууллагад, 33-38 хувь нь соёлын төвд буюу салбарын 3 ажилтны 1 нь театр, чуулгад, 1 нь сумын соёлын төвд ажиллаж байна гэсэн үг юм.

**Хүснэгт 6. Соёлын байгууллагад ажиллагчдын тоо, байгууллагын төрлөөр**


Байгууллага	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Бүгд	6,845	6,845	6,845	6,845	6,845	6,845	6,845	6,845	6,845	6,845	6,845
Эмэгтэй	3,699	3,699	3,699	3,699	3,699	3,699	3,699	3,699	3,699	3,699	3,699
Театр, чуулга, цирк	2,800	2,800	2,800	2,800	2,800	2,800	2,800	2,800	2,800	2,800	2,800
Музей	646	646	646	646	646	646	646	646	646	646	646
Номын сан	515	515	515	515	515	515	515	515	515	515	515
Соёлын төв (ордон)	2,602	2,602	2,602	2,602	2,602	2,602	2,602	2,602	2,602	2,602	2,602
Киноны байгууллага	282	282	282	282	282	282	282	282	282	282	282
Бусад							56	74	203	356	443

Эх сурвалж: [opendata.gov.mn](http://opendata.gov.mn), 2023

2012 оноос хойш салбарын ажиллагчдын тоо харьцангуй тогтвортой байжээ. Музей болон киноны байгууллагын ажилтнуудын тоо нэмэгдсэн боловч театр чуулга, соёлын төвүүдийн ажилтны тоо буурсан байна. Бусад байгууллага гэсэн ангилалд Соёлын яам, агентлаг болон аймаг, нийслэлийн Соёл урлагийн газар, соёлын хүрээлэнгүүд, хамгаалалтын захиргаа, Кино урлагийн зөвлөл зэрэг шинээр байгуулагдсан байгууллагын ажилтнууд орж байна. Хэрэв шинээр нэмэгдсэн захиргааны ажилтнуудыг хасаж тооцвол, соёлын салбарт ажиллагчдын тоо 2022 онд 6,871 хүн болж 2012 оныхоос 0.4 хувиар буюу зөвхөн 26 хүнээр нэмэгдсэн байна.

Түүнчлэн 2022 оны байдлаар, соёлын үйлчилгээний байгууллагад ажиллагчдын 52% нь мэргэжлийн ажилтнууд байна /Зураг 5/.

**Зураг 5. Соёлын байгууллагын ажилтны орон тоо, 2022 он**




Эх сурвалж: Соёлын яам, 2023



Соёлын байгууллагад ажилтнуудыг боловсролын түвшнээр зураг 6-д харуулав. 2022 оны байдлаар соёлын үйлчилгээний байгууллагын ажилтнуудын 7 хувь нь магистр ба түүнээс дээш, 56.3 хувь нь бакалавр ба дипломын, 9.8 хувь нь тусгай дунд, 24.1 хувь нь бүрэн дунд болон мэргэжлийн боловсролтой байна.


Зураг 6. Соёлын байгууллагын ажилтнууд боловсролын түвшнээр, эзлэх хувиар



Эх сурвалж: Соёлын яам, 2023

ҮСХ-ноос гаргасан эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалд соёлын салбар гэсэн ангилал байхгүй учраас “урлаг, үзвэр, тоглоом, наадмын үйл ажиллагаа” гэсэн эдийн засгийн үйл ажиллагааг соёлын салбартай дүйцүүлэн авч үзэв. ҮСХ-ноос мэдээлснээр 2022 оны эцэст нийт ажиллагчдын тоо 1,180.5 мянган хүн, үүнээс урлаг, үзвэр, тоглоом, наадмын үйл ажиллагааны салбарт ажиллагчдын тоо 14.1 мянга байгаа нь нийт ажиллагчдын 1.2 хувь болж байна. Уг үзүүлэлтийг бусад орны соёлын салбарт ажиллагчдын эзлэх хувьтай харьцуулан зураг 7-д харуулав.

Зураг 7. Соёлын салбарт хөдөлмөр эрхлэгчдийн нийт ажиллагчдын тоонд эзлэх хувь




Эх сурвалж: (BOP Consulting, 2021)/ҮСХ

Дэлхийн 50 орны соёлын салбарт ажиллагчдын тоог харьцуулсан тооцооллыг ЮНЕСКО-оос 2014 онд гаргасан бөгөөд соёл, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбар нь дэлхийн ДНБ-ий 3.1%, нийт ажил эрхлэлтийн 6.2% -ийг бүрдүүлдэг гэж тооцжээ (UNESCO, 2022). Манай улсын хувьд соёлын салбарт хөдөлмөр

эрхлэгчдийн тоо цөөн байгаа нь соёлын салбар эдийн засгийн эргэлтэд ороогүй, соёлын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ бага эрхэлдэгтэй холбоотой юм. Харин 2022 оны статистикаар соёлын салбарын байгууллагуудын ажилтны 48%-76% нь эмэгтэй ажилтнууд байна. Дунджаар салбарын ажилтны олонх буюу 56% нь эмэгтэй ажилтнууд байна. /Зураг 8/

Зураг 8. Соёлын салбарын ажилтнуудын тоо, хүйсээр 2022 он



Эх сурвалж: [opendata.gov.mn](https://opendata.gov.mn), 2022

Соёлын салбарт ажиллагчдын олонх нь эмэгтэйчүүд боловч удирдах албан тушаалтны хэдэн хувь нь эмэгтэй ажилтнууд болох тухай мэдээллийг Соёл урлагийн газарт манайд байхгүй байна. “Олон улсын урлагийн зөвлөл, соёлын агентлагуудын холбоо” (IFACCA) байгууллагын тайланд дурдсанаар улс орнуудын соёл, урлагийн байгууллагуудын удирдах албан тушаалтны хүйсийн харьцааг 2017 ба 2020 оноор харьцуулахад эмэгтэй удирдах албан тушаалтны эзлэх хувь нэмэгдэж буй боловч удирдах албан тушаалтны ихэнх нь эрэгтэйчүүд (58%) хэвээр байна. (International Federation of Coalitions for Cultural Diversity, 2021) /Хүснэгт 7/

Хүснэгт 7. Үндэсний урлаг, соёлын удирдах албан тушаалтны хүйсийн харьцаа

Бүс нутаг	Он	Эм	Эр
<b>Дэлхийн дундаж</b>	<b>2017</b>	<b>2017</b>	<b>2017</b>
	<b>2020</b>	<b>2020</b>	<b>2020</b>
Баруун Европ болон хойд Америкийн улсууд	2017	2017	2017
	2020	2020	2020
Зүүн Европын улсууд	2017	2017	2017
	2020	2020	2020
Латин Америкийн болон Карибын тэнгисийн улсууд	2017	2017	2017
	2020	2020	2020
Ази, Номхон далайн бүс улсууд	2017	2017	2017
	2020	2020	2020
Африкийн улсууд	2017	2017	2017
	2020	2020	2020
Арабын улсууд	2017	2017	2017
	2020	2020	2020

Эх сурвалж: (International Federation of Coalitions for Cultural Diversity, 2021) (BOP Consulting, 2021)

## 4. СОЁЛЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН МАКРО ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Соёлын салбарын зарлагын макро үзүүлэлтийг 2012-2022 оноор салбарын батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн нийт дүнгээр үзүүлэв.<sup>5</sup>

Соёлын салбар нь тайлант хугацаанд гурван Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд төсөв нь батлагдаж, төсвийн зарцуулалтын гүйцэтгэлээ тайлагнаж ирсэн байна. Тухайлбал, спорт, аялал жуулчлал, боловсрол, шинжлэх ухаан гэсэн салбаруудтай хамт нэг төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарагдаж байжээ. Соёлын салбарын асуудал ихэвчлэн Боловсрол, шинжлэх ухааны яаманд харьяалагдаж байсан бол УИХ-ын сонгуулийн зарим мөчлөгт бие даасан яаманд харьяалагдаж байсныг энэ тайлангийн өмнөх хэсэгт дурдсан билээ.

### Хүснэгт 8. Харьяалах Төсвийн ерөнхийлөн захирагч

Харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч	Он
Соёл, спорт, аялал жуулчлалын сайд /ССАЖЯ/	2012-2014
Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд /БСШУЯ/	2015-2020
Соёлын сайд /Соёлын яам/	2020 оноос хойш

Соёлын салбарын батлагдсан төсвийн гүйцэтгэлийн ерөнхий чиг хандлагыг ДНБ-д болон улсын төсвийн гүйцэтгэлд харьцуулан дүн шинжилгээ хийв. Соёлын салбарын батлагдсан төсвийн гүйцэтгэл 2012 онд 93.2 тэрбум төгрөг байсан бол 2022 онд гүйцэтгэл 174.0 тэрбум төгрөг болж 86.8 хувиар өссөн байна. Салбарын төсвийн зарлагыг ДНБ-тэй харьцуулахад 2012 онд 0.6 хувь байсан бол 2022 онд 0.3 хувь болж 0.3 нэгжээр буурсан байна. /Зураг 9/ Салбарын зарлагын ДНБ-тэй харьцуулсан харьцаа буурсан шалтгаан нь тухайн хугацаанд ДНБ нэрлэсэн үнээр 16.7 их наядаас 54.9 их наяд болж 3.3 дахин өссөн байна.

Салбарын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувийн ерөнхий хандлага сөрөг, маш бага бууралттай /бууралтын коэффициент -0.0003/байна.

<sup>5</sup>Тооцоололд ашигласан санхүүгийн тоо мэдээг СЯ-ны төсвийн фискал систем болон Төрийн сангийн газраас тус тус авсан болно.

**Зураг 9. Салбарын төсвийн зарлагын ДНБ ба улсын нэгдсэн төсөвт эзлэх хувь /тэрбум төг./**




Эх сурвалж: СЯ, Төсвийн зарлагын гүйцэтгэлийн мэдээ 2012-2022/УСХ, www.1212.mn

Салбарын төсвийн зарлагын гүйцэтгэлийг улсын нэгдсэн төсвийн зарлагатай харьцуулахад 2012 онд 1.5 хувь байсан бол 2022 онд 1.0 хувь болж 0.5 нэгжээр буурсан байна. Харин төсвийн зарлагын гүйцэтгэл 2012 оныхтой харьцуулахад 2022 онд 86.8 хувиар өссөн байна. Соёлын салбарын зарлагын улсын нэгдсэн төсвийн зарлагад эзлэх хувийн буурсан шалтгаан нь тухайн хугацаанд улсын нэгдсэн төсвийн зардал 6.0 их наядаас 18.2 их наяд болж 3 дахин огцом өссөнтэй холбоотой байна. Салбарын зарлагын улсын төсвийн гүйцэтгэлд эзлэх хувийн ерөнхий хандлага сөрөг, маш бага бууралттай /бууралтын коэффициент -0.0012/ байна.

Монгол Улсын хувьд соёлын салбарт төрөөс зарцуулж байгаа зардлын ДНБ-нд эзлэх хувь хэмжээ хөгжиж буй улс орнуудынхтай ойролцоо боловч хөгжингүй улс орнууд болон дэлхийн дунджаас ойролцоогоор 2 дахин бага байна.

**Зураг 10. “Соёлын үйлчилгээ”, “нэвтрүүлэх, түгээх үйлчилгээ”-нд улсын төсвөөс зарцуулсан зардлын ДНБ-д эзлэх хувь**




Эх сурвалж: (UNESCO, 2022)/BOP Consulting (2021)

## 5. СОЁЛЫН САЛБАРЫН ТӨСВИЙН НАЙДВАРТАЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Соёлын салбарын төсвийн зарлагын гүйцэтгэл 2012 онд 93.2 тэрбум төгрөг байсан бол 2022 онд 174.0 тэрбум төгрөг болж 86.8 хувиар нэмэгдэн төсвийн зарлага жилд дунджаар 8.4 хувиар өсөж байжээ.

Салбарын батлагдсан төсөв ба төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийг харьцуулан зураг 11-д харуулав. 2012-2022 оны 11 жилийн хугацаанд салбарын батлагдсан төсвийг тухайн жилд нь бүрэн зарцуулдаггүй бөгөөд төсвөөс дутуу зарцуулагдсан хэсгийг доорх зурагт цэнхрээр будаж дүрслэв.



Эх сурвалж: СЯ, Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2012-2022.

Төсвийг зөв төлөвлөж, батлагдсан төсвийг зөв удирдан гүйцэд зарцуулан төсвийн найдвартай, нийцтэй байдлыг хангах нь татвар төлөгчдийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж байгааг илтгэх шалгуур болдог.

“Төсвийн найдвартай байдал” нь төсөв бодитой бөгөөд зориулалтын дагуу зарцуулагдсан эсэхийг илэрхийлдэг. Төсвийн найдвартай байдлыг үнэлэхэд төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл (төсөв, санхүүгийн удирдлагын системийн шууд үр дүн)-ийг анх батлагдсан төсөвтэй харьцуулж гарсан зөрүүг тооцоолно. Соёлын салбарын төсвийн найдвартай байдлыг үнэлэхдээ нийт зарлагын гүйцэтгэл, зарлагын гүйцэтгэлийг зардлын ангиллаар, орлогын гүйцэтгэлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийлээ.

### 5.1. Нийт зарлагын гүйцэтгэл

Соёлын салбарын зарлагын гүйцэтгэл, түүний өөрчлөлтийн хувийг 2012-2022 оноор гаргаж зураг 12-д харуулав. Салбарын төсвийн зарлагын гүйцэтгэл нэрлэсэн үнээр 2012-2022 онд жилд дунджаар 8.4%-аар өссөн байна. Энэ хугацаанд салбарын зарлагын гүйцэтгэл нь батлагдсан төсвийн хэлбэлзлээс шалтгаалан мөн хэлбэлзэл ихтэй  $/SD=39.9, R^2=0.2812/$  байна. Гэхдээ ерөнхий хандлага эерэг,

өсөлттэй /өсөлтийн коэффициент 0.0375/ байна. Зарлагын гүйцэтгэл 2012-2019 онд харьцангуй тогтвортой байсан бол 2020 онд 2019 оныхтой харьцуулахад 113.5 хувийн огцом өсөлттэй, 2022 оны өсөлт 2021 онтой харьцуулахад 32.3 хувийн өсөлттэй байна.

**Зураг 12. Төсвийн зарлагын гүйцэтгэл, жилийн өсөлтийн хувь /тэрбум төг./**



Өнгөрсөн 11 жилийн хугацаанд батлагдсан төсвийн гүйцэтгэлийн хувь 2020 онд хамгийн бага буюу 71.6% байсан бол 2022 онд гүйцэтгэлийн хувь хамгийн өндөр буюу 98.1% байжээ. Соёлын салбарын төсвийн гүйцэтгэл 2020 онд муу байсан нь дэлхий нийтийг хамарсан Ковид 19 цар тахлын үеийн хөл хорионы нөхцөл байдалтай холбоотой байна. Энэ хандлага дэлхий дахинд тохиолдож 2020 онд соёл, соёлын бүтээлч салбарын дэлхийн нийт нэмүү өртөг 750 тэрбум ам.доллараар буурч, дор хаяж 10 сая ажлын байраа алдсан гэсэн тооцооллыг ЮНЕСКО-гоос гаргасан. (UNESCO, 2022). Түүнчлэн улс орнуудын соёл, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн орлого 2020 онд 20-40%-аар буурч, соёл урлаг, бүтээлч салбарууд эдийн засгийн бусад салбаруудтай харьцуулахад муу ажиллаж, урд өмнө нь тохиолдсон хямралуудын үеийнхээс илүү их хохирол амссан байна.

Соёлын салбарын 2012-2022 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийг батлагдсан нийт төсөвтэй хүснэгт 9-д харуулав.

**Хүснэгт 9. Нийт зарлагын батлагдсан төсөв ба гүйцэтгэл**

Он	Батлагдсан төсөв /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Зөрүү /мян. төг/	Гүйцэтгэлийг төсөвт харьцуулсан хувь
2012	101,996,792.9	93,183,341.1	-8,813,451.8	91.4%
2013	84,992,169.1	74,076,637.8	-10,915,531.3	87.2%
2014	101,954,079.7	90,604,393.5	-11,349,686.2	88.9%
2015	83,090,889.4	70,483,759.3	-12,607,130.1	84.8%
2016	82,915,940.4	78,121,068.4	-4,794,872.0	94.2%
2017	72,147,090.8	69,441,391.8	-2,705,699.0	96.2%
2018	97,898,542.3	94,250,909.5	-3,647,632.8	96.3%
2019	105,267,826.8	100,565,743.7	-4,702,083.1	95.5%
2020	180,810,757.3	129,486,577.7	-51,324,179.6	71.6%
2021	138,088,952.6	131,555,206.2	-6,533,746.4	95.3%
2022	177,373,671.6	174,028,646.4	-3,345,025.2	98.1%

Салбарын нийт зарлагын гүйцэтгэл 2020 онд 71.6%, 2021 онд 95.3%, 2022 онд 98.1% тус тус байсан буюу сүүлийн 3 жилээс 2 жилд нь буюу 2021, 2022 онд гүйцэтгэл 95%-аас дээш гарсан байна.

## 5.2. Төсвийн зарлагын гүйцэтгэл, зардлын ангиллаар

Төсвийн зарлагын гүйцэтгэлийн явцад төсвийн зардлын ангилал хооронд дахин хуваарилалт хийсэн нь батлагдсан төсвийн бүрэлдэхүүнд нөлөөлсөн байдлыг тодорхойлох зорилгоор нийт зарлагын баталсан төсөв ба гүйцэтгэлийн зөрүүг байгууллагын төрөл, эдийн засгийн засгийн ангиллаар 2020-2022 оноор тооцож дараах хүснэгт 10-12-д харуулав.

Хүснэгт 10. Зарлагын төсвийн гүйцэтгэл, байгууллагаар, 2020 он

Хөтөлбөрийн нэр, код	Батлагдсан төсөв /сая төг./	Гүйцэтгэл /сая төг./	Тохируулсан төсөв /сая төг./	Зөрүү	Зөрүүний абсолют утга	Хувиар
Төрийн өмчит музейнүүд	4,283.4	3,941.0	3,067.5	873.4	873.4	28.5%
Үндэсний төв номын сан,	2,626.7	2,191.2	1,881.1	310.2	310.2	16.5%
Хүүхдийн номын ордон						
Уран зургийн галерей	381.7	360.1	273.3	86.7	86.7	31.7%
Улсын дуурь бүжгийн эрдмийн театр	4,536.4	4,290.8	3,248.7	1,042.1	1,042.1	32.1%
Улсын драмын эрдмийн театр	2,147.8	2,053.2	1,538.2	515.0	515.0	33.5%
Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга	3,134.0	3,096.6	2,244.4	852.2	852.2	38.0%
Улсын хүүхэлдэйн театр	560.3	426.7	401.2	25.5	25.5	6.3%
Хүүхэд залуучуудын театр	-	-	0.0	0.0	0.0	
Улсын филармони	2,410.6	2,407.7	1,726.4	681.3	681.3	39.5%
Соёлын өвийн төв	698.7	581.6	500.4	81.2	81.2	16.2%
Дэлхийн Өв Орхоны соёлын дурсгалт газар	313.6	310.8	224.6	86.2	86.2	38.4%
Нүүдлийн соёл иргэншлийг судлах ОУ-ын хүрээлэн	162.7	161.7	116.5	45.2	45.2	38.8%
Монгол Алтай хадны ЗЦХЗ	133.4	-	95.5	-95.5	95.5	100.0%
Бурхан халдун уул ТХГХЗ	149.8	118.0	107.3	10.7	10.7	10.0%
Чингис хааны өв соёлын хүрээлэн	852.4	720.3	610.5	109.9	109.9	18.0%
Соёлын яам болон Соёлын сайдын шууд зардал	3,218.6	2,622.5	2,305.0	317.5	317.5	13.8%
Соёлын сайдын Хөрөнгө оруулалт	144,335.8	105,453.6	103,365.2	2,088.4	2,088.4	2.0%
Соёл, урлаг хөгжүүлэх сан	30.0	30.0	21.5	8.5	8.5	39.6%
Кино урлагийг дэмжих сан	10,000.0	-	7,161.4	-7,161.4	7,161.4	100.0%
Соёл урлагийн газар (СУГ), аймаг нийслэлийн СУГ	834.8	720.8	597.8	123.0	123.0	20.6%
Орон нутгийн соёлын байгууллагуудын гүйцэтгэлээр олгох санхүүжилт	0	0	0.0	0.0	0.0	
<b>Нийт зарлага</b>	<b>180,810.8</b>	<b>129,486.6</b>	<b>129,486.6</b>		<b>14,513.9</b>	
<b>Жилийн дундаж зөрүүний хувь</b>						<b>32.8%</b>
<b>Нийт зөрүүний нийт зарлагад эзлэх хувь</b>						<b>11.2%</b>

Хүснэгт 11. Зарлагын төсвийн гүйцэтгэл, байгууллагаар, 2021 он

Хөтөлбөрийн нэр, код	Батлагдсан төсөв /сая төг./	Гүйцэтгэл /сая төг./	Тохируулсан төсөв /сая төг./	Зөрүү	Зөрүүний абсолют утга	Хувиар
Төрийн өмчит музейнүүд	6,219.0	5,836.4	5,859.7	-23.3	23.3	0.4%
Үндэсний төв номын сан, Хүүхдийн номын ордон	2,662.1	2,289.2	2,508.3	-219.0	219.0	8.7%
Уран зургийн галерей	366.1	332.2	344.9	-12.8	12.8	3.7%
Улсын дуурь бүжгийн эрдмийн театр	4,431.8	4,084.7	4,175.7	-91.0	91.0	2.2%
Улсын драмын эрдмийн театр	2,140.5	1,953.3	2,016.8	-63.5	63.5	3.1%
Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга	3,019.3	2,977.1	2,844.8	132.3	132.3	4.7%
Улсын хүүхэлдэйн театр	500.1	454.2	471.2	-17.0	17.0	3.6%
Хүүхэд залуучуудын театр	0.0	0.0	0.0	0.0	0.0	
Улсын филармони	2,376.4	2,358.1	2,239.1	119.0	119.0	5.3%
Соёлын өвийн төв	695.8	658.1	655.6	2.5	2.5	0.4%
Дэлхийн Өв Орхоны соёлын дурсгалт газар	301.6	283.8	284.2	-0.4	0.4	0.1%
Нүүдлийн соёл иргэншлийг судлах ОУ-ын хүрээлэн	156.7	156.7	147.6	9.1	9.1	6.1%
Монгол Алтай хадны ЗЦХЗБ	194.5	148.5	183.3	-34.8	34.8	19.0%
Бурхан халдун уул ТХТГНХЗ	239.6	232.0	225.8	6.2	6.2	2.8%
Чингис хааны өв соёлын хүрээлэн	834.3	654.0	786.1	-132.1	132.1	16.8%
Соёлын яам болон Соёлын сайдын шууд зардал	18,551.6	15,657.8	17,479.7	-1,821.8	1,821.8	10.4%
Соёлын сайдын Хөрөнгө оруулалт	92,839.1	89,725.3	87,474.9	2,250.4	2,250.4	2.6%
Соёл, урлаг хөгжүүлэх сан	1,846.0	1,840.2	1,739.3	100.9	100.9	5.8%
Кино урлагийг дэмжих сан	0.0	0.0	0.0	0.0	0.0	0%
Соёл урлагийн газар (СУГ), аймаг нийслэлийн СУГ	714.5	468.5	673.2	-204.7	204.7	30.4%
Орон нутгийн соёлын байгууллагуудын гүйцэтгэлээр олгох санхүүжилт	0.0	0.0	0.0	0.0	0.0	
Болзошгүй зардал		1,444.98 <sup>6</sup>				
<b>Нийт зарлага</b>	<b>138,088.9</b>	<b>131,555.2</b>	<b>130,110.2</b>		<b>5,240.8</b>	
<b>Зөрүүний жилийн дундаж хувь</b>						<b>7.0%</b>
<b>Нийт зөрүүний нийт зарлагад эзлэх хувь</b>						<b>4.0%</b>



Хүснэгт 12. Зарлагын төсвийн гүйцэтгэл, байгууллагаар, 2022 он

Хөтөлбөрийн нэр, код	Батлагдсан төсөв /сая төг./	Гүйцэтгэл /сая төг./	Тохируулсан төсөв /сая төг./	Зөрүү	Зөрүүний абсолют утга	Хувиар
Төрийн өмчит музейнүүд	6,970.0	6,815.4	6,838.5	-23.1	23.1	0.3%
Үндэсний төв номын сан, Хүүхдийн номын ордон	2,513.1	2,412.1	2,465.7	-53.6	53.6	2.2%
Уран зургийн галлерей	416.7	404.4	408.8	-4.4	4.4	1.1%
Улсын дуурь бүжгийн эрдмийн театр	4,678.0	4,499.8	4,589.8	-89.9	89.9	2.0%
Улсын драмын эрдмийн театр	2,086.6	1,892.5	2,047.2	-154.7	154.7	7.6%
Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга	3,130.9	3,121.0	3,071.8	49.2	49.2	1.6%
Улсын хүүхэлдэйн театр	525.8	494.8	515.9	-21.1	21.1	4.1%
Хүүхэд залуучуудын театр	285.6	111.0	280.2	-169.3	169.3	60.4%
Улсын филармони	2,538.1	2,519.6	2,490.2	29.4	29.4	1.2%
Соёлын өвийн төв	1,374.8	1,068.8	1,348.8	-280.0	280.0	20.8%
Дэлхийн Өв Орхоны соёлын дурсгалт газар	303.0	297.7	297.3	0.3	0.3	0.1%
Нүүдлийн соёл иргэншлийг судлах ОУ-ын хүрээлэн	212.9	212.8	208.9	3.9	3.9	1.9%
Монгол Алтай хадны ЗЦХЗБ	196.3	175.5	192.6	-17.1	17.1	8.9%
Бурхан халдун уул ТХТГНХЗ	229.6	228.9	225.3	3.6	3.6	1.6%
Чингис хааны өв соёлын хүрээлэн	681.8	538.2	668.9	-130.7	130.7	19.5%
Соёлын яам болон Соёлын сайдын шууд зардал	21,227.9	20,411.7	20,827.5	-415.9	415.9	2.0%
Соёлын сайдын Хөрөнгө оруулалт	62,174.4	62,174.0	61,001.8	1,172.2	1,172.2	1.9%
Соёл, урлаг хөгжүүлэх сан	1,511.1	1,337.4	1,482.6	-145.1	145.1	9.8%
Кино урлагийг дэмжих сан	-	-	0.0	0.0	0	-
Соёл урлагийн газар (СУГ), аймаг нийслэлийн СУГ	5,536.0	4,554.3	5,431.6	-877.3	877.3	16.2%
Орон нутгийн соёлын байгууллагуудын гүйцэтгэлээр олгох санхүүжилт	60,781.3	60,758.7	59,635.1	1,123.6	1,123.6	1.9%
<b>Нийт зарлага</b>	<b>177,373.7</b>	<b>174,028.6</b>	<b>174,028.6</b>		<b>4,764.4</b>	
<b>Зөрүүний жилийн дундаж хувь</b>						<b>8.2%</b>
<b>Нийт зөрүүний нийт зарлагад эзлэх хувь</b>						<b>2.7%</b>

Дээрх хүснэгтүүдээс харахад байгууллагаар баталсан төсвийн гүйцэтгэлийн зөрүүний дундаж хувь байгууллагын хувьд 2020 онд 32.8%, 2021 онд 7%, 2022 онд 8.2% тус тус байжээ. Түүнчлэн батлагдсан төсөв ба гүйцэтгэлийн зөрүүний нийт зарлагад эзлэх хувь 2020 онд 11.2%, 2021 онд 4%, 2022 онд 2.7% тус тус байна. 2020 онд Ковидын нөхцөл байдлын улмаас хөл хорио тогтоосонтой холбоотойгоор соёлын үйлчилгээний байгууллагууд батлагдсан төсвөө гүйцэд зарцуулж чадаагүй байна. Харин 2021, 2022 онд байгууллагуудын төсвийн гүйцэтгэл сайн гаржээ.

Салбарын батлагдсан төсөв ба зарлагын гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллаар хүснэгт 15-д оруулав.

### Хүснэгт 13. Салбарын төсөв ба гүйцэтгэл, ЭЗ-ийн ангиллаар (сая төгрөгөөр)

Код	Зардлын ЭЗ-ийн ангилал	2020		2021		2022	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
	<b>НИЙТ</b>	<b>180,810.8</b>	<b>129,486.6</b>	<b>138,089.0</b>	<b>131,555.2</b>	<b>177,373.7</b>	<b>174,028.6</b>
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	16,807.8	15,600.9	18,681.9	17,326.9	24,966.7	23,116.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,195.5	2,006.4	2,600.9	2,266.8	3,212.9	2,903.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,146.9	983.5	1,197.5	1,118.1	1,504.1	1,391.4
2104	Хангамж, бараа материалын зардал	452.8	421.8	678.1	666.5	638.2	586.1
2105	Нормативт зардал	46.8	46.3	52.5	52.4	39.9	34.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	163.7	65.9	202.8	189.5	474.6	458.6
2107	Томилолт, зочны зардал	7.7	2.8	18.5	14.7	64.9	45.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,275.0	3,646.5	17,896.2	16,481.4	18,091.3	17,513.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,285.4	239.1	2,177.6	2,117.3	3,309.7	3,068.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,093.4	1,019.7	1,744.1	1,596.4	62,897.0	62,738.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.8	0.0	0.8	0.0	58,655.2	58,644.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,092.6	1,019.7	1,743.2	1,596.4	4,241.8	4,093.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	144,335.8	105,453.6	92,839.1	89,725.3	62,174.4	62,174.0
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	180,810.8	129,486.6	138,089.0	131,555.2	177,373.7	174,028.6
31	Улсын төсвөөс санхүүжих	180,810.8	129,486.6	138,089.0	131,554.1	177,373.7	174,025.8

Эх сурвалж: СЯ, Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020-2022.

Эдийн засгийн ангиллаар баталсан төсөв ба гүйцэтгэлийн зөрүүний үзүүлэлтийг тооцохдоо төсвийн эдийн засгийн ангиллыг дараах байдлаар бүлэглэж авч үзлээ. /хүснэгт 14, 15, 16, /

### Хүснэгт 14. Зарлагын төсвийн гүйцэтгэл, ЭЗ-ийн ангиллаар, 2020 он

Зардлын эдийн засгийн ангиллын бүлэг	Батлагдсан төсөв /сая төг./	Гүйцэтгэл /сая төг./	Тохируулсан төсөв /сая төг./	Зөрүү	Зөрүүний абсолют утга	Хувиар
Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, НДШ	19,003.3	17,607.3	13,609.1	3,998.2	3,998.2	29.4%
Бараа үйлчилгээний бусад зардал	16,378.3	5,405.9	11,729.2	-6,323.3	6,323.3	53.9%
Урсгал шилжүүлэг	1,093.4	1,019.7	783.0	236.7	236.7	30.2%
Хөрөнгийн зардал	144,335.8	105,453.6	103,365.2	2,088.4	2,088.4	2.0%
<b>Нийт зарлага</b>	<b>180,810.8</b>	<b>129,486.5</b>	<b>129,486.5</b>		<b>12,646.6</b>	
<b>Зардлын гүйцэтгэлийн зөрүүний хувь, ЭЗ-ийн ангиллаар</b>						<b>9.8%</b>

### Хүснэгт 15. Зарлагын төсвийн гүйцэтгэл, ЭЗ-ийн ангиллаар, 2021 он

Зардлын эдийн засгийн ангиллын бүлэг	Батлагдсан төсөв /сая төг./	Гүйцэтгэл /сая төг./	Тохируулсан төсөв /сая төг./	Зөрүү	Зөрүүний абсолют утга	Хувиар
Цалин хөлс, нэмэгдэл, урамшил, НДШ	21,282.80	19,593.70	20,275.8	-682.1	682.1	3.4%
Бараа үйлчилгээний бусад зардал	22,223.20	20,639.90	21,171.7	-531.8	531.8	2.5%
Урсгал шилжүүлэг	1,744.10	1,596.40	1,661.6	-65.2	65.2	3.9%
Хөрөнгийн зардал	92,839.10	89,725.30	88,446.3	1,279.0	1,279.0	1.4%
<b>Нийт зарлага</b>	<b>138,089.2</b>	<b>131,555.3</b>	<b>131,555.3</b>	<b>0.0</b>	<b>2,558.0</b>	
<b>Зардлын гүйцэтгэлийн зөрүүний хувь, ЭЗ-ийн ангиллаар</b>						<b>1.9%</b>

Хүснэгт 16. Зарлагын төсвийн гүйцэтгэл, ЭЗ-ийн ангиллаар, 2022 он

Зардлын эдийн засгийн ангиллын бүлэг	Батлагдсан төсөв /сая төг./	Гүйцэтгэл /сая төг./	Тохируулсан төсөв /сая төг./	Зөрүү	Зөрүүний абсолют утга	Хувиар
Цалин хөлс, нэмэгдэл, урамшил, НДШ	28,179.60	26,019.80	27,648.2	-1,628.4	1,628.4	5.9%
Бараа үйлчилгээний бусад зардал	24,122.70	23,096.80	23,667.8	-571.0	571.0	2.4%
Урсгал шилжүүлэг	62,897.00	62,738.00	61,710.8	1,027.2	1,027.2	1.7%
Хөрөнгийн зардал	62,174.40	62,174.00	61,001.8	1,172.2	1,172.2	1.9%
<b>Нийт зарлага</b>	<b>177,373.7</b>	<b>174,028.6</b>	<b>174,028.6</b>	<b>0.0</b>	<b>4,398.7</b>	
Зардлын гүйцэтгэлийн зөрүүний хувь, ЭЗ-ийн ангиллаар						2.5%

Салбарын баталсан төсөв ба гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллаар 2020-2022 оноор гаргаж үзэхэд, мөн Ковидын нөлөөллөөр 2020 онд эдийн засгийн ангиллаар баталсан зардлын төсвийн гүйцэтгэл зөрүү ихтэй байна. Эдийн засгийн ангиллаар баталсан төсөв ба зарлагын гүйцэтгэлийн зөрүү 2021, 2022 онд жилд нь 5%-аас бага буюу сайн үзүүлэлттэй байсан байна.

### 5.3. Төсвийн орлогын гүйцэтгэл

Соёлын салбарын үйл ажиллагааг дэмжих, соёлын үйлчилгээг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор 2019 оны төсвийн жилээс эхлэн соёлын салбарын төсвийн байгууллагуудын төсөвт орлогын төсөв батлахгүй байхаар Төсвийн тухай хуулиар зохицуулсан. Ингэснээр соёлын үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллагууд орлого олох тохиолдолд байгууллагын үйл ажиллагааны нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан тухай бүрд нь зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанд зарцуулах эрхтэй болсон.

Сангийн сайдын 2019 оны 74 тоот “Журам шинэчлэн батлах тухай” тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэл тусгах, хяналт тавих журам”-аар төсөвт байгууллага өөрийн орлогыг зарцуулах зардлын төрлийг зохицуулсан байна. Уг журмын дагуу төсвийн байгууллага шинээр болон нэмэлтээр орлого олсон тохиолдолд байгууллагын өр төлбөрөө барагдуулах, ажлын үр дүнг нь харгалзан ажилтнуудад урамшуулал олгох, хэрэв орлого үлдвэл ажилтнуудын нийгмийн хамгааллын зардалд зарцуулж болохоор журамласан байдаг.

Хүснэгт 17. Нийт орлогын гүйцэтгэл, сая төгрөгөөр

Орлогын төрөл	2020	2021	2022
<b>Нийт орлого</b>	<b>1,280.02</b>	<b>2,291.46</b>	<b>14,164.92</b>
Засаг дарга, ЗГ-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан орлого	-	1,444.98	4,459.59
Төсвийн байгууллагын өөрийн нэмэлт орлого	1,236.96	735.57	5,907.62
Дээд шатны төсвийн захирагчийн хөрөнгөнөөс шилжүүлсэн орлого	43.06	110.92	3,797.71

Эх сурвалж: СЯ, Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020-2022

---

Цар тахлын үеийн хөл хорио үргэлжилсэн 2020, 2021 онд соёлын төсөвт байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлого бага байсан бол 2022 онд өсөж, 5.9 тэрбум төгрөгийн орлого олсон байна. Соёлын салбарын төсвийн байгууллагуудад орлогын төсөв баталдаггүй учраас орлогын гүйцэтгэлийн үзүүлэлтийг хэмжих боломжгүй байна.

Соёлын салбарын төсвийн найдвартай байдлыг үнэлэх зорилгоор салбарын нийт төсвийн зарлагын гүйцэтгэл, байгууллагаар болон эдийн засгийн ангиллаар баталсан зардлын төсөв ба гүйцэтгэл, орлогын гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг дээрх хүснэгтүүдэд тооцож үзлээ. Салбарын төсвийн зарлагын гүйцэтгэлийг анх баталсан төсөвтэй нь харьцуулахад сүүлийн 3 жилийн хугацаанд төсвийн найдвартай байдал “сайн” байна. Учир нь байгууллагаар болон эдийн засгийн ангиллаар баталсан салбарын төсвийн дахин хуваарилалт хэвийн түвшинд байгааг илэрхийлж байна. Салбарын батлагдсан төсөв ба гүйцэтгэлийг байгууллагаар, эдийн засгийн ангиллаар үзэхэд хөрөнгө оруулалтын зардлын дутуу гүйцэтгэл нь төсвийн гүйцэтгэлд хамгийн их нөлөө үзүүлж байна.

## 6. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХӨТӨЛБӨР, ЗОРИУЛАЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын хувьд хөтөлбөрт суурилсан төсөвлөлтөд 2013 оноос шилжсэн. Төсвийг хөтөлбөрөөр төлөвлөх нь төсвийн зарлагыг зорилго, үр дүнд чиглүүлэн төлөвлөх, зарцуулалтад хяналт тавих зорилготой юм. Монгол Улсын хувьд ЭЗХАХБ-ууд болон НҮБ-ын Статистикийн хорооноос гаргасан Засгийн газрын чиг үүргийн ангилал (COFOG)<sup>7</sup>-д үндэслэсэн төсвийн хөтөлбөрийн ангиллыг Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар батлан мөрдөж байна. Хөтөлбөр бол гадагшаа чиглэсэн үйлчилгээнүүдийн багц буюу гарц эсхүл нийтлэг үр дагавар бүхий төлбөр шилжүүлгүүд юм. (Robinson, 2013) Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д “хөтөлбөр” гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг хэлнэ гэж заасан байна.

Төсвийн хөрөнгийг зарцуулснаар бий болгох бүтээгдэхүүн, үйлчилгээ буюу гарцуудын нийлбэрээр хөтөлбөрийг тодорхойлох нь илүү үр дүнтэй юм. Тухайн хөтөлбөрийн хүрээнд “үйлдвэрлэх” бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлүүдийг тодорхойлсноор тэдгээрийг ач холбогдлоор нь эрэмбэлэн шаардагдах зардлыг төлөвлөхөд чухал ач холбогдолтой юм. Тухайлбал, соёл урлаг хөтөлбөрийн хүрээнд номын сангийн үйлчилгээ, музейн үйлчилгээ, сонгодог урлагийн үйлчилгээ үзүүлэх тохиолдолд аль үйлчилгээнд тэргүүлэх ач холбогдол өгч илүү төсөв зарцуулах вэ гэдэг төсвийн шийдвэр гаргах боломжтой болно.

Соёлын салбарын төсвийн зарлага нь 2020-2022 онд соёл урлаг хөтөлбөр, шинжлэх ухаан, технологи хөтөлбөр ангилагдаагүй бусад хөтөлбөр гэсэн 3 хөтөлбөрөөр зарцуулагдсан. Ангилагдаагүй бусад хөтөлбөрт хөрөнгө оруулалтын зардлын төсвийг баталдаг бол шинжлэх ухаан, технологи хөтөлбөрт Чингис хааны өв соёлын хүрээлэн, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн гэсэн 2 байгууллагын үндсэн ажиллагааны зардлын төсөв тусгагддаг байна.

COFOG-д (European Union, 2019) тусгасан соёлын үйлчилгээний зарлагын хөтөлбөрийн ангилал болон СЯ-ны ашиглаж буй зарлагын хөтөлбөрийн ангиллыг харьцуулан дараах хүснэгт 18-д харуулав.

Хүснэгт 18. Хөтөлбөрийн ангиллын харьцуулалт

Код	COFOG ангилал	Код	СЯ-ны Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал
<b>708</b>	<b>Амралт, соёл урлаг, шашин</b>	<b>71700</b>	<b>Соёл урлаг, спорт, аялал жуулчлал</b>
7081	Амралт ба спортын үйлчилгээ	71701	Биеийн тамир спорт
7082	Соёл урлагийн үйлчилгээ	71702	Соёл урлаг
7083	Радио телевиз, хэвлэлийн үйлчилгээ	71703	Аялал жуулчлал
7084	Шашны болон бусад хэвлэлийн үйлчилгээ	71704	Соёл урлаг, спорт, аялал жуулчлалын бодлого, удирдлага
7085	Амралт, соёл урлаг, шашны судалгаа шинжилгээ	71705	Соёл урлаг, спорт, аялал жуулчлалын судалгаа шинжилгээ
7086	Амралт, соёл урлаг, шашны бусад		

<sup>7</sup> OECD (2023), *Government at a Glance 2023*. OECD Publishing, Paris. <https://doi.org/10.1787/3d5c5d31-en>

Сангийн сайдын тушаалаар баталсан соёлын салбарын төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал нь олон улсын COFOG хөтөлбөрийн ангилалтай ойролцоо байна. Гэхдээ манай улсын хувьд аялал, жуулчлалын асуудал тодорхой хугацаанд соёлын сайдын эрхлэх хүрээний асуудалд хамаарч байсан тулд аялал, жуулчлалын хөтөлбөрийн ангиллыг оруулсан байна. Түүнчлэн радио телевиз, нэвтрүүлэг дамжуулалт, хэвлэлийн үйлчилгээний зардлын тусдаа хөтөлбөр байдаггүй.

Салбарын төсвийн зарлагын ихэнх хувь нь соёл урлаг хөтөлбөрөөр дамжуулан зарцуулагдаж байна. Салбарын хөрөнгийн зардлын төсвийг 2020, 2021 онд соёл урлаг хөтөлбөрөөс салгаж “ангилагдаагүй бусад” гэсэн хөтөлбөрт тусгаж байжээ. Харин 2022 оны төсвийн жилд соёлын салбарын хөрөнгийн зардлын төсвийг соёл урлаг хөтөлбөрт оруулан баталсан байна. Тухайлбал, 2022 онд соёл урлаг хөтөлбөрийн зарлага 176.5 тэрбум төгрөгөөр, салбарын нийт төсөв 177.4 тэрбум төгрөгөөр тус тус батлагдсан байна. 2022 онд соёл урлаг хөтөлбөрийн зарлагын гүйцэтгэл 173.3 тэрбум төгрөг буюу нийт зарлагын 99.6 хувь, шинжлэх ухааны хөтөлбөрийн зарлагын гүйцэтгэл 751.0 сая төгрөг буюу нийт зарлагын 0.4 хувь тус тус болж байна. /Хүснэгт 19/

#### Хүснэгт 19. Салбарын зарлагын гүйцэтгэл, хөтөлбөрөөр, сая төгрөгөөр

Хөтөлбөрийн нэр, код	2020			2021			2022		
	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
Соёл урлаг (71702)	35,113.8	22,985.7	65.5%	44,258.8	39,619.2	89.5%	176,479.0	173,277.6	98.2%
Шинжлэх ухаан, технологи (71805)	1,361.2	1,047.3	76.9%	991.0	810.7	81.8%	894.7	751.0	83.9%
Ангилагдаагүй бусад /хөрөнгө оруулалт/ (72301)	144,335.8	105,453.6	73.1%	92,839.1	89,725.3	96.6%			
Нийт зарлага	180,810.8	129,486.6	71.6%	138,088.9	131,555.2	95.3%	177,373.7	174,028.6	98.1%

Соёл урлаг хөтөлбөрт салбарын үйл ажиллагааны төсөв бүхэлдээ батлагддаг бөгөөд 2020-2022 онд соёлын салбарын урсгал зардлын 96%-99% нь тус хөтөлбөрт тусгагдсан байна. Соёл урлаг хөтөлбөр нь зардлын 8 зориулалт, 34 арга хэмжээнд ангилагдаж байна. Хөтөлбөрүүдийн зардлын зориулалт, арга хэмжээний ангиллыг доорх хүснэгт 20-д үзүүлэв.

#### Хүснэгт 20. Соёлын салбарын төсвийн зарлагын хөтөлбөр, зардлын зориулалт, арга хэмжээний ангиллаар /сая. төг/

Код	Зардлын зориулалт, арга хэмжээний ангилал	2020 гүйцэтгэл	2021 гүйцэтгэл	2022 гүйцэтгэл
<b>НИЙТ</b>		<b>129,486.6</b>	<b>131,555.2</b>	<b>174,028.6</b>
	<b>СОЁЛ УРЛАГ ХӨТӨЛБӨР, 71702</b>	<b>22,876.5</b>	<b>41,019.2</b>	<b>173,277.6</b>
	<b>Үүнээс: Урсгал зардал</b>			
<b>801000</b>	<b>Үйл ажиллагааны урсгал зардлын ерөнхий зориулалт</b>	<b>20,149.5</b>	<b>22,873.2</b>	<b>29,220.1</b>
801010	Үндсэн үйл ажиллагааны зардал	19,979.6	22,655.9	29,035.1
801030	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	169.9	217.3	185.0
<b>802000</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлын зориулалт</b>	<b>996.6</b>	<b>1,254.5</b>	<b>2,104.6</b>
802050	Мэдээлэл, сурталчилгааны зардал	8.3	22.3	973.1
802140	Уран бүтээл хийлгэх	647.6	678.7	490.8

802150	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	53.0	70.7	76.5
802190	Харуул, хамгаалалтын зардал	166.4	199.9	290.3
802260	Байр ашиглалтын үйлчилгээ	121.4	283.0	273.8
<b>803000</b>	<b>Бараа үйлчилгээний бусад нийтлэг зардлын зориулалт</b>	<b>10.0</b>	<b>40.6</b>	<b>0.0</b>
803120	Сургалт семинар	10.0	40.6	0.0
<b>807000</b>	<b>Нийгмийн халамжийн шилжүүлгийн зориулалт</b>	<b>0.0</b>	<b>846.5</b>	<b>918.8</b>
807040	Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	0.0	846.5	918.8
<b>808000</b>	<b>Бусад шилжүүлгийн зориулалт</b>	<b>850.7</b>	<b>535.9</b>	<b>2,511.2</b>
808020	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	850.7	535.9	2,511.2
<b>815000</b>	<b>Төрийн нийтлэг арга хэмжээ</b>	<b>0.0</b>	<b>494.8</b>	<b>0.0</b>
815630	Цахим бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх	0.0	494.8	0.0
<b>819000</b>	<b>Соёлын арга хэмжээ</b>	<b>869.7</b>	<b>5,824.4</b>	<b>71,158.2</b>
819010	Соёл урлаг хөгжүүлэх	180.4	3,276.9	4,611.9
819050	Музейн үзмэр худалдан авах	57.2	24.5	84.0
819070	Түүхийн хурд баримтат кино бүтээх	45.1	36.0	92.4
819080	Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах	357.7	462.7	1,143.2
819090	Музей, түүх, соёлын өвийн сэргээн засварлалт	1.3	1.1	0.9
819110	Сонгодог урлаг хөтөлбөр	0.0	665.3	0.0
819140	Хөгжмийн шилдэг бүтээлийг улсын санд худалдаж авах	31.2	25.0	42.0
819160	Дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын санд худалдаж авах	27.8	11.3	42.0
819180	Соёл урлагийн олон улсын тэмцээнд тэргүүн байр эзэлсэн уран бүтээлчдийг шагнах	139.0	214.0	154.0
819190	Оны шилдэг уран бүтээлч найруулагч жүжигчин зураач бүжигчдийг шагнах	30.0	0.0	44.9
819220	Гадаад дотоодод зохиогдох соёл урлагийн арга хэмжээ	0.0	215.8	1,600.4
819310	Соёлын баримтат өвийг хамгаалах	0.0	396.0	0.0
819320	Соёлын биет бус өвийг хамгаалах	0.0	185.0	0.0
819330	Чулуун соёлын өв үндэсний хөтөлбөр	0.0	310.8	0.0
819340	Соёлын бүтээлч үйлдвэрлэл	0.0	0.0	1,553.4
819360	Цахим соёл хөтөлбөр	0.0	0.0	1,035.9
819380	Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтанд төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	0.0	464.2
819390	Бүх нийтийн соёлын боловсрол	0.0	0.0	327.7
819410	Соёлын байгууллагад гүйцэтгэлээр олгох санхүүжилт	0.0	0.0	58,644.8
819420	Нүүдлийн өв, соёлыг дэмжих хөтөлбөр	0.0	0.0	168.0
819430	Монголын түүх, соёл, үндэсний урлагийг гадаад, дотоодод түгээн сурталчлах хөтөлбөр	0.0	0.0	308.3
819440	Номын баяр арга хэмжээ	0.0	0.0	840.0
<b>828000</b>	<b>Баяр, наадам, тэмдэглэлт ой</b>	<b>0.0</b>	<b>9,149.3</b>	<b>5,190.6</b>
828100	Түүхэн ой	0.0	9,149.3	5,190.6
<b>809000</b>	<b>Хөрөнгийн зардлын зориулалт</b>			<b>62,174.0</b>
809180	Бусад			62,174.0
	<b>ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ХӨТӨЛБӨР, 71805</b>	<b>1,156.4</b>	<b>810.7</b>	<b>751.0</b>
<b>801000</b>	<b>Үйл ажиллагааны урсгал зардлын ерөнхий зориулалт</b>	<b>882.0</b>	<b>804.5</b>	<b>745.7</b>
801010	Үндсэн үйл ажиллагааны зардал	882.0	804.5	745.7
<b>802000</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зориулалт</b>	<b>0.0</b>	<b>6.2</b>	<b>5.3</b>
802150	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	0.0	6.2	5.3
<b>819000</b>	<b>Соёлын арга хэмжээ</b>	<b>274.4</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
819200	Монгол судлалын үйл ажиллагааг дэмжих	274.4	0.0	0.0
	<b>АНГИЛАГДААГҮЙ БУСАД ХӨТӨЛБӨР, 72301</b>	<b>105,562.7</b>	<b>89,725.3</b>	
<b>809000</b>	<b>Хөрөнгийн зардлын зориулалт</b>			
809180	Бусад	105,562.7	89,725.3	

Эх үүсвэр. Сангийн яам. Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2022.

Соёл урлаг хөтөлбөрийн “үйл ажиллагааны урсгал зардлын ерөнхий зориулалт”-д Соёлын яамны харьяа төрийн өмчит соёлын байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны зардал тусгагддаг бол “соёлын арга хэмжээ” зориулалтад орон нутгийн соёлын байгууллагад гүйцэтгэлээр олгох үндсэн үйл ажиллагааны санхүүжилт болон бусад соёлын үйлчилгээг дэмжих зардлууд тусгагдаж байна.

Соёлын арга хэмжээ гэсэн зориулалтад 14 төрлийн арга хэмжээ нь шинж чанар, хэмжээний хувьд харилцан адилгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээ, гарцын шинжтэй үйл ажиллагаануудын аль алиныг багтаасан байна. 2021 онд соёл урлагийн хөтөлбөрийн зардлын 14% нь соёлын арга хэмжээ зориулалтад тусгагдаж байсан бол 2022 онд 41% болж нэмэгдсэн нь 2022 оноос эхлэн орон нутгийн соёлын байгууллагад гүйцэтгэлээр олгох санхүүжилтийн төсвийг уг арга хэмжээнд батлах болсонтой холбоотой байна.

Соёл урлаг хөтөлбөрт нийгмийн халамжийн шилжүүлгийн зориулалтаар 2021 оноос эхлэн төсөв батлагдаж иржээ. Өмнө нь алдар цолтон ахмад настанд олгох нэмэгдлийн зардлыг нийгмийн халамжийн сангаас хариуцдаг байсан бол тухайн ахмадыг харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч бүр 2021 оноос эхлэн зардлыг хариуцах болсон. Соёлын сайдын төсвийн багцаас урлагийн салбарын хөдөлмөрийн баатар, ардын ба гавьяат цолтон, төрийн шагналт, төрийн соёрхолт ахмад настанд сар бүр олгох 150.0-200.0 мянган төгрөгийн нэмэгдлийг санхүүжүүлэхэд 2021 онд 846.5 сая төгрөг, 2022 онд 918.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Соёл урлаг хөтөлбөрийн соёлын арга хэмжээний зориулалтын зардлын гүйцэтгэлийг 2021, 2022 оноор дараах зураг 13-д харуулав.

**Зураг 13. Соёлын арга хэмжээ, зарлагын төрлөөр, сая төгрөгөөр**



2021, 2022 оны төсвийн гүйцэтгэлээс харахад хамгийн их төсөв зарцуулсан соёлын арга хэмжээ нь түүхэн ой тэмдэглэх, соёл урлагийг хөгжүүлэх болон гадаадад зохиогдох соёлын арга хэмжээнүүд болж байна. Түүнчлэн 2022 оноос эхлэн шинээр хэрэгжүүлсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл, цахим соёл арга хэмжээнд 2.6 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Соёлын салбарын 2023 оны батлагдсан төсвөөс харахад соёлын арга хэмжээний зардлын зориулалтын төсөв нэмэгдэж, соёл урлаг хөгжүүлэх зардалд 4.5 тэрбум төгрөг, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах зардалд 1.1 тэрбум, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн зардалд 1.8 тэрбум, цахим соёл хөтөлбөрт 1.0 тэрбум төгрөгийн төсөв соёлын сайдын шууд дансанд батлагдсан ба сайдын тушаалаар



---

зарцуулагддаг байна. Соёлын сайдын 2023 оны төсвийг зардлын зориулалт арга хэмжээний ангилал, байгууллагаар гаргаж Хавсралт 1-д харуулсан болно.

Салбарын бүх зардлыг үндсэн нэг хөтөлбөр (соёл урлаг)-т тусгаж байгаа нь уг салбараас иргэдэд үзүүлж буй соёлын үйлчилгээний үр дүн, гүйцэтгэлийг гарц, бүтээгдэхүүний төрөлтэй уялдуулан тодорхойлох боломжгүй болгож байна. Эцсийн хэрэглэгч болох иргэд, олон нийтэд театр, чуулгын, сонгодог урлагийн, номын сангийн болон музейн үйлчилгээ, соёлын боловсрол, соёлын өв, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих үйлчилгээг үзүүлэхийн тулд улс, орон нутгийн төсвөөс ямар зориулалт, арга хэмжээнд хөрөнгө зарцуулснаар ямар үр дүн, үр нөлөөг авчирч, төсвийн хөрөнгөний үр ашгийг хангасан бэ гэдгийг тодорхойлж, хянаж байх нь чухал юм. Иймд цаашид соёлын салбарын төсвийг ЗГ-ын дунд хугацаанд дэвшүүлсэн бодлого, чиглэлтэй уялдуулан дараах 4 хөтөлбөрөөр төсвийг төлөвлөж, зарцуулах саналтай байна. Үүнд:

1. Соёл урлаг (театр чуулга, соёлын төв, номын сангийн үйлчилгээ, музейн үйлчилгээ, хөрөнгө оруулалт);
2. Соёлын өв (соёлын биет ба биет бус өвийг хамгаалах, сэргээх, сурталчлах үйлчилгээ, судалгаа);
3. Соёлын бүтээлч үйлдвэрлэл;
4. Соёлын бодлого, удирдлага;

гэсэн зарлагын 4 хөтөлбөрөөр төсвийг төлөвлөж, зарцуулалтад хяналт тавих нь зүйтэй юм.

Түүнчлэн салбарын хөрөнгийн зардлыг нэгтгэн ангилагдаагүй бусад хөтөлбөрийн зардалд дахин тусгалгүй тухайн хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардал нь ямар гарцад чиглэж байгаагаас шалтгаалан холбогдох хөтөлбөрийн зардалд төсвийг тусгуулж байх шаардлагатай байна. Жишээлбэл, соёлын төвийн барилга барих хөрөнгийн зардлыг соёл урлаг хөтөлбөрт тусгах нь зүйтэй юм.

## 7. СОЁЛЫН САЛБАРЫН УРСГАЛ БА ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ЧИГ ХАНДЛАГА, ХУВААРИЛАЛТ


Салбарын урсгал ба хөрөнгийн зардлын гүйцэтгэлийн хэмжээг 2012-2022 оноор гаргаж дараах хүснэгт 21-д харуулав.

Хүснэгт 21. Салбарын урсгал ба хөрөнгийн зардлын гүйцэтгэл, сая төгрөгөөр

	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
<b>Урсгал зардал</b>	50,561.0	53,040.3	55,401.2	53,076.5	56,316.2	59,658.1	62,047.8	20,292.4	24,033.0	41,829.9	111,854.6
<b>Хөрөнгийн зардал</b>	42,622.3	21,036.3	35,203.2	17,407.2	21,804.8	9,783.3	32,203.1	80,273.3	105,453.6	89,725.3	62,174.0

Орон нутгийн соёлын байгууллагуудын үйл ажиллагааны зардалд олгох урсгал шилжүүлэг 2019-2021 онд Соёлын сайдын урсгал зардалд батлагдаагүй учраас эдгээр онуудад урсгал зардал огцом буурсан байна. Түүнчлэн тусдаа Соёлын яамтай байсан 2012-2014, 2020-2022 онуудад хөрөнгийн зардлын хэмжээ өндөр байх хандлагатай байна. Салбарын хөрөнгийн ба урсгал зардлын жилийн өсөлтийг доорх зураг 14-д дүрслэв.

Зураг 14. Урсгал ба хөрөнгийн зардлын жилийн өсөлт, хувиар




Салбарын урсгал зардлын өөрчлөлт нь орон нутгийн соёлын байгууллагуудын төсвийг улсын төсвөөс хариуцах эсэхээс хамаарч хэлбэлзсэн байна. Салбарын урсгал зардлын дундаж өсөлтийн хувь 2012-2018 онд тогтвортой буюу жилд 3.5

хувь байсан бол 2019-2020 онд урсгал зардал огцом буурч, 2021 онд огцом өссөн байна. 2022 онд Соёлын сайдын төсвийн багцад орон нутгийн байгууллагад олгох урсгал шилжүүлэг батлагдах болсноор урсгал зардал 2021 онтой харьцуулахад огцом буюу 167 хувиар өссөн байна. Урсгал зардлын сүүлийн жилүүдийн огцом хэлбэлзлийг оруулан тооцвол, 2012-2022 онд урсгал зардал жилд дунджаар 21.4 хувиар өссөн байна.

Салбарын хөрөнгийн зардал өнгөрсөн 11 жилийн хугацаанд хэлбэлзэл ихтэй байжээ. 2012-2022 оны хөрөнгийн зардлын гүйцэтгэлээс харахад хөрөнгийн зардлын жилийн дундаж өсөлт 30 хувь байна. Хөрөнгийн зардал хамгийн их байсан жил бол Соёлын яам байгуулагдсан 2020 бөгөөд онд 105.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байжээ.

Салбарын 2012-2022 оны нийт төсвийн зарлагын гүйцэтгэлийн дунджаас харахад 57.9 хувь нь урсгал зардал, 42.1 хувь нь хөрөнгийн зардалд зарцуулагджээ. Энэ харьцаа 2012-2022 оны тайлант хугацаанд харьцангуй тогтвортой байгаа боловч урсгал зардал 2019 онд нийт зардлын 34%, 2020 онд 18.2 хувь болж тус тус буурсан нь эдгээр онд салбарын хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардал огцом нэмэгдсэнтэй холбоотой байна. Тухайлбал, хөрөнгө оруулалтын төсвийн санхүүжих дүн 2020 онд 2018 онтой харьцуулахад 126.9 тэрбум төгрөгөөр буюу 829.6%-аар нэмэгдэж батлагдсан байна.

**Зураг 15. Төсвийн нийт зарлагын гүйцэтгэлд урсгал ба хөрөнгийн зардлын эзлэх хувь**




Эх сурвалж: СЯ, Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2012-2022

Түүнчлэн 2012, 2019-2021 онд орон нутгийн соёлын байгууллагуудын төсөв орон нутгийн төсөвт шилжсэн учраас урсгал зардал буурсантай холбогдуулан нийт төсвийн зарлагад хөрөнгийн зардлын эзлэх хувь хэмжээ нэмэгдсэн байна.

Салбарын төсвийн урсгал ба хөрөнгийн зардлын гүйцэтгэлийн батлагдсан төсөвт эзлэх хувийг дараах зураг 16-д харууллаа. 2020-2022 оноос бусад онуудад хөрөнгийн зардлын гүйцэтгэл урсгал зардлын гүйцэтгэлээс доогуур хувьтай буюу жилд дунджаар 84% байжээ. Энэ нь хөрөнгийн зардалд батлагдсан төсвийн 16 орчим хувийг тухайн ондоо зарцуулж чадаагүй гэсэн үг юм .

**Зураг 16. Салбарын урсгал ба хөрөнгийн зардлын төсвийн гүйцэтгэлийн хувь**




Соёлын салбарт 2012-2022 оны хугацаанд нийтдээ 1.2 их наяд төгрөгийн улсын төсөв батлагдсанаас 1.1 их наяд төгрөгийн зарлагыг санхүүжүүлж, зарлагын гүйцэтгэл 90% байжээ. Дутуу зарцуулагдсан төсвийн 25 хувь нь урсгал зардлын төсөв, 75 хувь нь хөрөнгийн зардлын төсөв байгаа нь хөрөнгийн зардлын төсвийн гүйцэтгэлийг сайжруулах шаардлагатайг мөн илэрхийлж байна.

### 7.1. Салбарын нийт төсвийн зарлагын хуваарилалт

Монгол Улсын соёлын салбарын төрийн ба орон нутгийн өмчит соёлын байгууллагуудаас иргэд, олон нийтэд үзүүлдэг үйлчилгээг 1) театр, чуулгын буюу мэргэжлийн урлагийн, 2) музейн, 3) номын сангийн болон 4) соёлын төвийн үйлчилгээ гэж 4 үндсэн бүлэгт хувааж болно.

Салбарын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас харахад дээрх 4 төрлийн үйлчилгээний байгууллагуудад Соёлын сайдын төсвөөс 2022 онд 84,800.2 сая төгрөгийн урсгал зардал олгосон нь Соёлын сайдын урсгал төсвийн зарлагын 74 хувь болсон байна. Түүнчлэн урсгалт төсвийн зарлагын 15 хувийг Соёлын сайдын шууд зардалд болон Соёл урлагийг хөгжүүлэх санд, 11 хувийг яам, агентлаг, бусад захиргааны байгууллагын зардалд зарцуулжээ.

**Зураг 18. Урсгал төсвийн зарлагын хуваарилалт, 2022**



**Зураг 17. Нийт төсвийн зарлагын хуваарилалт, 2022**



Хэрэв хөрөнгийн зардлыг оруулан салбарын нийт төсвийн зарлагын хуваарилалтыг харвал нийт зарлагын 48 хувийг соёлын үйлчилгээний байгууллагад, 36 хувийг хөрөнгө оруулалтад, 10 хувийг Соёлын сайдын шууд зардал болон Соёл урлагийг хөгжүүлэх санд, 7 хувийг яам, агентлаг болон бусад захиргааны байгууллагын үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулсан байна. /Зураг 17/

Харин салбарын төсвийн зарлагын хуваарилалтыг соёлын үйлчилгээний байгууллагуудаар 2022 оноор тооцож үзэхэд улсын төсвөөс олгож байгаа төсвийн хамгийн их буюу 38.7% нь театр, чуулгад, 35.9% нь соёлын төвд, 16.5% нь музейд болон төсвийн 8.9% нь номын санд хуваарилагдаж байна. Соёлын байгууллагад улсын төсвөөс олгосон санхүүжилтийн 75% нь театр, чуулга, соёлын төвд хуваарилагдаж байна. Гэхдээ энд орон нутгийн төсвөөс соёлын байгууллагуудад олгодог санхүүжилтийг оруулаагүй зөвхөн Соёлын сайдын төсвийн багцаас олгож байгаа улсын төсвийн зарлагыг тооцов. /Хүснэгт 22/

**Хүснэгт 22. Соёлын байгууллагуудад улсын төсвөөс олгосон зардал, 2022 оноор, сая төг.**

Соёлын байгууллага (СБ)-ын төрөл	Төрийн өмчит		Орон нутгийн өмчит		Нийт		Нийт дүнд эзлэх хувь
	СБ-ын тоо	Урсгал зардлын гүйцэтгэл	СБ-ын тоо	Урсгал зардлын гүйцэтгэл	СБ-ын тоо	Урсгал зардлын гүйцэтгэл	
<b>Театр, чуулга</b>	6	12,638.7	24	20,147.0	30	32,785.7	<b>38.7%</b>
<b>Музей</b>	14	8,990.7	23	5,026.2	37	14,016.9	<b>16.5%</b>
<b>Номын сан</b>	2	2,412.1	23	5,111.9	25	7,524.0	<b>8.9%</b>
<b>Соёлын төв</b>			333	30,473.5	333	30,473.5	<b>35.9%</b>
<b>Нийт</b>	<b>22</b>	<b>24,041.6</b>	<b>403</b>	<b>60,758.7</b>	<b>425</b>	<b>84,800.2</b>	<b>100.0%</b>

*Эх үүсвэр. Соёлын яам, Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2022.*

Соёл урлагийг дэмжих сан нь ЗГ-ын тусгай сан бөгөөд соёл, урлагийг хөгжүүлэх, сурталчлан таниулах, соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зориулалттай гэж Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан байна. Соёлын сайдын шууд зардал гэдэгт Соёлын яамнаас шууд шийдвэр гаргаж, хариуцан зарцуулдаг зардлууд ордог.

Тухайлбал, бүх нийтийн боловсрол олгох, гадаад, дотоодод соёлын арга хэмжээ зохион байгуулах, монголын түүх, соёл, үндэсний урлагийг гадаад, дотоодод түгээн сурталчлах, нүүдлийн өв, соёлыг дэмжих, олон улсын тэмцээнд тэргүүн байр эзэлсэн уран бүтээлчдийг шагнах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, цахим соёлыг хөгжүүлэх зэрэг зардлууд ордог байна.

Соёлын сайдын 2022 оны шууд зардлын гүйцэтгэлийн бүтцийг дараах хүснэгт 23-т харуулав.

### Хүснэгт 23. Соёлын сайдын шууд зардлын бүтэц


СУДС ба Соёлын сайдын шууд зардлын төрөл	Зардлын гүйцэтгэл /сая төг./	Нийт дүнд эзлэх хувь
1 Соёл урлагийг дэмжих сан	1,337.4	8.0%
2 Бүх нийтийн соёлын боловсрол	327.7	2.0%
3 Гадаад дотоодын соёлын арга хэмжээ	1,600.4	9.6%
4 Түүх, соёлыг сурталчлах	308.3	1.8%
5 Номын баяр	840.0	5.0%
6 Нүүдлийн өв соёл	168.0	1.0%
7 Соёл урлаг хөгжүүлэх	3,266.7	19.5%
8 Уран бүтээлчдийн шагнал	154.0	0.9%
9 Соёлын бүтээлч үйлдвэрлэл	1,553.4	9.3%
10 Түүхийн дурсгалт зүйлийг хамгаалах	946.4	5.7%
11 Түүхэн ой	5,190.6	31.0%
12 Цахим соёл	1,035.9	6.2%
<b>Нийт</b>	<b>16,729.0</b>	<b>100.0%</b>

Соёлын сайд 2022 онд шууд зардлынхаа хамгийн их буюу 31%-ийг түүхэн ойн соёл урлагийн үйл ажиллагаанд зарцуулсан бол цахим соёлыг дэмжихэд зардлынхаа 6.2%, бүх нийтийн соёлын боловсролд зардлынхаа 2%-ийг тус тус зарцуулсан байна. Төсвийн зардлын хуваарилалт нь тухайн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, үр дүнгийн зорилтот түвшнийг хангахад хамгийн үр ашигтай зориулалт, арга хэмжээг ач холбогдлоор эрэмбэлэн зардал хуваарилах зарчмыг баримтлах нь зүйтэй байна.

### 7.2. Салбарын урсгал зардлын бүтэц

2012-2022 оны хугацаанд соёлын салбарын нийт урсгал зардлын дунджаар 53.6%-ийг бараа үйлчилгээний зардал, 46.4%-ийг урсгал шилжүүлэгт зарцуулсан. Бараа үйлчилгээний зардалд соёлын сайдад шууд харьяалагддаг төрийн өмчийн 34 байгууллагын ажилтнуудын цалин хөлс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засвар, томилолтын зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж багтаж байна. Харин урсгал шилжүүлэгт орон нутгийн өмчит 430 гаруй соёлын байгууллагын (сумын соёлын төв, аймгийн театр, музей, номын сан) үйл ажиллагааны төсвийн эх үүсвэр болох тусгай зориулалтын шилжүүлэг багтана. Орон нутгийн өмчит соёлын байгууллагуудын байр ашиглалттай холбоотой түлш, халаалт, гэрэл цахилгааны гэх мэт зардлыг зардлыг тухайн аймгийн орон нутгийн төсвөөс хариуцдаг байна.

Зураг 19. Салбарын урсгал зардлын бүтэц /хувиар/




Орон нутгийн өмчит соёлын байгууллагуудын төсөв 2012, 2019-2021 онуудад соёлын сайдын төсвийн багцад тусгагдалгүй орон нутгийн төсөв шилжсэнтэй холбогдуулан салбарын урсгал зардалд урсгал шилжүүлгийн эзлэх хувь огцом багассан байна. Хэрэв эдгээр онуудыг хасаж тооцвол Соёлын сайд орон нутгийн соёлын байгууллагуудын урсгал зардлыг хариуцах тохиолдолд урсгал төсвийнхөө дийлэнхийг буюу 72 хувийг орон нутгийн өмчит 420 орчим соёлын байгууллагуудын урсгал зардлын санхүүжилтэд нь зарцуулдаг байна. Гэхдээ орон нутгийн соёлын байгууллагуудад олгосон санхүүжилт салбарын нийт урсгал зардалд 2022 онд 56.1%-ийг эзлэх болж буурсан байна. /Зураг 19/ Үүнд нөлөөлсөн гол хүчин зүйл нь соёлын салбарын нийт урсгал зардал нэмэгдэж, сайдын багцаас бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлын төлбөр өссөн нь нөлөөлжээ.

### 7.2.1. Салбарын урсгал зардалд цалин хөлсний зардлын эзлэх харьцаа

Салбарын 2012-2022 оны бараа үйлчилгээний зардалд цалин хөлс, НДШ-ийн зардлын эзлэх хувь дунджаар 67 хувь байжээ. /Зураг 20/ 2021, 2022 онд салбарын бараа, үйлчилгээний зардалд Цалин хөлс, НДШ-ийн зардлын эзлэх хувь буурах хандлагатай байна. Тухайлбал, 2022 онд бараа үйлчилгээний зарлагын 53.0 хувь цалин хөлс, НДШ-ийн зардалд, 47 хувь нь бусад зардалд зарцуулагдсан байна.

Зураг 20. Салбарын бараа үйлчилгээний зардлын бүтэц, хувиар



Соёлын салбарт урсгал зардлынхаа хэдэн хувийг цалин хөлс, НДШ-ийн зардалд зарцуулж байгааг тодорхойлохын тулд бараа үйлчилгээний зардалд эзлэх цалин хөлсний зардлыг авч үзэхээс гадна урсгал шилжүүлэгт багтах цалин хөлс, НДШ-ийн зардлыг мөн тооцоолох хэрэгтэй. Учир нь бараа үйлчилгээний зардалд тусгагдсан цалин хөлсний зардал нь зөвхөн соёлын сайдын шууд харьяанд байдаг төрийн өмчит 22 соёлын байгууллагад (театр, чуулга, музей, номын сан, хүрээлэн г.м) ажиллаж байгаа 1,600 гаруй соёлын ажилтнууд болон Соёлын яам, аймаг, нийслэлийн Соёл урлагийн газар ба харьяа байгууллагын 400 орчим ажилтны цалин хөлсний зардал юм. Соёлын сайдын төсвийн багцаас орон нутгийн өмчит 420 орчим соёлын байгууллагад урсгал шилжүүлэг олгож, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас бусад үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс хариуцаж байна. Өөрөөр хэлбэл, орон нутгийн өмчит сумын соёлын төв, ордон, аймгийн театр, чуулга, музей, номын санд ажиллаж байгаа 4,620 орчим ажилтны цалин хөлс, НДШ-ийн зардал соёлын сайдын төсвийн багцад урсгал шилжүүлгээр тусгагдаж байна. Салбарын урсгал зардалд цалин хөлсний болон НДШ-ийн зардлын эзлэх хувийг 2020-2022 оноор тооцож, хүснэгт 24-д харуулав.

#### Хүснэгт 24. Салбарын цалин хөлсний зардлын гүйцэтгэл, сая төгрөгөөр

Зардал	2020	2021	2022
<b>Нийт урсгал зардал</b>	24,033.0	48,223.3	111,854.6
1. Бараа үйлчилгээний зардал	23,013.3	46,398.9	49,116.7
Үүнээс: цалин хөлс, НДШ-ийн зардал	17,607.4	24,214.4	26,019.8
2. Урсгал шилжүүлэг (нийт)	1,019.7	1,824.4	62,738.0
Үүнээс: цалин хөлс, НДШ-ийн зардал	0.0	0.0	50,778.6
<b>Нийт цалин хөлс, НДШ-ийн зардал</b>	17,607.4	24,214.4	79,798.4
<b>Нийт урсгал зардалд цалин хөлс, НДШ-ийн эзлэх хувь</b>	<b>73.3%</b>	<b>50.2%</b>	<b>68.7%</b>

2022 оны байдлаар соёлын салбарын урсгал зардлын 68.7% нь цалин хөлс, НДШ-ийн зардалд зарцуулагджээ. 2020, 2021 онд орон нутгийн соёлын байгууллагын ажилтнуудын цалин хөлс, НДШ-ийн зардлыг Соёлын сайдын төсвийн багцаас бус орон нутгийн төсвөөс хариуцсан. 2021 онд урсгал зардалд эзлэх цалин хөлс, НДШ-ийн зардал буурсан нь цалин хөлснөөс бусад бараа үйлчилгээний зардал, ялангуяа бусаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 12.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

2022 оноос орон нутгийн өмчит соёлын байгууллагуудын урсгал зардлыг Соёлын сайдын төсвийн багцын урсгал шилжүүлгээр хариуцах болсон учраас салбарын нийт урсгал зардалд цалин хөлс, НДШ-ийн шимтгэлийн зардлын эзлэх хувь есөж 68.7 хувь болсон байна. Ялангуяа орон нутгийн өмчит соёлын байгууллагууд нь Соёлын сайдаас олгосон 60.8 тэрбум төгрөгийн урсгал шилжүүлгийн 50.7 тэрбумыг буюу 83 хувийг цалин хөлс, НДШ-д зарцуулсан байна.

Хэдийгээр урсгал зардалд цалин хөлсний зардал өндөр хувийг эзэлж байгаа боловч соёлын салбарт ажиллагчдын цалин хөлс нь улсын дундаж цалингаас доогуур байсан. Төрийн албан хаагчдын дотор биеийн тамир, спортын салбарын дараах хамгийн бага цалин хөлстэй төрийн үйлчилгээний албан хаагчид болдог. Соёлын ажилтны үндсэн цалин 2023 оны эхний хагас жилийн байдлаар



766.5 мянган төгрөгтэй тэнцэж байсан.<sup>8</sup> Энэ нь 2020 оны нийт цалин хөлстэй харьцуулахад 17.6 хувиар, 2020 оны үндсэн цалинтай харьцуулахад 10.6 хувиар тус тус өссөн үзүүлэлт юм.


**Зураг 21. Соёлын байгууллагын ажилтны дундаж цалин хөлс, мянган төгрөгөөр**



Эх үүсвэр. ҮСХ/Соёлын яам

Соёлын салбарын ажилтны цалингийн бүтэц нь үндсэн цалин, Төрийн албаны тухай хуулийн 57.2.4-т заасны дагуух докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын нэмэгдэл, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлснөөс тус тус бүрддэг байна. Соёлын салбарт ажиллагчид цалин хөлс бага талаар эсэргүүцлээ илэрхийлж 2023 онд жагсаал, цуглаан зохион байгуулсан. Төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 7 дугаар сарын 1-ны өдрөөс эхлэн нэмэгдүүлэх арга хэмжээг Засгийн газраас авч хэрэгжүүлсэн. Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр зарим ажилтны албан тушаалын зэрэглэл болон цалингийн доод хэмжээг тогтоосноор соёлын салбарын ажилтны үндсэн цалин 2023 оны байдлаар 1,273.0 мянган төгрөгтэй тэнцэж, оны эхний хагас жилийн үеийн 766.5 мянган төгрөгөөс 40 орчим хувиар нэмэгдсэн байна.<sup>9</sup> /Зураг 22/

**Зураг 22. Соёл ба бусад салбарын цалин хөлс, мянган төгрөгөөр**



Эх үүсвэр. Засгийн газрын 2023 оны 240, 241 дугаар тогтоол

Салбарын үндсэн цалинг тооцохдоо тус салбарын мэргэжлийн урлагийн ажилтны /ТҮСУ-4/ үндсэн цалингаар тооцсон болно. 2023 оны 7 дугаар сарын 1-ны өдрөөс эхлэн төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлснээр соёлын ажилтнуудын үндсэн цалин боловсролын салбарынхтай адил болсон. Гэхдээ

<sup>8</sup> Засгийн газрын 2022 оны 107, 276, 487, 488 дугаар тогтоол  
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468129124141&showType=1>  
<sup>9</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759736441001&showType=1>

соёлын байгууллагын ажилтны нийт дундаж цалин боловсролын салбарынхнаас 12 хувиар, эрүүл мэндийн салбарынхнаас 9.2 хувиар тус тус доогуур, биеийн тамир, спортын салбарынхнаас 12 хувиар өндөр байна.

#### Хүснэгт 25. Цалин хөлсний зөрүү (мянган төг.)

Салбар	Нийт цалин хөлсний зөрүү	Нийт цалин хөлсний зөрүү хувиар	Үндсэн цалингийн зөрүү	Үндсэн цалингийн зөрүү хувиар
Эрүүл мэнд	-146.85	-9.2%	-64.0	-5%
Боловсрол	-190.95	-12.0%	-	-
Биеийн тамир, спорт	190.95	12.0%	190.95	12.0%

### 7.2.2. Салбарын урсгал зардалд тогтмол зардлын эзлэх харьцаа

Салбарын урсгал зардалд цалин хөлс, НДШ-ийн зардал өндөр хувь эзлэхээс гадна байр ашиглалттай холбоотой түлш, халаалт, гэрэл цахилгаан, цэвэр, бохир ус, түрээсийн зардал багагүй хувийг эзэлж байна. Нийт урсгал зардал болон бараа үйлчилгээний зардалд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын эзлэх хувийг тооцож доорх хүснэгт 26-д харуулав.

#### Хүснэгт 26. Төрийн өмчит соёлын байгууллагын байр ашиглалтын тогтмол зардал, сая төгрөгөөр

Зардал	2020	2021	2022
<b>Төрийн өмчит СБ-уудын урсгал зардал</b>	<b>21,376.4</b>	<b>23,146.8</b>	<b>24,041.6</b>
<b>Үүнээс: Бараа үйлчилгээ зардал</b>	<b>20,453.7</b>	<b>22,601.7</b>	<b>23,331.0</b>
<b>Бараа үйлчилгээний зардалд туссан байр ашиглалтын тогтмол зардал</b>	<b>1,106.6</b>	<b>1,183.7</b>	<b>1,573.0</b>
1) Гэрэл, цахилгаан	210.5	167.0	386.6
2) Түлш халаалт	206.5	256.6	276.8
3) Цэвэр, бохир ус	32.9	41.2	98.3
4) Байрны түрээс	547.5	651.9	714.5
5) Ашиглалтын зардал /ТӨУГ/	109.2	67.0	96.8
<b>Бараа үйлчилгээний зардалд байр ашиглалтын тогтмол зардлын эзлэх хувь</b>	<b>5.4%</b>	<b>5.2%</b>	<b>6.7%</b>
<b>ТӨСБ-уудын урсгал зардалд байр ашиглалтын тогтмол зардлын эзлэх хувь</b>	<b>5.2%</b>	<b>5.1%</b>	<b>6.5%</b>

Эх үүсвэр. СЯ, Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020-2022.

Соёлын сайдын төсвийн багцад яамны шууд харьяа төрийн өмчит 34 соёлын байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардал л тусгагдсан. Төрийн өмчит соёлын байгууллагууд ихэвчлэн Улаанбаатар хот, аймгийн төвд байршдаг бөгөөд урсгал зардлынхаа зөвхөн 5%-6.5%-ийг л байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд зарцуулж байна. Харин аймаг, сум, дүүргүүдэд байдаг орон нутгийн өмчит 420 орчим байгууллага болох соёлын төв, театр, чуулга, музей, номын сангуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг харьяалах аймаг, дүүргийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг байна. Орон нутгийн өмчит соёлын байгууллагуудын урсгал төсвийг 2020, 2021 онд Соёлын сайд хариуцаагүй тул 2022 оны байдлаар байр ашиглалтын тогтмол зардлын урсгал зардалд эзлэх хувь хэмжээг тооцож дараах хүснэгт 27-д харуулав.

**Хүснэгт 27. Орон нутгийн өмчит соёлын байгууллагын байр ашиглалтын тогтмол зардал, сая төг.**

Зардал	2022 Нийт	Музей	Номын сан	Соёлын төв	Театр, чуулга
<b>Орон нутгийн өмчит соёлын байгууллагын урсгал зардал</b>	<b>85,083.9</b>	<b>6,833.6</b>	<b>6,196.1</b>	<b>45,232.4</b>	<b>26,821.9</b>
Үүнээс: Соёлын сайдаас олгосон урсгал шилжүүлэг	60,758.7	5,026.2	5,111.9	30,473.5	20,147.0
ОН-ийн өмчит СБ-ын бараа үйлчилгээний зардал	80,891.4	6,144.0	5,947.7	43,177.8	25,621.9
Байр ашиглалтын тогтмол зардал. Үүнээс:	19,180.6	901.7 (4.7%)	747.4 (3.9%)	13,544.6 (70.6%)	3,986.9 (20.8%)
1. Гэрэл, цахилгаан	878.6	88.9	51.6	529.5	208.6
2. Түлш халаалт	17,890.3	782.8	620.2	12,851.0	3,636.2
3. Цэвэр, бохир ус	376.6	30.0	40.5	164.1	142.0
4. Байрны түрээс	35.1		35.1		
<b>Бараа үйлчилгээний зардалд байр ашиглалтын тогтмол зардлын эзлэх хувь</b>	<b>23.7%</b>	<b>14.7%</b>	<b>12.6%</b>	<b>31.4%</b>	<b>15.6%</b>
<b>ОН-ийн өмчит соёлын байгууллагын урсгал зардалд байр ашиглалтын тогтмол зардлын эзлэх хувь</b>	<b>22.5%</b>	<b>13.2%</b>	<b>12.1%</b>	<b>29.9%</b>	<b>14.9%</b>

Эх үүсвэр. СЯ, Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020-2022.

Орон нутгийн өмчит соёлын байгууллагуудын байр ашиглалтын тогтмол зардлаас бусад зардлыг соёлын сайдын төсвийн багцаас хариуцдаг болохыг өмнө дурдсан. 2022 оны байдлаар эдгээр байгууллагын нийт урсгал зардлын 22.5 хувь нь зөвхөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд зарцуулагдаж байна. Энэ үзүүлэлт нь Улаанбаатар хот, аймгийн төвд байршилтай төрийн өмчит соёлын байгууллагуудын байр ашиглалтын зардлын урсгал зардалд эзлэх хувь хэмжээнээс 3.5 дахин өндөр байна. Орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн нийт 19.2 тэрбум төгрөгийн байр ашиглалтын тогтмол зардлын 71.8 хувь нь буюу 17.9 тэрбум төгрөгийг түлш, халаалтын зардалд зарцуулсан байна. Түүнчлэн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын санхүүжилтийн 70.6 хувь буюу 13.5 тэрбум төгрөг нь соёлын төвүүдийн байр ашиглалтын тогтмол зардал байна.

Орон нутгийн өмчит соёлын байгууллагын тоо олон бөгөөд орон нутагт уурын зуухнаас халаалт авдаг дулааны алдагдал ихтэй хуучин барилга байгууламж ихтэй учир байр ашиглалтын тогтмол зардал өндөр байна. Орон нутагт халаалт, дулааны асуудлыг нүүрсний уурын зуухаар шийдэж байгаа нь өртөг өндөртэй эрчим хүчний эх үүсвэр юм. Зөвхөн соёлын байгууллагуудын хувьд төдийгүй төсөвт үзүүлэх байр ашиглалттай холбоотой зардлын дарамтыг бууруулахын тулд эрчим хүчний хэмнэлттэй дулааны алдагдалтай барилга байгууламж барихад анхаарах, нар, салхины эрчим хүч зэрэг байгальд ээлтэй сэргээгдэх эрчим хүчийг хуримтлуулж ашиглах ухаалаг технологийг нэвтрүүлэхэд онцгой анхаарах нь зүйтэй байна.

### **7.3. Салбарын хөрөнгийн зардлын чиг хандлага**

Соёлын салбарын хөрөнгийн зардлын дийлэнх нь шинээр барилга байгууламж барих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ юм. Соёлын салбарт 2010-2023 онд хөрөнгө оруулалтын нийт 500 барилга байгууламж барих төсөл, арга хэмжээний төсөв батлагдаж гүйцэтгэлээр санхүүжүүлсэн байна. Үүнээс 2022 оны эцсийн байдлаар 425 төсөл арга хэмжээний барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулсан байна.

Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг тухайн онд батлагдсан санхүүжих дүнтэй харьцуулахад 2010-2022 оны хугацаанд 85.4% байна. Хөрөнгийн төсвийн гүйцэтгэл 2015 онд 63.1%-тай хамгийн бага байсан бол 2022 онд маш сайн буюу 100% гүйцэтгэлтэй гарсан байна.

*Хүснэгт 28. Хөрөнгө оруулалтын төсөв ба гүйцэтгэл /сая.төг/*

Он	Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
2010	16,714.6	5,722.7	4,868.1	85.1%
2011	71,612.6	25,373.3	23,114.3	91.1%
2012	74,308.7	50,143.9	42,622.3	85.0%
2013	70,231.5	29,590.6	21,036.3	71.1%
2014	107,753.3	44,149.5	35,203.2	79.7%
2015	111,562.3	27,567.9	17,407.2	63.1%
2016	146,671.4	25,652.7	21,804.8	85.0%
2017	80,560.5	11,805.9	9,783.3	82.9%
2018	118,538.8	35,268.4	32,203.1	91.3%
2019	187,607.3	84,587.6	80,273.3	94.9%
2020	671,079.7	144,335.8	105,453.6	73.1%
2021	548,984.5	92,839.1	89,725.3	96.6%
2022	481,220.0	62,174.4	62,174.0	100.0%
<b>Нийт</b>		<b>639,211.8</b>	<b>534,483.5</b>	<b>85.4%</b>

2010-2023 онд давхардсан тоогоор он дамжуулан нийт 906 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Үүнээс соёлын төвийн барилга хамгийн их баригджээ.

*Хүснэгт 29. Хөрөнгө оруулалт байгууллагын төрлөөр*

Он	Кино театр	Музей	Номын сан	Соёл, спорт цогцолбор	Соёлын өв	Соёлын төв	Театр чуулга	Түүх соёл	Улсын хэмжээнд	Нийт
2010		1	1		1	8	3	2	2	<b>18</b>
2011		8	4	4		41	12	4	3	<b>76</b>
2012		22	5	7		72	12	4		<b>122</b>
2013		1	1	5		18	4	5	2	<b>36</b>
2014			3	7		31	7	5	2	<b>55</b>
2015			1	3		20	4	3		<b>31</b>
2016			2	2		19	6	4	2	<b>35</b>
2017			1			10	4	3		<b>18</b>
2018			1	2		42	4	1		<b>50</b>
2019	1	3	1	10		73	7	2		<b>97</b>
2020	1	12	2	10	2	76	11	1		<b>115</b>
2021		11		3	4	55	9	2	2	<b>86</b>
2022	1	19	6		3	48	12		1	<b>90</b>
2023	1	16	5	3	1	42	9			<b>77</b>
<b>Нийт</b>	<b>4</b>	<b>93</b>	<b>33</b>	<b>56</b>	<b>11</b>	<b>555</b>	<b>104</b>	<b>36</b>	<b>14</b>	<b>906</b>

Соёлын салбарын хөрөнгө оруулалтын 2010-2022 онд батлагдсан төсөл арга хэмжээг хамруулан судалгаа хийхэд ашиглалтад орох хүртэлх барилгын ажлын үргэлжлэх хугацаа дунджаар 4.4 жил байна. Гэхдээ 2008 онд анх төсөв нь батлагдсанаас хойш 2017 он хүртэл 10 жил үргэлжилсэн театрын 1 барилга, 2011 онд төсөв нь анх батлагдсанаас хойш 2023 он хүртэл 12 жил үргэлжилж буй

театрын 3 барилга, 2012 онд төсөв нь батлагдаж 11 жил үргэлжилж буй театрын 1 барилга байжээ. Түүнчлэн 2008-2019 оны хугацаанд 12 жил үргэлжилж баригдсан 1 барилга, 2011 онд төсөв нь батлагдаж 10 жил үргэлжилсэн соёлын төвийн 1 барилга, 2012 онд төсөв нь батлагдаж 11 жил үргэлжилсэн соёлын өвийн 1 барилга, Үндэсний номын сангийн барилга 2012 оноос баригдаж эхэлсэн боловч өнөөг хүртэл ашиглалтад оролгүй 12 жилийн хугацаанд баригдсаар байна. Нийт 10 жилээс дээш баригдсан болон баригдаж буй 9 төсөл арга хэмжээ байгаа нь салбарын барилга байгууламжийн төсөл арга хэмжээний үргэлжлэх хугацааны дундаж 4.4 жил байхад нөлөөлж байна.

### Хүснэгт 30. Хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэл, оноор

Эхлэх он	Дуусах он	Кино театр	Музей	Номын сан	Соёл, спорт цогцолбор	Соёлын өв	Соёлын төв	Театр чуулга	Түүх соёл	Тоног төхөөрөмж, их засвар	Нийт	Төслийн үргэлжлэх хугацаа
2007	2010							1			1	4
2007	2011						1				1	5
2007	2013						1				1	7
2008	2010					1	4				5	3
2008	2011						2				2	4
2008	2012						1	1	1		3	5
2008	2016								2		2	9
2008	2017							1			1	10
2008	2019								1		1	12
2009	2011						2				2	3
2010	2010		1	1			3	2		1	8	1
2010	2011							1			1	2
2010	2014								1		1	5
2010	2015						1				1	6
2010	2016									1	1	7
2010	2018						1				1	9
2011	2011		7	2	2		24	3	1	2	41	1
2011	2012		1	2	4		12	3	1	1	24	2
2011	2013						3	1	1	1	6	3
2011	2014							1			1	4
2011	2017										0	7
2011	2018										0	8
2011	2020						1				1	10
2011	2023							3			3	13
2012	2012		22	4	5		53	7	2		93	1
2012	2013		1	1	1		8		2		13	2
2012	2014			1	3		13	1	1		19	3
2012	2015				1		2		2		5	4
2012	2016			1	2		5	1			9	5
2012	2017				1		3		1		5	6
2012	2018				1		1				2	7
2012	2021						1				1	10
2012	2022							1			1	11
2012	2023			1							1	12
2013	2013									1	1	1
2013	2016						1				1	4
2014	2014			1	1					1	3	1
2014	2016						2	1		1	4	3
2014	2017						2				2	4
2014	2018						1				1	5


Эхлэх он	Дуусах он	Кино театр	Музей	Номын сан	Соёл, спорт цогцолбор	Соёлын өв	Соёлын төв	Театр чуулга	Түүх соёл	Тоног төхөөрөмж, их засвар	Нийт	Төслийн үргэлжлэх хугацаа
2015	2016						1				1	2
2015	2017						1				1	3
2016	2016						1				1	1
2016	2017								1		1	2
2018	2018				1		10				11	1
2018	2019				2		21				23	2
2018	2020						4				4	3
2018	2022						2				2	5
2018	2023						1				1	6
2019	2019		1		3		32	3	1		40	1
2019	2020	1			2		7				10	2
2019	2022						4				4	4
2019	2023		2		4		8	1			15	5
2020	2020		3	1	1	1	18	3			27	1
2020	2021		1			1	6	1	1		10	2
2020	2022		1				1	2			4	3
2020	2023		4		4		14				22	4
2021	2021					2	2			1	5	1
2021	2022		1			1	4		1	1	8	2
2021	2023		4				11	2			17	3
2022	2022		2	1		1	3	1			8	1
2022	2023	1	5	4		1	2	3			16	2
	Нийт	2	56	20	38	8	301	44	20	11	500	4,4

Эх үүсвэр. Соёлын яам, 2023.

Барилга байгууламжийн ашиглалтад орох хугацаа төлөвлөснөөс хойшлох нь төсөвт өртөг нэмэгдэх гол хүчин зүйл болж эдийн хувьд үр ашиггүй нөхцөл байдал үүсдэг. Иймд төсөл арга хэмжээний ТЭЗҮ-ийг анхнаас нь зөв тодорхойлж, ач холбогдлоор нь эрэмбэлж, шаардлагатай төсөлд л хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна.

Соёлын салбарт 2010-2022 оны 13 жилийн хугацааны хөрөнгийн зардлыг багцалбал, нийтдээ 639.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөв батлагдаж, 500 барилгын ажлыг эхлүүлж, 425 барилгыг ашиглалтад оруулж, 534.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлсэн байна. Нийт 500 төсөл, арга хэмжээний 60 хувь нь соёлын төвүүдийн барилга байна. /Зураг 23/

Зураг 23. 2010-2023 онд баригдсан барилгын тоо, зориулалтаар



Эх үүсвэр. Соёлын яам, 2023.

---


Монгол Улсын 333 сумаас 301 суманд буюу сумын соёлын төвүүдийн барилгын 90 хувь нь өнгөрсөн 10 жилийн хугацаанд шинэчлэгджээ гэж үзэж болохоор байна. Энэ нь цаашид соёлын салбарын хөрөнгө оруулалтын зардал буурах эсхүл одоогийнхоос нэмэгдэхгүй байх магадлалтай байна. Хэдийгээр шинээр соёлын төвүүд барьсан боловч архитектур дизайны хувьд уламжлалт загварын хийц давамгайлсан байна. Гадаад улс орнууд нь соёлын төвүүдийн барилгыг илүү шинэлэг архитектур дизайнаар барьж, иргэд, олон нийт байнга цугларах, соёлын боловсрол мэдээлэл авах, дуу хөгжмийн бэлтгэл хийх, уран зургийн үзэсгэлэнгээ гаргах, бүх насныхан чөлөөтэй ном унших орчин нөхцөлийг бүрдүүлсэн загвар дизайныг илүүд үзэх болсон байна. Энэ тайлангийн 9 дүгээр бүлэгт соёлын төвүүдийн талаар илүү дэлгэрэнгүй хөндөх болно.

## 8. ТӨСВИЙН ХАНГАЛТТАЙ БАЙДАЛ

Соёлын салбар 2022 оны байдлаар 34.1 тэрбум төгрөгийн авлагатай болсон нь 2021 онтой харьцуулахад 9.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт авлагын 67.1% буюу 22.9 тэрбум төгрөг нь салбарын хөрөнгө оруулалт, их засварын дансанд бүртгэгдсэн байна. Бусад харьяа байгууллагад нийт 11.2 тэрбум төгрөгийн авлагатай гарсан үзүүлэлттэй байна.

Нийт өр төлбөрийн хувьд 2022 оны гүйцэтгэлээр 24.1 тэрбум төгрөгийн өр төлбөртэй гарсан бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 110.8 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт юм. Энэ нь тухайн салбарын барьцаа хөрөнгө/хөрөнгө оруулалт/-ийн дансанд нийт 23.1 тэрбум төгрөгийн өр төлбөртэй гарсан нь нийт өр төлбөрийн 96.0% болж байна.

Зураг 24. Салбарын нийт өр төлбөр ба авлага, сая төгрөгөөр



Эх үүсвэр. Соёлын яам, 2023

Нийт авлагын 67 хувь, нийт өр төлбөрийн 96 хувь нь салбарын хөрөнгө оруулалт, их засварын болон барьцаа хөрөнгийн гэсэн 2 дансанд байршиж байгаа нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсвийг оны эцэст эдгээр дансанд төвлөрүүлэн төсвийн дараа жил рүү шилжүүлж, барилгын гүйцэтгэл дууссаны дараа санхүүжүүлдэгтэй холбоотой байна.

Нийт авлага, өр төлбөрийн хэмжээг 2022 оны байдлаар байгууллагын төрлөөр доорх хүснэгт 31-д харуулав.

Хүснэгт 31. Нийт өр, авлага, байгууллагын төрлөөр, сая төгрөгөөр, 2022 он

Байгууллагын төрөл	Нийт авлага		Нийт өр төлбөр	
	Байгууллагын тоо	Эцсийн үлдэгдэл	Байгууллагын тоо	Эцсийн үлдэгдэл
<b>НИЙТ</b>	<b>155</b>	<b>34,087.2</b>	<b>124</b>	<b>24,088.5</b>
<b>Орон нутгийн өмчит байгууллагууд</b>	<b>125</b>	<b>313.3</b>	<b>106</b>	<b>912.5</b>
Музей	7	47.8	5	36.2
Номын сан	6	10.3	8	16.2
Соёлын төв	102	102.7	85	695.7
Театр, чуулга	10	152.5	8	164.3



Байгууллагын төрөл	Нийт авлага		Нийт өр төлбөр	
	Байгууллагын тоо	Эцсийн үлдэгдэл	Байгууллагын тоо	Эцсийн үлдэгдэл
<b>Соёлын сайдын харьяа, төрийн өмчит байгууллагууд</b>	<b>30</b>	<b>33,773.9</b>	<b>18</b>	<b>23,176.0</b>
Соёл урлагийн газар /агентлаг/	1	93.3	1	4.8
Аймгийн Соёл урлагийн газар	7	64.9	6	14.9
Гүйцэтгэлээр санхүүжих	1	71.4		
Кино урлагийн зөвлөл	2	10,020.6	1	1.5
Музей	9	513.8	3	18.3
Номын сан	2	37.6	2	6.0
Театр, чуулга	5	48.3	3	3.7
Хөрөнгө оруулалт	1	22,888.6	1	23,126.7
Хүрээлэн	1	2.0	1	0.1
Яам	1	33.5		

Эх үүсвэр. Соёлын яам, 2023

Салбарын 2022 оны төсвийн гүйцэтгэлээр орон нутгийн 125 байгууллагын нийт авлага 313.3 сая төгрөг, нийт өр төлбөр 912.5 сая төгрөг байна. Харин соёлын сайдын харьяа байгууллагын нийт авлага 33.8 тэрбум төгрөг, нийт өр төлбөр 23.2 тэрбум төгрөг байна. 2020 онд Кино урлагийг дэмжих санд 10 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан боловч хууль эрх зүйн зохицуулалт бүрдээгүй, Кино урлагийг дэмжих зөвлөл байгуулагдаж амжаагүй зэргээс шалтгаалан тухайн онд батлагдсан төсвөө зарцуулж чадаагүй учраас оны эцэст төсөвт эргэн татагдсан байна. Үүнийг Соёлын яам 2022 оны санхүүгийн тайландаа төсвийн санхүүжилтээс авах авлагаар бүртгэж, авлага үүсгэжээ.

2022 оны төсвийн зарлагын гүйцэтгэлээс харахад бичиг хэрэг, гэрэл, цахилгаан, түлш, халаалт болон ажилтнуудад олгох унаа хоолны хөнгөлөлтийн төсөв хангалтгүй буюу төсөвлөснөөс илүү зарцуулсан байна. Бичиг хэргийн зардалд 2022 онд 103.6 сая төгрөг баталсан нь 1 ажилтанд сард 1450 орчим төгрөгийн зардал болж байна. Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас харахад 2022 онд бичгийн хэргийн зардлыг 5 сая төгрөгөөр, гэрэл, цахилгааны зардал 33.3 сая төгрөгөөр, цэвэр, бохир усны зардлыг 1.7 сая төгрөгөөр, ажилтнуудын унаа хоолны хөнгөлөлтийн зардлыг 377.3 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

Соёлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.9-д “Тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд 5 жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгоно” гэж заасны дагуу орон нутагт ажиллаж байгаа соёлын ажилтнууд 5 жил тутамд мөнгөн тэтгэмж авах эрхтэй байхаар 2021 онд хуульчилсан байна. Энэ заалтын хүрээнд орон нутагт тухайн байгууллагад 5-аас дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж буй 2,257 албан хаагчийн 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгоход 2023 онд 9.9 тэрбум төгрөгийн эх үүсвэр шаардлагатай гэж Соёлын яамнаас тооцсон боловч шаардагдах хөрөнгийн эх үүсвэр төсөвт тусгагдаагүй байна. ЗГ-ын 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 185 дугаар тогтоолоор орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журмыг баталж, цаашид жил бүрийн улсын төсөвт санхүүжилтийн эх үүсвэрийг тусгаж байхыг шийдвэр гаргасан байна. Дээр дурдсан илүү зарцуулалттай зардлууд болон энэ оны төсөвт тусгагдаагүй мөнгөн тэтгэмжийн зардлыг оруулан тооцвол салбарын урсгал төсөв наад зах нь 10.3 тэрбум төгрөгөөр дутуу буюу хангалтгүй байна.

## 9. СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ЗАРДЛЫН ӨГӨӨЖ

Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоон шалгуур үзүүлэлтийг баталдаг.

Төсвийн ерөнхийлөн захирагч (сайд) нар төсвийн жил дууссаны дараа төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаж, СЯ-нд ирүүлэх үүргийг Төсвийн тухай хуулиар хүлээдэг. Уг тайланд хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлтийг багтаасан байх ёстой. СЯ-аас Монгол Улсын жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэж дараа оны 5 дугаар сарын 10-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлэх ба аудитын байгууллагын дүгнэлт гарсны дараа УИХ-аар хэлэлцүүлж, гүйцэтгэлийг батлуулдаг.

Монгол Улсын 2021, 2022, 2023 оны төсвийн тухай хуулиудаар баталсан соёл урлаг хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг дараах хүснэгт 32-д харьцуулан харуулав.

### Хүснэгт 32. Соёл урлаг хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд

	Хөтөлбөрийн үр дүнгийн чанарын ба тоон шалгуур үзүүлэлтүүд	2021 оны зорилтот түвшин	2022 оны зорилтот түвшин	2023 оны зорилтот түвшин
1	Соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн тоо /хүн амд эзлэх хувиар/	75.0	75.0	78.0
2	Нийтийн номын сангийн байнгын уншигч /хүн амд эзлэх хувиар/	15.0	15.0	15.0
3	Музейн үзэгчийн тоо /хүн амд эзлэх хувиар/	21.0	21.0	21.0
4	Жилийн эцэст хүрсэн байх музейн үзмэрийн тоо /мянгаар/	245.0	245.0	245.0
5	10000 хүнд ногдох номын тоо /мянган ширхэг/	28.0	28.0	28.0
6	10000 хүнд ногдох соёлын төвийн суудлын тоо	300	300	300
7	Улсын хэмжээнд хэрэгжүүлсэн үндэсний хөтөлбөрийн тоо	3-аас доошгүй	3-аас доошгүй	21
8	Мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчдийн тоо /давхардсан тоогоор, сая хүн/	3.6	3.6	3.6

Монгол Улсын 2021, 2022, 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар баталсан соёл урлаг хөтөлбөрийн 8 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг 2013 оноос хойш өөрчлөөгүй байна. Түүнчлэн сүүлийн 3 жилийн хугацаанд дээрх 8 үзүүлэлт өөрчлөгдөөгүй ба зорилтот түвшнийг ямар нэг ахиц дэвшил, өөрчлөлтгүй жил бүр ижил хэмжээгээр авч байжээ.

Зөвхөн 2023 онд соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн тоог 2022 оныхоос 3 пунктээр нэмэгдүүлж 78 хувьд хүргэх, хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн тоог 21 болгоно гэж 2022 оныхоос 7 дахин өндөр зорилт тус тус тавьж өөрчилсөн байна. Харин Соёлын сайдын төсөв 2020 онд 180.8 тэрбум төгрөгөөр батлагдсан байсан бол 2021 онд 138.1 тэрбум болж 24%-аар буурсан, 2022 онд 177.4 тэрбум төгрөгөөр батлагдаж өмнөх оноос 28%-аар тус тус нэмэгдсэн байна. Ийнхүү соёлын

---

салбарын төсвийн хэмжээ өөрчлөгдөж байсан боловч төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн зорилтот түвшнийг өөрчлөөгүй байна.

Хөтөлбөрийн хүрэх үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг Төсвийн тухай хуулиар баталдаг боловч хөтөлбөрийн үр дүнгийн томъёолол хуульд тусгагдахгүй байна. Соёл урлаг хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд зөвхөн тоон шалгуур үзүүлэлтүүд бөгөөд төсвийн хөрөнгөөр хөтөлбөр хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг бус зөвхөн хийх ажил, үйлчилгээний гарцын үзүүлэлтийг хэмжих шалгуур төдий байна. ҮСХ-ны вэбсайтад байршуулсан соёлын салбарын статистик үзүүлэлт хязгаарлагдмал агуулгатай, соёлын үйлчилгээний үр дүн, иргэдийн соёлын боловсролын нөхцөл, байдал эсхүл үйлчилгээний хүртээмж, агуулгын талаарх түүвэр судалгаа, дүн шинжилгээний ажил бараг хийгдээгүй учраас соёлын үйлчилгээний хүн амын хөгжилд үзүүлж байгаа үр нөлөө, эдийн засгийн өсөлт, хөгжилд үзүүлэх өгөөжийн талаар дүгнэлт хийх боломжгүй байна. Харин Соёлын яамнаас судалгааны байгууллагатай хамтран 2021 онд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн суурь судалгааг хийсэн нь соёлын бүтээлч үйлдвэрлэлийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлсон чухал судалгаа болсон байна. Цаашид соёлын байгууллагуудаас авдаг захиргааны тоо мэдээллийг сайжруулах, албан ёсны статистик үзүүлэлтүүдийг шинэчлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын салбарын хувийн хэвшилд ажиллагчдын тооны статистик мэдээлэл зэргийг тооцдог болох шаардлагатай байна.

ЮНЕСКО-оос Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан соёлын салбарын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тоон болон чанарыг шалгуур үзүүлэлтийг 2019 онд боловсруулж, улс орнуудыг ашиглахыг зөвлөмж болгосон. Энэхүү шалгуур үзүүлэлтийн багцад соёлын салбарын үр дүнг үндсэн 4 бүлэгт хувааж, үр дүнг үнэлэх тоон болон чанарын 22 шалгуур үзүүлэлтийн тодорхойлолт, зорилго, тооцох аргачлалыг гаргасан байна. (UNESCO, 2019) Эдгээр шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлалыг монгол хэлээр орчуулан манай улсад хэрэглэж болох эсэх тухай зөвлөмжийн хамт энэхүү тайлангийн сүүлийн бүлэгт оруулсан болно. Манай улсын хувьд Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгын 244 шалгуур үзүүлэлтийн 20 шалгуур үзүүлэлтийг буюу дөнгөж 8% нь манай хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд ашигласан нь хангалтгүй байгаа учраас цаашид өөрийн орны бодлогын баримт бичигт ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тусгахыг эрмэлзэх шаардлагатай байна.

Соёл урлагийн салбарын үйл ажиллагааны үр дүнгийн 4 үзүүлэлт /A-D/ болон салбарын зардлын зарим төрөл хооронд уялдаа байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор корреляцийн хамаарлын шинжилгээ хийв. Үүнд салбарын урсгал ба хөрөнгийн зардал, цалингийн зардал (F-H), уран бүтээл хийлгэх, музейн үзмэр худалдан авах, түүхийн соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, соёл урлагийг хөгжүүлэх зориулалтаар 2013-2022 онд зарцуулсан (I-K) зардлуудыг үйл ажиллагааны үр дүнгийн 4 үзүүлэлттэй хамаарах корреляцийн коэффициентыг тооцож дараах хүснэгт 33-д харуулав.

### Хүснэгт 33. Хамаарлын шинжилгээ

Хамаарал тооцсон үзүүлэлтүүд	А.Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолтын тоо	В.Мэргэжлийн урлагийн байгууллагаар үйлчлүүлсэн хүний тоо	С.Музейн үзэгчдийн тоо	Д.Номын сангийн байнгын уншигчдын тоо
Е.Нийт төсөв	-0.93847	-0.46760	-0.14046	0.02525
Ф.Урсгал зардал	0.62996	-0.52453	0.49585	-0.07081
Г.Хөрөнгө оруулалт	-0.89284	-0.08126	-0.50296	0.07699
Н. Цалингийн сан, НДШ	-0.93604	-0.38709	-0.19679	-0.04425
І.Соёл урлаг хөгжүүлэх	-0.63721	-0.49108	0.02634	-0.02983
Ј.Музейн үзмэр худалдан авах		0.16691	0.29474	
К.Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах		-0.43413	0.07353	

Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолтын тоо нь урсгал зардалтай эерэг, дунд хамааралтай /0.62996/ байна. Харин цалингийн сан, НДШ-тэй хүчтэй, сөрөг хамааралтай /-0.93604/, соёл урлагийг хөгжүүлэх зардалтай сөрөг, дунд хамааралтай /-0.63721/ байна. Мэргэжлийн урлагийн байгууллагаар үйлчлүүлсэн хүний тоо нь хөрөнгө оруулалттай хамааралгүй /-0.08126/ байна.

Музейн үзэгчдийн тоо нь музейн үзмэр худалдан авах зардалтай эерэг, бага зэргийн хамааралтай /0.29474/ байгаа бол номын сангийн байнгын уншигчдын тоо салбарын төсвийн үзүүлэлтүүдтэй төдийлөн хамааралгүй байна.


#### 9.1. Театр, чуулгын соёлын үйлчилгээний үр дүн, зардлын өгөөж

Төрийн болон орон нутгийн өмчийн соёл, урлагийн байгууллагууд 2020-2021 онд цар тахлын нөхцөл байдал, үйл ажиллагааны хязгаарлалтаас шалтгаалан үйлчилгээ, үйлчлүүлэгчдийн тоо 2019 оны үеэс жилд 30-50 хувиар буурсан. Харин 2022 онд танхимын үйл ажиллагааг сэргээж цахимаар үзүүлэх үйлчилгээг үргэлжлэн хэрэгжүүлснээр үзвэр, үйлчилгээ, үйлчлүүлэгчдийн тоо III дугаар улирлын гүйцэтгэлээр 2021 оны мөн үеэс 30 хувиар өсөж, 2 сая 877 мянга болсон. Энэ нь давхардсан тоогоор Монгол Улсын жилийн дундаж хүн ам /3 сая 283 мянган/-ын 87%-тай тэнцэх буюу үйлчлүүлэгч нэг иргэн жилд дунджаар 2-3 удаа соёлын үйлчилгээ авч байна гэсэн өндөр үзүүлэлт юм.

Театр, чуулгын соёлын байгууллагуудад Дуурь бүжгийн эрдмийн театр, Үндэсний урлагийн их театр, Улсын филармони, Улсын драмын эрдмийн театр, Улсын хүүхэдэд театр, Хүүхэд залуучуудын гэсэн төрийн өмчит 6 байгууллага болон орон нутгийн өмчит 24 Хөгжимт жүжгийн театр, чуулга нийт 30 байгууллага улсын төсвөөс санхүүжилт авч байна.

Мэргэжлийн урлагийн байгууллага 2012-2018 онд жилд 4000 гаруй тоглолт тогтмол хийж байсан бол 2019-2021 онд цар тахлын нөлөөгөөс үүдэн тоглолтын тоо огцом буурсан байна. Үзэгчдийн тоо нь тоглолтын тооноос төдийлөн хамаарахгүйгээр хэлбэлзэл ихтэй байжээ. Тухайлбал, 2014 онд 4,358 тоглолтыг давхардсан тоогоор 1,603.3 мянган хүн үзсэн бол 2015 онд 4,442 тоглолт хийхэд 4,642.7 мянган үзэгчтэй байжээ.

Зураг 25. Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолтын ба үзэгчдийн тоо



Эх сурвалж: www.1212.mn, 2023

Хүснэгт 34. Мэргэжлийн урлагийн байгууллагуудын зардлын өгөөж

Үзүүлэлт	Үзэгчид (мянган хүн)	Нийт урсгал зардал (сая төг.)	Байгууллагын үйл ажиллагааны орлого (сая төг.)	1 үзэгчид ногдох жилийн үйл ажиллагааны зардал (төгрөг)	100 төгрөгийн зардалд ногдох өөрийн орлого (төгрөг)
2022 он	885.7	32,785.7	3,023.1	37,017	9

Эх сурвалж: Соёлын яам, Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2022

Мэргэжлийн урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны орлого Ковидын дараа 2022 онд огцом нэмэгдэж, 3 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас харахад орон нутгийн өмчит 24 Хөгжимт жүжгийн театр, чуулгын 2022 оны үйл ажиллагааны өөрийн орлого 379.8 сая төгрөг байсан бол мэргэжлийн урлагийн төрийн өмчит 6 байгууллагын орлого 2.6 тэрбум төгрөг байжээ. Орон нутгийн өмчит 24 Хөгжимт жүжгийн театрын жилийн орлого 379.8 сая төгрөг байгааг 25 театрт хуваахад дунджаар 16 сая төгрөг болж байгаа нь хангалтгүй байна. Эдгээр 25 театр нийтдээ наад зах нь 500.0 мянган хүнд үйлчилсэн гэж үзэхэд 1 үзэгчээс 30 төгрөгийн орлого олсон гэж үзэхээр байна. Урлагийн байгууллагуудын орлогын бүртгэл гүйцэд байдаг эсэх нь эргэлзээтэй байна. Цаашид мэргэжлийн урлагийн байгууллагууд нь сайн менежмент, үзэгчдэд чиглэсэн зөв маркетинг баримталбал орлогоо нэмэгдүүлэх бүрэн боломжтой гэж үзэж байна. 2022 онд театр, чуулгын үйлчилгээний 1 үзэгчид ногдох дундаж зардал 37,017 төгрөг бөгөөд 100 төгрөгийн зардал гаргаж 9 төгрөгийн орлого олжээ. /Хүснэгт 37/

Дэлхий дахинд тохиолдсон Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионы нөхцөл байдал нь соёлын үзвэр, үйлчилгээний хэлбэрийг шинэчлэхэд түлхэц болж, виртуал үйлчилгээ, дижитал үзэсгэлэн, соёлын тусгай подкаст, видео, соёлын өвийн контент бүхий видео тоглоомууд зэрэг соёлын шинэ төрлийн бүтээгдэхүүнүүд дэлхийн зах зээлд дэлгэрч байна. Театр, чуулгын тоглолт, концерт, дуурийн онлайн дамжуулалтын хэлбэр түгээмэл болж байна. Латин Америкийн Чили Улсын Сантьягогийн Үндэсний дуурийн театр, Буэнос-Айрес дахь “Колон” театрууд нь анхны эмэгтэй найруулагч Кармен Глория, Мария Виктория нарын удирдлагаар шууд дамжуулалтын тоглолтуудыг амжилттай эхлүүлсэн. (BOP Con-

sulting, 2021). Сантьягогийн Дуурийн театр нь долоо хоногт дөрөв хүртэлх удаа тоглолт, яриа, семинарыг шууд дамжуулдаг “Хотын хүргэлт (Municipal Delivery)”-ийг бий болгосон. Колон театр нь “Culture At Home” (Испани хэлээр CulturaEnCasa)-ыг байгуулж, ням гарагийн орой бүр шууд дамжуулдаг байжээ. 2020 оны 6 дугаар сарын байдлаар Municipal Delivery хөтөлбөрийн хүрээнд 27 виртуал шууд арга хэмжээ зохион байгуулж, 260,000 гаруй хүн оролцсон бол “Culture At Home” нь 1.5 сая гаруй үзэлттэй болжээ. Эдгээр тусгай хөтөлбөрүүд нь газарзүйн саад бэрхшээлийг арилгах, үзэгчдийг төрөлжүүлэх зэрэг эерэг үр дүнд хүргэж байна гэж дүгнэсэн. Манай улсын хувьд цаашид ч үзэгчдийн тоог нэмэгдүүлэх, гадаад дахь үзэгчдэд зориулсан театрын виртуал үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй байна.

### ШИГТГЭЭ. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН “ЗАЛУУЧУУД” ТЕАТР.



*Дархан-Уул аймгийн Залуучууд театр нь 591 суудалтай их танхим, 200 суудалтай дугуй танхим, 73 суудалтай хүүхэлдэйн театр гэсэн 3 танхимтай. Нийт 98 ажилтантайгаас 54 хүн нь мэргэжлийн уран бүтээлчид байна. 2023 оны батлагдсан төсөв нь 2.01 тэрбум төгрөг, үүний 99 хувь нь цалин хөлс, НДШ, нэмэгдэл урамшуулалд зарцуулагдахаар төсөвлөгдсөн. Театр нь 2022 онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд 106,159 хүнийг хамруулсан 292 удаагийн урлаг, соёлын арга хэмжээг зохион байгуулж, 110 сая төгрөгийн орлого олсон. Түүнчлэн байраа цайны газарт түрээсэлсний*


болон Мобиком ХХК-ны сүлжээний антенныг байршуулсны түрээсийн орлого олдог байна. 2022 онд театр өөрийн 21 уран бүтээлийг 103 удаа тоглож 36,386 хүнд хүргэсэн бол бусад 189 арга хэмжээ нь хувийн байгууллага, уран бүтээлчидтэй хамтарч ажилласан тоглолтууд юм..

Дархан-Уул аймгийн Залуучууд театрын дарга А.Болорсүх уулзалтын үеэр “...Залуучууд театрын барилга нь 1978 онд ашиглалтад орсноос хойш их засвар хийгдээгүй. 2023 оны төсвийн төсөлд 150 сая төгрөгийн төсөвт өртөгтэй их засварын ажил хийлгүүлэхээр санал хүргүүлсэн боловч батлагдаагүй. Цаашид үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад их засвар зайлшгүй шаардлагатай байна. Үүнээс гадна нарийн мэргэжлийн уран бүтээлчид /найруулагч, хөгжимчид г.м/, тоног төхөөрөмж их шаардлагатай байна” гэж яриу.

## 9.2. Музейн үйлчилгээний үр дүн, зардлын өгөөж

Улаанбаатар нийслэл хот, Архангай, Өвөрхангай аймагт төрийн өмчийн нийт 14 музей байдаг бол аймаг болгонд болон нийслэлд орон нутгийн өмчит нийт 23 музей байна. Түүнчлэн төрийн өмчит Уран зургийн галерей нийслэл хотод байна. Төрийн болон орон нутгийн өмчийн музейн үзмэрийн тоо 2018 онд бусад оныхоос өндөр буюу 289,589 хүрсэн ч 2019 онд 16%-аар буурч, 2020-2021 онд үзмэрийн тоо мөн буурсан. Музейн үзэгчдийн тоо ба үзмэрийн тооны хооронд шууд хамаарал байхгүй байна.

Зураг 26. Музейн үзмэрийн ба үзэгчдийн тоо



Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn), 2023

Музейн үзэгчдийн тоо жил бүр буурах хандлагатай бол урсгал зардал нь жил бүр нэмэгдэх хандлагатай байна. Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаг нийт музейн үзэгчдийн тоо, урсгал зардал, үндсэн үйл ажиллагаанаас олсон өөрийн орлого зэрэг үзүүлэлтийг гаргаж дараах хүснэгт 35-д харуулав.

### Хүснэгт 35. Музейн урсгал зардлын өгөөж

Үзүүлэлт	Үзэгчид (мянган хүн)	Нийт урсгал зардал (сая төг.)	Байгууллагын үйл ажиллагааны орлого (сая төг.)	1 үзэгчид ногдох жилийн үйл ажиллагааны зардал (төгрөг)	100 төгрөгийн зардалд ногдох өөрийн орлого (төгрөг)
2022 он	824.0	14,016.9	2,367.5	17,012	17

Эх сурвалж: СЯ, Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2013-2022.

Орлого олох боломжтой дараагийн соёлын үйлчилгээ бол музейн үйлчилгээ юм. 2013-2018 онд музейн салбар жилд 532.8-878.5 сая төгрөгийн орлого олсон бол Ковидын дараа 2022 онд 2.3 тэрбум төгрөгийн орлого олжээ. Музейн 1 үзэгчид ногдох үйл ажиллагааны зардал 2022 онд дунджаар 17,012 төгрөг байна. Энэ үзүүлэлт театр, чуулгын үйлчилгээний хувьд 37,017 төгрөг гарч байснаас 2 дахин бага байна. 2022 онд музейн үйлчилгээнд зарцуулсан 100 төгрөг тутамд 17 төгрөгийн орлого олжээ. Цаашид дэвшилтэт техник технологийн тусламжтайгаар үйлчилгээний онлайн хувилбарыг нэвтрүүлж, музейгээр үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлж, төсвийн хөрөнгийн үр ашиг, үр нөлөөг сайжруулах нь зүйтэй юм.

АНУ-ын Нью-Йорк хотын Метрополитен музей, Бангкок хотын Хааны ордон, Сөүл хотын Орчин үеийн урлагийн үндэсний музей зэрэг дэлхийн томоохон үндэсний музей, соёлын өвийн газрууд нь Ковидын үеэс ч өмнө үзэгчдэд виртуал аялал хийх боломжийг нээсэн байсан. Виртуал онлайн музейнүүд нь хэрэглэгчдэд газарзүйн байршлаас үл хамаарч музейн үзмэрийг илүү ойроос, нарийн тодорхой харах, дэлгэрэнгүй тайлбарыг унших, сонсох зэрэг шинэ боломжийг нээж өгч, соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байна. Түүнчлэн “Verizon”, “Google Arts and Culture” зэрэг вебд суурилсан платформд төрөл бүрийн соёл урлагийн дижитал цуглуулгуудыг оруулдаг болсон нь соёлын шинэ хандлагыг түгээж, соёлын үйлчилгээг хүн бүр хүртэх бололцоотой болгож байна. Харин манай улсын хувьд дижитал технологид суурилсан виртуал музейн үйлчилгээ бараг байхгүй, зөвхөн уламжлалт үзүүлэн хэлбэрийн музей байгаа нь хүүхэд, залуусын эрэлт хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна. Цаашид музейд орчин үеийн технологи нэвтрүүлж, интерактив видео контент бэлтгэх, VR төхөөрөмж зэрэгт зайлшгүй хөрөнгө оруулалт оруулах шаардлагатай гэж үзэж байна. Зөвхөн улсын төсвөөс гадна хувийн салбарын хөрөнгө оруулалтыг энэ салбарт татах нь зүйтэй юм.



## ШИГТГЭЭ. “БОГД ХААНЫ ОРДОН” МУЗЕЙ.



1924 онд байгуулагдсан Богд Хааны ордон музей нь Монголын сүүлчийн хаан VIII Богд Жавзандамба Хутагтын Ногоон ордонд байрлах хамгийн анхны музейн цогцолбор юм. Засгийн газрын 1926 оны тогтоолоор музейг Богд хааны Өвлийн ордонд шилжүүлэн байрлуулж, ордонд байсан түүх, соёл урлагийн зүйл, бурхан тахил, угсаатны зүйн эд өлөг, төрөл бүрийн амьтны чихмэл дүрс зэргийг музейн үзмэртэй нэгтгэжээ. Энэхүү музей нь Найдан сүм, Махранзын сүм, Номын сангийн сүм тэргүүтэй долоон сүм, Өвлийн ордон, Амгалан энхийн хаалга, Сэрүүн асар зэрэг 20 шахам байгууламжаас бүрдсэн цогцолбор юм. Музей 8600 гаруй үзмэртэй, жилд 40 мянга гаруй үзэгч хүлээн авдаг. Уг музей нь 2022 онд улсын төсвөөс 412.3 сая төгрөгийн төсвийг зарцуулж, үндсэн үйл ажиллагааны хүрээнд 260.7 сая төгрөгийн орлого олжээ. Жуулчдын хамгийн их сонирхдог музейн нэг юм. Музейн уламжлалт үйлчилгээнээс гадна эрдэм шинижлгээний хурал, өв соёлыг дэлгэрүүлэх арга хэмжээ, үзэгчдэд зориулсан сургалтын болон мэдээлэл түгээх арга хэмжээ зохион байгуулдаг байна. 2022 онд нийт төсвийнхөө 84 хувийг үндсэн үйл ажиллагаанд буюу цалин хөлс, НДШ, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, томилолтын зардал зэрэгт зарцуулсан.. 2020, 2021 онд музейн урсгал засварын зардалд 10-11 сая төгрөгийн төсвийн санал хүргүүлсэн ч төсөвт батлагдаагүй. 2021 онд Ковид-19 цар тахлын хөл хорионы үед хэмнэгдсэн төсвөөс 6.5 сая төгрөгийг урсгал засварт зарцуулсан байна.

### 9.3. Номын сангийн үйлчилгээний үр дүн, зардлын өгөөж

Нийслэл Улаанбаатар хотод Үндэсний номын сан, Хүүхдийн төв номын сан гэсэн төрийн өмчит 2 номын сан байгаа бол дүүрэг болон аймгуудад орон нутгийн өмчит нийт 23 номын сан улсын төсвөөс санхүүжилт авч байна. Түүнчлэн сум, дүүргийн соёлын төвүүдэд жижиг номын сан ажилладаг ба эдгээрийг оролцуулан тооцвол нийтдээ 360-380 номын сан байдаг байна. Номын сангийн уншигчдын тоо 2012-2018 оны хооронд тогтмол байсан бол 2019 онд 388,180 болж нэмэгдсэн байна. Гэхдээ уншигчдын тоо цар тахлын нөлөөгөөр 2021 онд 2 дахин буурч 191,348 болсон.

Номын фондын тоо нь номын сангийн тоотой хамааралтай байна. /Зураг 28/

Зураг 27. Номын сангийн уншигчдын тоо болон суудлын тооны харьцаа



Зураг 28. Номын сангийн тоо болон номын фондны тооны харьцаа



Эх сурвалж: www.i2i2.mn, 2023

Төрийн ба орон нутгийн өмчит 25 номын сангийн үйл ажиллагааны урсгал зардал, үндсэн үйл ажиллагаанаас олсон өөрийн орлогын хэмжээг дараах хүснэгт 36-д харуулав

Хүснэгт 36. Нийтийн номын сангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Байнгын уншигчдын тоо (мянган хүн)	Нийт урсгал зардал (сая төг.)	Байгууллагын үйл ажиллагааны орлого (сая төг.)	1 үзэгчид ногдох жилийн үйл ажиллагааны зардал (төгрөг)	100 төгрөгийн зардалд ногдох өөрийн орлого (төгрөг)
2022 он	306.3	7,524.0	80.2	24,566	2


Ковидын нөхцөл байдлаас өмнө 2013-2018 онд номын сангууд (соёлын төвд байрших номын сан, өрөөг оруулахгүйгээр) жилдээ 30-40 сая төгрөгийн орлого олдог байсан бол 2022 онд 80.2 сая төгрөг болж орлого нь нэмэгдсэн байна. 2022 онд номын сангийн 1 байнгын уншигчид ногдох үйл ажиллагааны дундаж зардал 24.6 мянган төгрөг байсан бөгөөд 100 төгрөгийн зардалд 2 төгрөгийн орлого олжээ. Номын сангийн үйлчилгээг нь иргэдэд үнэ төлбөргүй үзүүлдэг учраас үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд орлого олох боломж бараг байхгүй юм. Харин номын сангийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, номын сангаар цахимаар зайнаас үйлчлүүлэх боломжийг үйлчлүүлэгчдэд хангах

чиглэлээр ажиллах нь хүн амын боловсрол, соёл, хөгжилд үр дүнтэй хувь нэмэр болно.

#### 9.4. Соёлын төвийн үйлчилгээ үр дүн, зардлын өгөөж

Манай улсад 2012-2021 онд төр ба хувийн хэвшлийн 341-347 соёлын төв, ордон, өргөө байжээ. /Зураг 29/. Харин соёлын төвийн ажилтны тоо 2017 онд хамгийн бага буюу 2,339 хүн байсан бол 2021 онд 2,645 хүн болж 13% -аар нэмэгдсэн байна.

Зураг 29. Соёлын төвийн үзүүлэлтүүдийн харьцуулалт



Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn), 2023

2023 оны эхний хагас жилийн байдлаар орон нутгийн өмчит 344 соёлын төв байгаагаас 334 нь сумын соёлын төвүүд, 7 нь дүүргийн соёлын төвүүд болон Хүүхдийн урлан бүтээх төв, Соёлын төв өргөө, Хүүхдийн ордон байна. Эдгээр 344 соёлын төв, ордонд 2023 оны 6 дугаар сарын байдлаар 2,399 хүн ажиллаж байна.<sup>10</sup>

Соёлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “25.2.Сум, дүүргийн соёлын төв, соёлын ордон нь тухайн орон нутгийн иргэний соёлын үйл ажиллагаа эрхлэх, бүтээл туурвих, соёлын ололт, үр шимийг хүртэх нөхцөлийг хангах, орон нутгийн байгаль, түүх, соёлын үнэт зүйлийг сурталчлах, номын сангийн үйлчилгээ хүргэх чиг үүрэгтэй соёлын боловсрол олгох анхан шатны байгууллага бөгөөд соёл, мэдээллийн төв байна.” гэж заасан.

Соёлын төвүүд нь улсын ба орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаг тухай энэ тайлангийн өмнөх бүлгүүдэд дурдсан. 2022 онд Соёлын сайдын төсвийн багцын урсгал шилжүүлгээс соёлын төвүүдийн урсгал зардалд 30.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. 2012-2022 онд соёлын төвд ажиллагчдын тоо төдийлөн нэмэгдээгүй байна.

Соёлын төвүүдийн 1 суудалд ногдох жилийн үйл ажиллагааны зардал 2013-2018 оны дунджаар 460 мянган төгрөг, 2022 онд 343.4 мянган төгрөг байжээ. Энэ нь театр, чуулга, музейн нэг үйлчлүүлэгчид болон номын сангийн 1 уншигчид ногдох жилийн үйл ажиллагааны зардлаас өндөр байна. Сумын соёлын төвөөр үйлчлүүлсэн хүний тооны албан ёсны статистик мэдээллийг нийтэд зарладаггүй

<sup>10</sup> Соёлын яамнаас 2023 оны 7 дугаар сард авсан тоо мэдээ.

---

учраас I үйлчлүүлэгчид ногдох зардлыг тооцох боломжгүй байна. Сумын соёлын төвүүд нь соёлын үйлчилгээнүүд дотроос хамгийн өндөр өртөгтэй үйлчилгээ байх магадлалтай байна. Хэдийгээр зардлын хувьд өртөгтэй ч хүн амд соёлын үйлчилгээг түгээх анхан шатны нэгж учраас зайлшгүй байх шаардлагатай билээ. Соёлын төв гэж юу болох ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг талаар урлагийн судлаачид тодорхойлсон байна. Соёлын төв бол хүмүүст урлагаар дадлага, сургалт хийх, соёлын арга хэмжээнд оролцох аль аль нөхцөлийг бүрдүүлдэг нийтийн эзэмшлийн газар юм. Соёлын төв нь концерт, театрын жүжиг, хошигнол, мюзикл, уран зургийн үзэсгэлэн, тэр ч байтугай хотын симфони найрал хөгжмийн тоглолтын газар байж болно. (Lambert, 2017) Соёлын төвүүд нь зөвхөн нэг зорилгоор ашигладаг театр, чуулга зэргээс ялгаатай бөгөөд ихэвчлэн өөрийн гэсэн урлагийн хүний нөөцтэй байдаггүй байна.

Дэлхийн II дайны дараа баруун, хойд, өмнөд Европын ихэнх хэсэгт нийгмийн халамж бий болж, урлаг, соёлын төсвийн санхүүжилтээр Соёлын төвүүдийг байгуулж, төрөөс дэмжиж эхэлсэн байна. Ялангуяа, ЗХУ-аас тусгаарласан Зүүн Европын орнууд нь хот, дүүрэг, тосгон болгондоо төрийн өмчийн эсхүл төрийн менежментийн соёлын төвүүдтэй байсан бөгөөд тэдгээрийн ихэнх нь өнөөг хүртэл үйл ажиллагаа явуулсаар байна. (Bogen, 2018) 20-р зууны хоёрдугаар хагаст Баруун Европт төрөөс болон орон нутгаас татаас авдаг соёлын төвүүдийн хажуугаар төрийн бус болон хувийн хэвшлийн янз бүрийн төрлийн соёлын төвүүд үүсэж эхэлсэн байна.

АНУ, Франц, Норвег, Канад зэрэг орнуудын урлагийн байгууллагуудад олгодог төсвийн санхүүжилтийн хэмжээ 1990-ээд оноос эхэлж буурсан (Mulcahey, 2000). Түүнчлэн 2008 онд тохиолдсон Европын санхүүгийн хямралын дараа урлаг, соёлын төвүүдэд олгох төсвийн санхүүжилт буурсан байна. Энэ бүхэн нь хувийн хэвшлийн урлаг, соёлын төвүүд нэмэгдэж, соёлын үйл ажиллагааны өөр шинэлэг, орчин үеийн хэлбэр бий болох нөхцөл болсон.

Европ дахь хувийн соёлын төвүүдийн талаар хийсэн судалгааны дүнгээр дундаж “ердийн” хувийн Соёлын төв нь ихэвчлэн хот суурин газарт байрлах ба дунджаар 2500 хавтгай дөрвөлжин метр талбайтай, 19 ажилтантай, 1.25 сая еврогийн төсөвтэй ба жилд 200 орчим соёлын арга хэмжээг зохион байгуулж, 75,000 үзэгчийг хамруулдаг байна (Bogen, 2018). Эдгээр төвүүд түрээсийн орлогоос хамгийн их орлого олж, баар, кофе ажиллуулдаг. Соёлын төвүүд нь 13 өөр төрлийн соёл урлагийн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд дунджаар найман өөр төрлийн урлагийн үйлчилгээ үзүүлдэг байна. Үүнд, 93% нь дүрслэх урлагийн, 84% нь хөгжмийн, 82% нь театрын, 78% нь кино болон видео контент, 60% нь бүжгийн, 53% нь клуб, үдэшлэгийн, 49% нь орчин үеийн технологийн, 47% нь гадна талбайн фестиваль, 40% нь үргэлжилсэн үгийн зохиол, 29% нь гар урлал, 29% нь хошин шогийн, 24% нь цирк/багт наадам, 22% нь уран зохиолын үйлчилгээ тус тус үзүүлж байна. Түүнчлэн бүх соёлын төвүүдийн хөтөлбөрт сургалт, хичээл, мэтгэлцээн, лекц зэрэг боловсрол олгох төрлийн үйл ажиллагаа ч мөн багтдаг байна.

Австрали Улсын Брисбане хотод байрлах урлагийн төвийн зургийг доор харуулав. Урлагийн танхимаас гадна баар кафе ажиллуулдаг байна.





Зураг 30. Австралийн Брисбане хотын урлагийн төв



Зураг 31. Урлагийн төвийн дотор тал

Латви Улсын Парламент 2022 оны 2 дугаар сарын 27-ны өдөр “Соёлын төвийн тухай” хуулиа шинэчлэн батлуулжээ.<sup>11</sup> (Saeima, 2023) Энэ хуульд Соёлын төвийг орон нутгийн засаг захиргааны нэгжээс байгуулах бөгөөд дараах чиг үүрэгтэй байхаар заажээ. Үүнд:

- 1) Соёлын арга хэмжээг санаачлах, зохион байгуулах, насан туршийн боловсролын арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 2) Дуу, бүжгийн тэмцээн, баяр зохион байгуулах, үндэсний ардын урлагийн болон олон улсын арга хэмжээнд сонирхогчдыг оролцуулахад дэмжлэг үзүүлэх;


<sup>11</sup> Латви Улсын Соёлын төвийн тухай хуулийг Kultūras centru likums (likumi.lv) вэб хуудаснаас харах боломжтой.

- 
- 3) Төрөл бүрийн мэргэжлийн урлаг, соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх, бүтээлч байдал, орон нутгийн бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
  - 4) Орон нутгийн соёл, түүхийн орчин, өвөрмөц байдал, соёлын биет бус өвийн хадгалалт, хөгжлийг хангах;
  - 5) Түүхийн мэдлэг олгох, орон нутгийн түүхээ сурталчлах, соёлын аялал жуулчлалын үйлчилгээг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах;
  - 6) Тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчдын соёлын үйлчилгээний хэрэгцээг тодорхойлон нэгтгэж, түүнд нийцсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Манай улсын хувьд сумын соёлын төвүүдийн үйл ажиллагаа хязгаарлагдмал, хоцрогдсон хэвээр байна. Өнгөрсөн 11 жилийн хугацаанд 301 соёлын төвийг шинээр барьсан боловч үйл ажиллагааны цар хүрээ төдийлөн нэмэгдээгүй атлаа урсгал зардал нэмэгдсэн байна. Сумын соёлын төвүүдийг шинээр барихдаа архитектор дизайны орчин үеийн шийдлийг харгалзан үзэх нь зүйтэй юм. Сумдад хүн амын тоо цөөн, соёлын үйлчилгээнд төлбөр төлөх боломж орон нутгийн иргэдийн хувьд хязгаарлагдмал учраас сумын соёлын төвүүдийг хувийн хэвшилд шилжүүлэхийг санал болгохгүй. Одоогийн дүрэм журмын дагуу соёлын төв нь номын сангийн өрөө, музейн үзүүлэнгийн булан ажиллуулж, зарим улиралд нийтийн бүжиг зохиох, хурал цуглаан зохион байгуулах байдлаар үйл ажиллагаа явуулж байна. Соёлын төв нь цоожтой байдаг, түлш халаалтын зардал өндөртэй байшин байх ёсгүй харин хүүхэд болон насанд хүрэгчдийн хөл хөдөлгөөнд дарагдсан соёлын олон төрлийн үйлчилгээ үзүүлэх газар байж төсвийн хөрөнгийн үр ашгийг хангах юм. Иймд одоогийн байгаа хүний нөөцөд тулгуурлан орлого олох үйл ажиллагаануудыг нэвтрүүлэх, төрийн байгууллагын хандлагаас олон нийтийн төв байх хандлага чиглүүлэх, хувь уран бүтээлчид, сайн дураар урлагаар хичээллэгч, сонирхогчдыг хөгжүүлэх орон зайг бий болгох нь зүйтэй байна. Түүнчлэн бүх насныханд зориулсан хөгжим, дуу, зургийн дугуйлангуудыг хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулж болно. Сумын соёлын төвүүдийн үйл ажиллагааны хамгийн чухал үр дүн бол тухайн нутаг дэвсгэрт амьдарч байгаа иргэдэд нийтийн соёлын боловсрол олгох, соёл, мэдээллийн төв явдал юм.

Харин олон хүн амтай томоохон сумдад соёлын төвийн үйл ажиллагааг нь өргөтгөх, хувийн хэвшлийн болон орон нутгийн төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн засаг захиргаанд тодорхой хугацаагаар гэрээгээр шилжүүлэх хувилбарыг туршиж үзэж болно. Ялангуяа, улсын төсвөөс татаас авдаггүй аймгуудын сумдын соёлын төвийн үйл ажиллагаанд шинэчлэл хийх нь зүйтэй юм.

## ШИГТГЭЭ. ХОНГОР СУМЫН “СОЁЛЫН ТӨВ”



Дархан-Уул аймгийн Хонгор сумын Соёлын төв нь 100 хүний суудалтай бөгөөд иргэдэд номын сан, музей, соёл, урлагийн үйлчилгээ үзүүлдэг. Соёлын төв нь дарга, номын санч, музейн ажилтан, нягтлан, бүжгийн багш, хөгжмийн багш, үйлчлэгч, нярав гэсэн 8 орон тоотой. Номын санч ба нягтлангийн ажлыг 1 хүн хавсарч хийдэг учраас 7 хүн ажиллаж байна. Соёлын төвийн үйл ажиллагааны 2023 оны төсөв нь 98 сая төгрөг байна. Үүний 52 сая төгрөгийг улсын төсвөөс, 56 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ. 2023 оны эхний 8 сарын хугацаанд 24 удаа гэрээр ном олгож, эвент, үзэсгэлэн 4 удаа зохион байгуулж 480 хүнийг хамруулсан, 15 хүн номын сангаар үйлчлүүлснээс 8 нь хүүхэд, орон нутаг судлах танхимыг 9 хүн үзсэнээс 6 нь хүүхэд байна. Ямар нэг урлагийн тоглолт зохион байгуулаагүй. Эхний 8 сарын гүйцэтгэлээр өөрийн үйл ажиллагаанаас 2.2 сая төгрөг олсон. Нийтийн бүжиг зохион байгуулах, хувь уран бүтээлч, байгууллагуудтай хамтарч ажиллаж орлого олдог. Сумын иргэдийг оролцуулан урлаг, уран сайхны тоглолт зохион байгуулдаг, авьяастай иргэдээ аймаг, нийслэлд тэмцээн, уралдаанд оролцуулдаг зэрэг орлого олдоггүй үйл ажиллагааг мөн хэрэгжүүлдэг. Хонгор сум нь Дархан-Уул аймгийн төвөөс 20 км зайтай байдгаас үйлчлүүлэгчийн тоо бага, сумын иргэд урлагийн үзвэр, үйлчилгээг Дархан суманд очиж авах нь түгээмэл байна.

Хонгор сумын Соёлын төвийн эрхлэгч Г.Сайхансанаатай уулзалт хийж ярилцахад “Байгууллагын төсөв бага, бичиг хэргийн зардлын төсөв сард

*25 мянган төгрөг, шатахууны зардлын төсөв сард 25 мянган төгрөг байгаа нь хангалтгүй байна. 250-300 хүний суудалтай шинэ соёлын төвийн барилга бариулахад шаардагдах 1.3 тэрбум төгрөгийн төсвийн саналаа 2024 оны улсын төсөвт тусгуулахаар хүргүүлсэн.” гэж саналаа илэрхийлэв*

## **9.5. Соёлын бүтээлч үйлдвэрлэл**

Соёл бүтээлч үйлдвэрлэл гэдэг нь бүтээлч хандлагад тулгуурлан, оюуны өмчийн эрхийн баталгаажсан бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээх, түгээх байдлаар ашиг, орлого олох, ажлын байр бий болгох инновацад суурилсан үйл ажиллагаа, түүний үр дүн юм. Бүтээлч үйлдвэрлэлийг дэлхийн улс орнуудад мэдлэгийн эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг гэж үзэж үндэсний хүрээнд дэмжин хөгжүүлж байна (Т.Намнан, 2021). Засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 24-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор “Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл (2022-2027), “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ (2022-2030 он)”-г тус тус батлан хэрэгжүүлж байна. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээг соёлын өв, утга зохиол, ном хэвлэл, дүрслэх урлаг, дуу, хөгжим, тайзны урлаг, кино, дуу дүрсний урлаг, хэвлэл мэдээлэл, хувцас загвар, архитектур, дизайн, дижитал контент, тоглоом хөгжүүлэлт, маркетинг, зар сурталчилгаа гэсэн үндсэн чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр тогтоосон байна.

Соёлын бүтээлч үйлдвэрлэл нь дэлхийн Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 3.1%, нийт ажил эрхлэлтийн 6.2% -ийг бүрдүүлдэг. Улс орнуудын соёлын бараа, үйлчилгээний экспорт 2005 оныхоос хоёр дахин нэмэгдэж, 2019 онд 389.1 тэрбум ам.долларт хүрсэн байна. (UNESCO, 2022). Соёлын бүтээлч үйлдвэрлэл нь дэлхийн хамгийн залуу бөгөөд хамгийн хурдацтай хөгжиж буй эдийн засгийн салбаруудын нэг боловч хамгийн эмзэг салбаруудын нэг учраас төр болон хувийн хэвшлийн дэмжлэг зайлшгүй чухал байдаг байна.

Соёлын яам 2021 онд анх удаа Монголын маркетингийн судалгааны ассоциацитай хамтран соёлын бүтээлч үйлдвэрлэлийн талаарх судалгаа хийсэн байна. Энэхүү судалгаагаар Монгол Улсын соёлын бүтээлч үйлдвэрлэлийн эдийн засгийн хамрах хүрээний (Соёлын бүтээлч үйлдвэрлэл+тоног төхөөрөмж, дагалдах материал+холбогдох салбар) нэмэгдэл өртгийн хэмжээ 2020 онд оны үнээр 982.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.6%-ийг эзэлж байна. Соёлын салбар 2020 онд нийт 362,209.76 ам.долларын үнэлгээ бүхий бүтээгдэхүүн экспортолсон. 2010-2020 оны нийт экспортын 47.7% нь соёлын бараа, бүтээгдэхүүн байсан бол 52.3% нь тоног төхөөрөмж дагалдах материал байна. Харин 2020 оны нийт экспортын дүнгийн 19.5%-ийг соёлын бараа бүтээгдэхүүн, үлдсэн 80.5%-ийг тоног төхөөрөмж дагалдах материал эзэлж байна. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарт 2020 онд 33.9 мянган хүн, тоног төхөөрөмж, дагалдах материалын салбарт 26.7 мянган хүн, нийтлэг хамааралтай салбарт 12.9 мянган хүн, холбогдох салбарт 1.3 мянган хүн тус тус ажиллаж байна. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарт ажиллагчдын 27% нь хувцас загварын, 24% нь өв соёлын, 17% нь дүрслэх урлаг, гар урлалын салбарт



---

ажиллаж байгаа бол дижитал инновац, контентын салбарт ажиллагчдын эзлэх хувь дөнгөж 4% байна (Монголын маркетингийн судалгааны ассоциаци, 2021).

Соёлын сайдын төсвөөс 2022 онд “соёлын бүтээлч үйлдвэрлэл”-д 1,553.4 сая төгрөгийг, “цахим соёл” зориулалтад 1,035.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Соёлын сайдын 2023 оны төсөвт соёлын бүтээлч үйлдвэрлэлд 1,750.0 сая төгрөг, цахим соёлд 1.0 тэрбум төгрөгийг тус тус баталсан байна. Соёлын бүтээлч үйлдвэрлэл болон цахим соёлыг дэмжих зорилгоор зарцуулсан 2,589.3 сая төгрөгийг ямар арга хэмжээнд зарцуулсан талаарх задаргаа мэдээлэл төсвийн гүйцэтгэлийн тайлангаас дэлгэрэнгүй харагдахгүй байсан тул зардлын хуваарилалтад шинжилгээ хийх боломжгүй байлаа. Соёлын сайдаас шууд зарцуулах төсвийг зарцуулахдаа тухайн үед холбогдох тушаал, шийдвэр, үндэслэлийг гаргаж зарцуулдаг байна. Цаашид соёлын бүтээлч үйлдвэрлэл ба цахим соёлын чиглэлийн зардлыг тусад нь төсвийн хөтөлбөр болгон батлуулж, зардлын төсвийг нь зориулалт, арга хэмжээгээр салгаж батлуулан урьдчилан төлөвлөдөг байх нь зүйтэй байна. Ийнхүү соёлын бүтээлч үйлдвэрлэл ба цахим соёлыг тусдаа хөтөлбөр болгосон тохиолдолд хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж, дэвшүүлсэн зорилтдоо хүрч байгаа эсэхийг хянах боломжтой болно.

Дэлхийн улсуудад дижитал эдийн засаг, соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийн салбарууд бие биеэсээ харилцан хамаарч, уран бүтээлч, хэвлэн нийтлэгч, үзэгчид болон технологийн компаниуд харилцан хамааралтай ажиллаж байна. Хиймэл оюун ухаан, виртуал бодит байдал, блокчэйн нь контентыг үйлдвэрлэх, түгээх, хэрэглэх арга замыг өөрчлөх боллоо. Үр нөлөө нь зөвхөн бүтээлч үйлдвэрлэлийн салбарыг төдийгүй нийгмийг бүхэлд нь өөрчилж байна (World Economic Forum, 2018)<sup>12</sup>. Соёлын бүтээгдэхүүн (кино, видео, хөгжим гэх мэт) үйлдвэрлэгч мэргэжлийн хүмүүс, байгууллагууд томоохон дижитал платформууд, олон нийтийн сошиал мэдээллийн хэрэгсэл болон дижитал төхөөрөмжүүдтэй (гар утас, таблет) нягт ажилладаг болсон (United Nations Conference on trade and Development, 2019).<sup>13</sup>

Соёлын бүтээлч үйлдвэрлэл бий болох суурь нөхцөл нь дижитал технологи, дижитал дэд бүтэц юм. Түүнчлэн хэрэглэгчдийн “дижитал”-ын хэрэглээ, мэдлэг ойлголт, хандлага маш чухал юм.

Цар тахлын үеэс эхлэн онлайн үйл ажиллагаа эрчимтэй өссөн. Жишээлбэл Netflix дээр 1 минутад үзсэн цагийн тоо 2016 онд 69,444 байсан бол 2021 онд 584,222 болж өссөн. Facebook-т нэвтэрдэг хүний тоо 1 минутад 700 мянга байсан бол 1.3 сая болж 2 дахин нэмэгдсэн, Google-ийн хайлтын 1 минутад ногдох тоо 2.4 саяас 4.8 сая болж 2 дахин нэмэгдсэн, YouTube-н үзэгчдийн тоо 1 минутад 2.8 саяас 5.0 сая болж өссөн байна. Платформууд болон шинээр гарч ирж буй хиймэл оюун ухаан (AI) технологи, виртуал бодит байдал, блокчэйн зэрэг дижитал хэрэглээний шинэ хэлбэрүүдийг бий болгосон (UNESCO, 2022).

---

<sup>12</sup>[www.weforum.org/whitepapers/creative-disruption-the-impact-of-emerging-technologies-on-the-creative-economy](https://www.weforum.org/whitepapers/creative-disruption-the-impact-of-emerging-technologies-on-the-creative-economy).

<sup>13</sup><https://unctad.org/webflyer/digital-economy-report-2019>.


Хүснэгт 37. Интернэтэд 1 минутад эргэлдэж буй мэдээллийн хэмжээ

Төрөл	2016	2021
Фейсбүүк нэвтрэлт	701,389	1,300,000
Нэтфликс (Netflix) үзсэн цаг	69,444	584,222
Жиргээний (new tweets) тоо	347,222	381,532
Хуваалцсан snaps (shared)	527,760	2,985,000
Apple.аас апп татсан тоо	51,000	234,817
Амазоны (Amazon) борлуулалт (ам. доллар)	203,596	508,699
Гүүглийн хайлт	2,400,000	4,812,040
Спотифай (Spotify) сонссон цаг	38,052	196,917
Инстаграмын пост	38,194	64,320
Youtube үзэлтийн тоо	2,780,000	5,039,650

Эх үүсвэр. (BOP Consulting, 2021)

Хэдийгээр дижитал үйлдвэрлэлд хувийн секторууд гол үүргийг гүйцэтгэж буй боловч улс орнууд соёлын салбарыг дижитал орчинд хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал, 2021 онд хийсэн судалгаагаар, дэлхийн улс орнууд дижитал орчинд соёлын хөгжлийг дэмжихдээ аналог системээс дижитал систем рүү шилжихэд санхүүжилт үзүүлэх, дижитал орчинд ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх, дотоодод хийсэн дижитал контентыг түгээх, дижитал соёл, бүтээлч үйлдвэрлэлийн зах зээлд оролцогчдыг дэмжих чиглэлээр тус тус дэмжлэг үзүүлсэн байна. Дараах зурагт харуулснаар, улс орнуудын 3Г-ын 80% нь аналогоос дижитал системд шилжихэд санхүүгээр дэмжсэн, улсуудын 71% нь урлаг, соёлын мэргэжилтнүүдийн ур чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн бол улсуудын 60% нь дотооддоо үйлдвэрлэсэн дижитал соёлын бүтээгдэхүүнийг

Зураг 32. Дижитал орчинд соёлын салбарыг дэмжих төрийн дэмжлэг



илрүүлж, түгээн хүртээмжийг нэмэгдүүлэхэд тусалсан, харин улс орнуудын 44% нь дотоодын дижитал соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийн зах зээлд тоглогчдын олон талт, ялгаатай байдлыг тус тус дэмжсэн байна. /Зураг 32/

Монгол Улсын хувьд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг 4 хувьд хүргэх зорилтод хүрэхийн тулд баримтлах стратеги, дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөг тодорхой гаргах шаардлагатай юм. Ялангуяа, соёлын үйлчилгээнд дижитал технологийг нэвтрүүлэх, урлагийн үзүүлбэрийн виртуал, онлайн хувилбарыг бий болгох чиглэлээр дэвшилтэт технологи, тэдгээртэй ажиллах хүний нөөц, боловсон хүчинд хөрөнгө чадвартай боловсон хүчнийг бэлтгэх, дижитал контентыг дэмжих, санхүүжүүлэх, түгээх сурталчлах зэрэг үр дүнтэй арга хэмжээнд зарцуулах нь зүйтэй байна.

### ШИГТГЭЭ. БНСУ-ЫН 'BEYOND LIVE', ЯПОНЫ 'UNITIVE' ОНЛАЙН ПЛАТФОРМУУД



Виртуал концерт гэдэг нь уран бүтээлчийн тусгал нь виртуал тайзан дээр үзүүлэх дуу хөгжмийн үзүүлбэр юм. Сүүлийн жилүүдэд виртуал ертөнцөд хөгжмийн хэрэглээний иймэрхүү шинэлэг, инновац бүхий олон амжилттай жишээ гарч байна. Хамгийн амжилттай виртуал тоглолтуудын нэг бол Fortnite дээр үзүүлсэн Травис Скоттын үзүүлбэр юм. Америкийн реппер, продюсер Трэвис Скотт Epic Games-тэй хамтран “Astroworld” хэмээх шинэ цомгоо сурталчлах зорилгоор 2020 оны 4 дүгээр сард Метаверс маягийн нээлттэй World Game Fortnite-д виртуал концерт хийсэн. Fortnite-ийн бүх ертөнц 15 минутын тоглолтын тайз болон хувирч, Трэвис Скоттын 3D хувилбар гарч ирэв. Дуучны дуу солигдоход түүний болон хэрэглэгчдийн дүр төрх өөрчлөгдсөн. Виртуал тоглолтын үеэр 27.7 сая гаруй тоглогч

---

оролцсон бөгөөд тоглогчид бүжиглэж, тайзан дээр алхаж, уран бүтээлчийг өөр өнцгөөс харах боломжтой байсан. Виртуал концертыг төлөвлөхөд дижитал уран бүтээлчид, хөгжүүлэгчид, бүтээлч технологичид, бүх виртуал орчныг бий болгох зураг авалтын мэргэжилтнүүд, аватар бүтээх уран бүтээлчид, бүжиг дэглээч зэрэг олон уран бүтээлчид шаардлагатай. Виртуал концертын дизайны чухал хэсэг бол жүжигчний дүр төрх юм. Хөдөлгөөн мэдрэх технологиор дамжуулан жүжигчнийг эхнээс нь загварчлах хэрэгтэй болдог. Жүжигчний эргэн тойронд тавьсан хэд хэдэн камерын бичлэг болон жүжигчний биеийн хэсэг болгонд байрлуулсан мэдрэгч нь уран бүтээлчийн дохио зангаа, хөдөлгөөн бүрийг илрүүлэх үүрэгтэй. Мэдрэгчийн бичсэн мэдээллийг дараа нь жүжигчний хөдөлгөөнт 3D загварыг бүтээх ба дээрээс нь жүжигчний дууг тохируулан оруулна. Дараа нь жүжигчний дижитал хувилбарыг 3D орчинд байрлуулж, үзүүлбэрийн сэдэвт тохируулан загварчилж, өөрчлөх боломжтой.ан бүтээлчид /найруулагч, хөгжимчид г.м/, тоног төхөөрөмж их шаардлагатай байна” гэж ярих.

## ШИГТГЭЭ. “МЕТАВЕРС ДЭЭРХ ВИРТУАЛ КОНЦЕРТ”.



Виртуал концерт гэдэг нь уран бүтээлчийн тусгал нь виртуал тайзан дээр үзүүлэх дуу хөгжмийн үзүүлбэр юм. Сүүлийн жилүүдэд виртуал ертөнцөд хөгжмийн хэрэглээний иймэрхүү шинэлэг, инновац бүхий олон амжилттай жишээ гарч байна. Хамгийн амжилттай виртуал тоглолтуудын нэг бол Fortnite дээр үзүүлсэн Травис Скоттын үзүүлбэр юм. Америкийн реппер, продюсер Трэвис Скотт Epic Games-тэй хамтран “Astroworld” хэмээх шинэ цомгоо сурталчлах зорилгоор 2020 оны 4 дүгээр сард Метаверс маягийн нээлттэй World Game Fortnite-д виртуал концерт хийсэн. Fortnite-ийн бүх ертөнц 15 минутын тоглолтын тайз болон хувирч, Трэвис Скоттын 3D хувилбар гарч ирэв. Дуучны дуу солигдоход түүний болон хэрэглэгчдийн дүр төрх өөрчлөгдсөн. Виртуал тоглолтын үеэр 27.7 сая гаруй тоглогч оролцсон бөгөөд тоглогчид бүжиглэж, тайзан дээр алхаж, уран бүтээлчийг өөр өнцгөөс харах боломжтой байсан. Виртуал концертыг төлөвлөхөд дижитал уран бүтээлчид, хөгжүүлэгчид, бүтээлч технологичид, бүх виртуал орчныг бий болгох зураг авалтын мэргэжилтнүүд, аватар бүтээх уран бүтээлчид, бүжиг дэглээч зэрэг олон уран бүтээлчид шаардлагатай.

Виртуал концертын дизайны чухал хэсэг бол жүжигчний дүр төрх юм. Хөдөлгөөн мэдрэх технологиор дамжуулан жүжигчнийг эхнээс нь загварчлах хэрэгтэй болдог. Жүжигчний эргэн тойронд тавьсан хэд хэдэн камерын бичлэг болон жүжигчний биеийн хэсэг болгонд байрлуулсан мэдрэгч нь уран бүтээлчийн дохио зангаа, хөдөлгөөн бүрийг илрүүлэх үүрэгтэй. Мэдрэгчийн бичсэн мэдээллийг дараа нь жүжигчний хөдөлгөөнт 3D загварыг бүтээх ба дээрээс нь жүжигчний дууг тохируулан оруулна. Дараа нь жүжигчний дижитал хувилбарыг 3D орчинд байрлуулж, үзүүлбэрийн сэдэвт тохируулан загварчилж, өөрчлөх боломжтой.ан бүтээлчид /найруулагч, хөгжимчид г.м/, тоног төхөөрөмж их шаардлагатай байна” гэж яриу.

---

## 10. ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

---

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д төсвийн ил тод байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлэхдээ төсвийн байгууллагууд нь төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих, төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор тус тус хангахыг хуульчилсан байдаг.

Түүнчлэн Төсвийн тухай хуульд хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх тухай заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл болон ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагууд нь төсөв, санхүүгийн мэдээллээ тодорхой давтамжийн дагуу [www.shilendans.mn](http://www.shilendans.mn) цахим хуудсанд нийтэд ил тод мэдээлэх үүрэгтэй. Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн аудитын тайланд дурдсанаар 2020 онд Соёлын яам шилэн дансны мэдээллээ цаг хугацаандаа оруулсан боловч Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь цахим хуудсанд 2,640 мэдээлэл оруулахаас 509 мэдээллийг хугацаа хоцроож, 10 мэдээллийг байршуулаагүй, 2021 онд Соёлын яам нь 140 мэдээлэл байршуулахаас 4 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан гэж дүгнэсэн байна.

Соёлын сайд 2022 онд шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 79 мэдээллийг хугацаанд нь оруулсан байна. Соёлын сайдын эрхлэх хүрээний 460 байгууллагууд нийт 2,812 мэдээллийг байршуулахаас 2,330 мэдээллийг хугацаанд нь, 205 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бол 277 мэдээллийг байршуулаагүй хэрэгжилт гэж дүгнэжээ.

Хэдийгээр тухайн оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагч, шууд захирагчаар сараар гаргаж цахим хуудсанд ил тод байршуулж байгаа боловч, төсвийн зардлыг эдийн засгийн ангиллаар харуулдаг тул энгийн иргэд, олон нийт ийм мэдээлэлд боловсруулалт хийж, дүн шинжилгээ хийх, харьцуулалт хийх бараг боломжгүй байна. Шилэн дансны цахим хуудсанд байрших мэдээллийг шууд санхүүгийн тайлангаас авч тавихаас гадна олон нийтэд ойлгомжтой байдлаар мэдээлэх чиглэлээр холбогдох дүрэм, журмыг сайжруулах шаардлагатай байна.

Соёлын сайдын төсвийн багцаас орон нутгийн өмчит соёлын байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас бусад төсвийг хариуцдаг. Уг төсөв нь Соёлын сайдын төсөвт ЗГ-ын дотоод шилжүүлэг ангиллаар бөөн дүнгээр батлагддаг. Энэхүү зарлагын шинжилгээний тайланг боловсруулах явцад орон нутгийн соёлын байгууллагуудын төсөв, төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг



---

олж авахад хүндрэлтэй байлаа. Цаашид орон нутгийн соёлын байгууллагуудын төсвийн мэдээллийг театр, чуулга, музей, номын сан, сумын соёлын төв зэргээр байгууллага бүрээр системд харагдах нөхцөлийг бүрдүүлж, төсвийн ерөнхийлөн захирагчийг хяналт тавих, удирдамж, зөвлөгөөгөөр хангах бололцоотой болгох нь зүйтэй юм.

Соёлын салбарт Кино урлагийг дэмжих сан, Соёл, урлагийг дэмжих сан гэсэн Засгийн газрын хоёр тусгай сан харьяалагддаг. Кино урлагийг дэмжих сан 2020 онд байгуулагдаж 10.0 тэрбум төгрөгийн төсөв тавигдсан боловч холбогдох эрх зүйн баримт бичиг, зарцуулалтын дүрэм, журам батлагдаагүй байсан тул тухайн онд зарцуулалт хийж чадаагүйн улмаас төсөвт буцаж татагдсан. 2021, 2022 онд уг санд төсөв батлагдаагүй байна. Кино урлагийг дэмжих сан нь монголын кино урлаг, киноны уран бүтээлчдийг дэмжих, дэлхийд өрсөлдөх кино үйлдвэрлэлийг хөгжүүлэх, түүх соёл, ахуй амьдрал, хүүхэд залуучуудын хүмүүжил, төлөвшилд эергээр нөлөөлөх кино, ОУ-ын кино наадамд өрсөлдөх зорилготой уран бүтээлийг дэмжих зорилготой байна. Уг сангаас эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг авч болно. Түүнчлэн киноны дэд бүтэц, техник технологи, инновац нэвтрүүлэхэд хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкаар дамжуулан олгохоор зохицуулсан байна.

Засгийн газрын 2020 оны 120 дугаар тогтоолоор “Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг баталсан. Соёлын яамны веб хуудсанд Соёл, урлагийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан иргэн, хуулийн этгээдийн нэрсийн жагсаалтыг ил тод тавьсан байна. Уг сангаас 2017-2019 онд олгосон санхүүгийн дэмжлэгийн хэмжээг авсан иргэн, хуулийн этгээд бүрээр мэдээлэл болгон веб хуудсанд ил тод мэдээлсэн байна. Харин 2021-2023 онд сангаас олгосон санхүүгийн дэмжлэгийн хэмжээг мэдээлэлгүй, зөвхөн хүлээн авагчийн нэрсийг мэдээлсэн байна.

---

## 11. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОЙ УЯЛДСАН СОЁЛЫН САЛБАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД<sup>14</sup>

---

**ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН БА ТҮҮНД ДАСАН ЗОХИЦОХ,  
ДАВАН ТУУЛАХ ЧАДАВХ.  
/ENVIRONMENT & RESILIENCE/**

### **СОЁЛЫН ӨВИЙН ЗАРДАЛ. /EXPENDITURE ON HERITAGE/**

**Тодорхойлолт:** Соёлын болон байгалийн бүх өвийг хадгалах, хамгаалах, сэргээн засварлахад зарцуулсан нэг хүнд ногдох нийт зардлын хэмжээг ойлгоно.

**Зорилго:** Энэхүү үзүүлэлт нь соёлын болон байгалийн өвийг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах чиглэлээр төрийн байгууллага, орон нутаг, үндэсний болон олон улсын түвшинд дангаараа болон эсвэл иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлж буй санхүүжилтийн хэмжээ нь өвийг хамгаалахад хэрхэн шууд нөлөөлж байгааг харуулна.

**Эх үүсвэр:** UNESCO статистик, Үндэсний статистикийн хороо, Харьяалах захиргааны байгууллага

Тооцох аргачлал: 
$$PPC_{exp} = \frac{\sum Exp_{pub} + \sum Exp_{pr}}{Population}$$

**PPC<sub>exp</sub>**= Нэг хүнд ногдох хадгалах, хамгаалах, сэргээн засварлах зардал

**Exp<sub>pub</sub>**= Засгийн газар, орон нутгийн зардал /үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардал/

**Exp<sub>pr</sub>**= Хувийн секторын санхүүжилт, биет болон биет бус хандив, тусламж, ивээн тэтгэлэг

Зөвлөмжид тусгах эсэх: **ТИЙМ**

### **2.СОЁЛЫН ӨВИЙН ТОГТВОРТОЙ БОДЛОГО /SUSTAINABLE MANAGEMENT OF HERITAGE/**

**Тодорхойлолт:** Соёлын болон байгалийн өв, туршлага, мэдлэг, түүхийн хөдлөх, үл хөдлөх эд өлгийн зүйлийг хамгаалах, удирдах тогтвортой менежментийн тогтолцоог олж тогтоох.

**Зорилго:** Энэхүү үзүүлэлт нь өвийн тогтвортой байдлыг хамгаалах, дэмжих олон нийтийн үйл ажиллагааны давуу болон сул талуудын ерөнхий дүр зургийг гурван бүрэлдэхүүн хэсэгт дүн шинжилгээ хийх замаар тодорхойлно.

- үндэсний болон олон улсын бүртгэл, бараа материал;
- өвийг хадгалах, хамгаалах, удирдахад бүх оролцогч талуудыг хамруулж,



- 
- тогтвортой байдлыг бий болгох үйл ажиллагаа;
  - өвийг хамгаалах, сэргээхэд чиглэсэн дэмжлэгийн түвшин.

**Эх үүсвэр:** UNESCO data, Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Харьяалах захиргааны байгууллага, тусгайлсан судалгаа, боломжтой бол соёлын салбарын мэдээллийн систем

**Тооцох аргачлал:** Тоон болон тийм/үгүй хариулт бүхий санал асуулга

Зөвлөмжид тусгах эсэх: **ҮГҮЙ**

### **3.УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ БОЛОН ДАВАН ТУУЛАХ ЧАДАВХ. /CLIMATE ADAPTATION & RESILIENCE/**

**Тодорхойлолт:** Уур амьсгалд дасан зохицох, ялангуяа уламжлалт арга барилыг багтаасан даван туулах чадварыг олж тогтоох.

**Зорилго:** Энэ үзүүлэлт нь соёлын биет болон биет бус өв, байгалийн өвийг тогтвортой хамгаалах, удирдах замаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааг дэмжих, даван туулах чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг үнэлэх зорилготой юм.

**Эх үүсвэр:** UNESCO data, Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Харьяалах захиргааны байгууллага, тусгайлсан судалгаа, боломжтой бол соёлын салбарын мэдээллийн систем

**Тооцох аргачлал:** Тоон болон тийм/үгүй хариулт бүхий санал асуулга

Зөвлөмжид тусгах эсэх: **ҮГҮЙ**

### **4.СОЁЛЫН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ. /CULTURAL FACILITIES/**

**Тодорхойлолт:** Соёлын барилга, байгууламжийн хуваарилалтыг орон зайн зураглалын дагуу харуулах.

**Зорилго:** Энэ үзүүлэлт нь соёлын барилга, байгууламжийн олон талт байдал, тэдгээрийн тархалтыг нутаг дэвсгэрийн хандлагаар үнэлэх зорилготой. Энэ нь хүн ам, тээвэр, засаг захиргаа, эдийн засгийн төвүүдтэй холбоотой соёлын бүсүүдийг тодорхойлох боломжийг олгодог.

**Эх үүсвэр:** UNESCO data, Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Харьяалах захиргааны байгууллага

Зөвлөмжид тусгах эсэх: **ҮГҮЙ**

---

## **СОЁЛ УРЛАГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ЗАДГАЙ ТАЛБАЙ. /OPEN SPACE FOR CULTURE/**

**Тодорхойлолт:** Соёл урлагийн зориулалттай задгай талбайн тоо болон хэмжээг хэлнэ.

**Зорилго:** Энэхүү үзүүлэлт нь соёлын зориулалттай задгай талбайн хэмжээг нийт нийтийн эзэмшлийн талбайд харьцуулсан харьцааг тодорхойлоход оршино.

**Эх үүсвэр:** UNESCO data /UIS/, Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Харьяалах захиргааны байгууллага

**Тооцох аргачлал:** Дараах аргуудаар тодорхойлдог. Үүнд:

Нийтийн эзэмшлийн талбайн хэмжээнд (м2) соёлын зориулалттай задгай талбайн хэмжээн (м2) эзлэх хувь  
Тоогоор илэрхийлэгдсэн нийт нийтийн эзэмшлийн талбайд соёлын зориулалттай задгай талбайн тоон эзлэх хувь  
Нийт зохион байгуулагдсан соёл урлагийн арга хэмжээнд задгай талбайд зохион байгуулагдсан соёл урлагийн арга хэмжээний эзлэх хувь

Зөвлөмжид тусгах эсэх: **ТИЙМ**

### **5.“ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО 2030”-ЫН ЗОРИЛТТОЙ УЯЛДАХ БАЙДАЛ:**

2.4 2030 он гэхэд хүнс үйлдвэрлэлийн тогтвортой системийг бий болгож, бүтээмж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, экосистемийн тэнцвэрийг хангаж чадах, цаг уурын өөрчлөлт, эрс тэс цаг агаар, ган зуд, үер, бусад гамшигт үзэгдэлд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх, газар хөрсний чанарыг тасралтгүй сайжруулах хөдөө аж ахуйн уян хатан арга туршлагыг нэвтрүүлэх /Sustainable foodways & agriculture/

6.6 2020 он гэхэд устай холбоотой экосистем, түүний дотор уул, ой, намагшсан газар, гол мөрөн, уст давхарга, нуурыг хамгаалах, сэргээх /Water related ecosystems/

9.1 Хүн бүрт тэгш, хүртээмжтэй байх талыг голлон анхаарч эдийн засгийн хөгжил, хүний сайн сайхан аж байдлыг дэмжих чанартай, найдвартай, тогтвортой, уян хатан дэд бүтэц, түүний бүсийн болон хил дамнасан дэд бүтцийг хөгжүүлэх /Quality infrastructure/

11.4 Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах /Cultural & natural heritage/

11.7 2030 он гэхэд хүн бүрийг, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аюулгүй, бүх талын оролцоог хангасан, хүртээмжтэй, ногоон болон нийтийн эзэмшлийн талбайгаар хангах /Inclusive public spaces/

---

12.b Шинээр ажлын байр бий болгодог, орон нутгийн соёл, бүтээгдэхүүнийг хөхүүлэн дэмждэг тогтвортой аялал жуулчлалд тогтвортой хөгжлийн үзүүлж буй нөлөөнд хяналт шинжилгээ хийх арга хэрэгслийг боловсруулж, нэвтрүүлэх /Sustainable tourism management/

13.1 Улс орнуудад тулгарч буй цаг ууртай холбоотой аюул осол, байгалийн гамшгийг даван туулах, тэдгээрт зохицох чадавхыг бэхжүүлэх /Climate & disaster resilience/

14.5 2020 он гэхэд олон улсын болон үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн, бэлэн байгаа шинжлэх ухааны чанартай мэдээлэлд үндэслэн далайн эргийн болон далай тэнгисийн талбайн хамгийн багадаа 10 хувийг хамгаалах /Marine areas conservation/

15.1 2020 гэхэд олон улсын гэрээний өмнө хүлээсэн үүрэг хариуцлагад нийцүүлэн хуурай газрын болон далайгаас хол цэнгэг усны экосистем, түүний үйлчилгээ, ялангуяа ой, намагшсан газар, уулархаг болон хуурай газрыг хамгаалах, сэргээх, тэдгээрийг тогтвортой ашиглах боломж нөхцөлийг бүрдүүлэх /Sustainable terrestrial ecosystems/

16.4 2030 он гэхэд санхүүгийн болон галт зэвсгийн хууль бус урсгалыг үлэмж хэмжээгээр багасгаж, хулгайлагдсан эд хөрөнгийг буцаан олгох, нөхөн төлөх ажлыг сайжруулах, зохион байгуулалттай гэмт хэргийн бүх хэлбэртэй тэмцэх /Recovery of stolen assets/

## II. ХӨГЖИЛ ДЭВШИЛ БА ХҮРТЭЭМЖ /PROSPERITY & LIVELIHOODS/

### 6.СОЁЛ УРЛАГИЙН САЛБАРЫН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ /CULTURE IN GDP/

**Тодорхойлолт:** ДНБ-д төрийн болон хувийн хэвшлийн соёл урлагийн бүтээгдэхүүний эзлэх хувь.

**Зорилго:** Энэ үзүүлэлт нь тухайн нутаг дэвсгэрт соёлын салбарын эдийн засагт оруулсан хувь нэмрийг бүхэлд нь үнэлэх зорилготой.

**Эх үүсвэр:** Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Засгийн газрын тайлан, Судалгааны материал, Харьяалах захиргааны байгууллага, Хувийн сектор

**Тооцох аргачлал:** ДНБ-д соёлын салбарын бүтээгдэхүүний эзлэх хувийг тооцно.

$$CGDP = \frac{\sum_1^n GVA_{isic\ codes}}{GDP}$$

**GVA=** (ДНБ+татаас-(шууд зардал, борлуулалт,)татвар)

**GDP(gross domestic product)=**Дотоодын нийт бүтээгдэхүүн

Зөвлөмжид тусгах эсэх: **ТИЙМ**

## 7. СОЁЛ УРЛАГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ /CULTURAL EMPLOYMENT/

**Тодорхойлолт:** Нийт хөдөлмөр эрхэлж буй хүмүүст соёл урлагийн болон бүтээлч үйлдвэрлэлийн салбарт ажиллаж буй ажилтны эзлэх хувь хэмжээг хэлнэ.

$$CEP_0 = \frac{\sum_1^n CE_{isico\ codes}}{EP}$$

CEP<sub>0</sub>=соёл урлагийн мэргэжилтэй ажилтны тоо

EP=нийт хөдөлмөр эрхэлж буй хүн

**Зорилго:** Энэхүү үзүүлэлт нь үндэсний болон орон нутгийн түвшинд соёлын салбарын “ажил олгогч”-ийн үүрэг оролцоо, соёлын салбарын хөгжил, түүнд хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн материаллаг байдлыг сайжруулах, түүний чадавхыг үнэлэх зорилготой юм.

**Эх үүсвэр:** UNESCO data /UIS/, Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Харьяалах захиргааны байгууллага, Хүн амын тооллого, Ажиллах хүчний судалгаа, Нийгмийн даатгалын сан, Мэргэжлийн холбоодын тайлан

**Тооцох аргачлал:** Соёлын хөдөлмөр эрхлэлт нь дараах 3 бүлэг ажилтнаас бүрддэг. Үүнд:

### Хүснэгт 38. Соёлын салбарын хөдөлмөр эрхлэлт

	Соёлын байгууллага	Соёлын бус байгууллага
Соёл урлагийн мэргэжилтэй	А	В
Соёл урлагийн бус мэргэжилтэй	С	

А. Соёлын мэргэжилтэй, соёлын чиглэлээр ажил эрхэлдэг хүмүүс (жишээ нь, театрын жүжигчин)

В. Соёл, урлагийн мэргэжилтэй боловч соёлын үйл ажиллагаа эрхэлдэггүй байгууллагад ажилладаг хүмүүс (жишээлбэл, автомашины үйлдвэрлэлийн дизайнер)

С. Соёлын байгууллагад ажилладаг боловч соёлын мэргэжилгүй хүмүүс (жишээ нь, театрт ажилладаг нягтлан бодогч)

Шалгуур үзүүлэлтийг эдгээр 3 бүлэг хүмүүсийн нийлбэрээр тооцно.

Зөвлөмжид тусгах эсэх: **ҮГҮЙ**

## 8.СОЁЛ УРЛАГ ДАХЬ БИЗНЕС /CULTURAL BUSINESSES/

**Тодорхойлолт:** Нийт бизнесийн үйл ажиллагаанд соёл урлагийн бизнесийн үйл ажиллагааны хамаарах хандлагыг ойлгоно.

**Зорилго:** Энэ үзүүлэлт нь соёлын бизнест (ялангуяа жижиг, бичил аж ахуйн

---

нэгжид) олгож буй таатай нөхцөлийг үнэлэхэд чиглэгдсэн.

**Эх үүсвэр:** UNESCO data /UIS/, Үндэсний статистикийн хороо (ҮСХ), ХАҮТ-ын судалгаа, холбогдох бусад судалгаа

**Тооцох аргачлал:** Тухайн улс, бүс нутагт зохиогдож буй үйл ажиллагаанд соёлын байгууллагуудын бизнесийн үйл ажиллагааны эзлэх хувиар тодорхойлдог. Үүнд:

$$CE/\sum E*100 \{дараагийн жил\} - CE/\sum E*100 \{өмнөх жил\}$$

CE=соёлын байгууллагын тоо

E=тухайн бүсийн нийт байгууллагын тоо

Зөвлөмжид тусгах эсэх: **ҮГҮЙ**

## **9.ӨРХ ГЭРИЙН ЗАРЛАГА /HOUSEHOLD EXPENDITURE/**

**Тодорхойлолт:** Өрхийн нийт зардлаас соёл урлагийн арга хэмжээнд ногдох хувь.

**Зорилго:** Энэ үзүүлэлт нь тухайн нутаг дэвсгэрийн өрхүүд соёлын бараа, үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг үнэлэх, соёлын үйл ажиллагаа, бараа, үйлчилгээний орон нутгийн зах зээлийн хэмжээ, боломжийн талаарх ойлголтыг олж авахад чиглэгддэг.

**Эх үүсвэр:** UNESCO data /UIS/, Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Аж үйлдвэрийн судалгаа, тооллого, Үйлчилгээний судалгаа, Жижиг аж ахуйн нэгжийн судалгаа, Өрхийн зардлын судалгаа.

**Тооцох аргачлал:** Дараах аргуудаар тодорхойлдог. Үүнд:

$$CHFC = \frac{\sum_1^n HCS COICOP \text{ codes}}{HFC}$$

CHFC нь өрхийн эцсийн хэрэглээний нийт зардлаар тогтоосон соёлын арга хэмжээ, бараа, үйлчилгээнд зарцуулсан эцсийн хэрэглээний зардал.

HCS COICOP код нь сонгосон COICOP кодууд дахь өрхийн зардлын нийт дүн.

HFC нь өрхийн эцсийн хэрэглээний нийт зардал.

Зөвлөмжид тусгах эсэх: **ТИЙМ**

## **10.СОЁЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛЭЛЦЭЭР /TRADE IN CULTURAL GOODS & SERVICES/**

**Тодорхойлолт:** Нийт экспортод соёл урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортын эзлэх хувийг хэлнэ.

**Зорилго:** Энэ үзүүлэлт нь эдийн засгийн эрэлт хэрэгцээ болон тухайн улс/хотын

---

соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байдал зэргийг соёл урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан экспортолж буй бүтээгдэхүүнийг үнэлэхэд чиглэгддэг.

**Эх үүсвэр:** UNESCO data /UIS/, Үндэсний татварын алба, Орлогын тайлан, Олон улсын COMTRADE database

**Тооцох аргачлал:** Дараах аргуудаар тодорхойлдог. Үүнд:

А. Нийт экспортод соёлын биет бүтээгдэхүүнийг мөнгөн дүнгээр илэрхийлэн харьцуулсан байдлаар тооцсон хувь<sup>15</sup>

В. Нийт экспортод соёлын нийт бүтээгдэхүүн, үйлчилгээг мөнгөн дүнгээр илэрхийлэн харьцуулсан байдлаар тооцсон хувь

Зөвлөмжид тусгах эсэх: ТИЙМ

## **11.СОЁЛЫН САЛБАРТ ТӨРӨӨС ЗАРЦУУЛЖ БУЙ САНХҮҮЖИЛТ /PUBLIC FINANCE FOR CULTURE/**

**Тодорхойлолт:** Улсын болон орон нутгийн нийт төсөвт соёл урлагийн салбарын төсвийн эзлэх хувь хэмжээг хэлнэ.

**Зорилго:** Энэхүү үзүүлэлт нь соёлын салбарын төсвийн гүйцэтгэлд хяналт, шинжилгээ хийхэд оршино.

**Эх үүсвэр:** Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Харьяалах захиргааны байгууллага, Үндэсний тусгайлсан судалгаа, боломжтой бол соёлын мэдээллийн систем

**Тооцох аргачлал:** Салбарын төсөв болон гүйцэтгэлийн дараах дүнгүүд шаардлагатай болно. Үүнд:

Захиргааны нэгжээр байдлаар улсын болон орон нутгийг төсөв

Төсвийн төрөл /урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал/

Нэг хүнд ногдох зардал

Хөтөлбөр, зориулалтаар

Төсвийн эх үүсвэр

Зөвлөмжид тусгах эсэх: **ТИЙМ**

## **12.СОЁЛЫН ЗАСАГЛАЛ /GOVERNANCE OF CULTURE/**

**Тодорхойлолт:** Соёл урлагийн салбарыг хөгжүүлэх засаглалыг үнэлэх.

**Зорилго:** Энэхүү үзүүлэлт нь соёлын салбарын эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах хувь нэмрийг баталгаажуулах, салбарын төрөл бүрийн үйл ажиллагааг дэмжих төрийн бодлого, зохицуулалтын тогтолцооны ерөнхий дүр зургийг харуулахад чиглэнэ.

Соёлын салбарыг ерөнхийд нь болон соёлын чиглэлээр үндэсний/орон нутгийн түвшинд засаглалын тогтолцооны хөгжлийн түвшнийг үнэлэх зорилготой. Хэд

---

хэдэн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг сонгосон бөгөөд тэдгээрийг 3 үндсэн түвшинд ангилдаг.

Үндэсний/орон нутгийн түвшинд удирдлагын болон зохион байгуулалтын хамрах хүрээ.

Удирдлага, техникийн болон санхүүгийн дэмжлэгийн хамрах хүрээ.

Бүхий л төрлийн дэмжлэгийн уялдаа холбоо

**Эх үүсвэр:** UNESCO data /UIS/, Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Харьяалах захиргааны байгууллага

**Тооцох аргачлал:** Тоон болон тийм/үгүй хариулт бүхий санал асуулга

Зөвлөмжид тусгах эсэх: **ҮГҮЙ**

### **“Тогтвортой хөгжлийн зорилго 2030”-ын зорилттой уялдах байдал:**

8.3 Бүтээмжтэй үйл ажиллагаа, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдал, инновацыг дэмждэг хөгжлийн чиг баримжаатай бодлогыг хөхүүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох замаар бичил, жижиг, дунд бизнесийг албан ёсны болгож, тэдгээрийн өсөлтийг дэмжих /Jobs, entrepreneurship & innovation/

8.9 2030 он гэхэд ажлын байр бий болгож, орон нутгийн соёл, бүтээгдэхүүнийг дэмждэг тогтвортой аялал жуулчлалыг хөхүүлэн дэмжих бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх /Policies for sustainable tourism/

8.a Нэн буурай хөгжилтэй орнуудад үзүүлэх худалдааны холбогдолтой техникийн туслалцааны сайжруулсан нэгдсэн хүрээ/бүтцээр дамжуулан хөгжиж буй орнууд, ялангуяа нэн буурай хөгжилтэй улс орнуудад үзүүлэх Худалдааны тусламж дэмжлэгийг нэмэгдүүлэх /Increase Aid for Trade/

10.a Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрт нийцүүлэн хөгжиж буй орон, ялангуяа нэн буурай хөгжилтэй улс орнуудад онцгой ба ялгавартай хандах зарчмыг хэрэгжүүлэх /Differential treatment on trade/

11.4 Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах /Cultural & natural heritage/

## **III.МЭДЛЭГ БА УР ЧАДВАР /KNOWLEDGE & SKILLS/**

### **13.ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ /EDUCATION FOR SUSTAINABLE DEVELOPMENT/**

**Тодорхойлолт:** Соёл салбарын олон талт байдлыг харуулсан боловсролын шалгуур үзүүлэлтийг хэлнэ.

**Зорилго:** Энэхүү үзүүлэлт нь бүх нийтийн болон тогтвортой хөгжлийн боловсрол нь боловсролын үндэсний хэмжээний бодлого, сургалтын хөтөлбөр, багшийн

---

хөгжил, сурагчийн үнэлгээ зэрэг бүхий л түвшинд соёлын олон талт байдлыг хэрхэн тусгасныг үнэлэхэд чиглэнэ.

**Эх үүсвэр:** UNESCO data /UIS/, Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Харьяалах захиргааны байгууллага

Зөвлөмжид тусгах эсэх: **ҮГҮЙ**

#### **14.СОЁЛЫН МЭДЛЭГ /CULTURAL KNOWLEDGE/**

**Тодорхойлолт:** Соёлын боловсрол олгох болон боловсон хүчнийг бэлтгэх тогтолцоог үнэлэх.

**Зорилго:** Энэхүү үзүүлэлт нь соёлын мэдлэг нь салбарын тогтвортой хөгжлийг хэрхэн өсгөж харуулахад чиглэнэ.

**Эх үүсвэр:** UNESCO data /UIS/, Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Харьяалах захиргааны байгууллага

Тооцох аргачлал: Тоон болон тийм/үгүй хариулт бүхий санал асуулга

Зөвлөмжид тусгах эсэх: **ТИЙМ**

#### **15.ОЛОН ХЭЛНИЙ БОЛОВСРОЛ /MULTILINGUAL EDUCATION/**

**Тодорхойлолт:** Бага болон дунд ангиудад зарцуулж буй хэлний боловсрол олгох цагт олон хэлний мэдлэг олгох цагийн эзлэх хувь.

**Зорилго:** Уг үзүүлэлтийг бага болон дунд ангийн түвшинд соёл хоорондын хэл авиаг дэмжих, хамгаалах, ойлгох зэргээр дамжуулан соёлын олон талт хэлбэрийг сурталчлахад ашигладаг.

**Эх үүсвэр:** UNESCO data /UIS/, Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Сургалтын хөтөлбөр

Тооцох аргачлал: Дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

$$Үзүүлэлт=ILR+II+(1-1/B)*ION$$

ION=Хэл заах нийт цагт тухайн хэлний сургалтын цагийн эзлэх хувь

ILR= Хэл заах нийт цагт тухайн орон нутагт хэлний сургалтын цагийн эзлэх хувь

II= Хэл заах нийт цагт гадаад хэл заах сургалтын цагийн эзлэх хувь

B=Сургалтын хөтөлбөрт тусгагдсан албан ёсны эсвэл үндэсний хэлний тоо

Зөвлөмжид тусгах эсэх: **ҮГҮЙ**



---

## **16.СОЁЛ, УРЛАГИЙН БОЛОВСРОЛ /CULTURAL & ARTISTIC EDUCATION/**

**Тодорхойлолт:** Сургалтын хөтөлбөрт тусгагдсан нийт цагт дунд ангийн /ISCED-2/ эхний хоёр жилд соёлын боловсролын олгоход зориулагдсан хичээлийн цагийн эзлэх хувь.

**Зорилго:** Энэ үзүүлэлт нь ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт соёл судлал, бүтээлч сэтгэлгээ, бүтээлч авьяас чадварыг дэмжих, мөн залуучуудад “соёлын хүсэл эрмэлзэл”-ийн талаарх мэдлэгийг олгох талаар хэр зэрэг багтааж байгааг үнэлэх зорилготой.

**Эх үүсвэр:** UNESCO data /IBE/, яамнаас батлагдсан сургалтын хөтөлбөр

**Тооцох аргачлал:** Сургалтын хөтөлбөрт тусгагдсан нийт цагт соёлын боловсролын олгоход зориулагдсан хичээлийн цагийн эзлэх хувийг тооцож гаргана.

Зөвлөмжид тусгах эсэх: **ҮГҮЙ**

## **17.СОЁЛЫН СУРГАЛТ /CULTURAL TRAINING/**

**Тодорхойлолт:**

А.Ахлах анги болон мэргэжлийн, дээд боловсролын түвшинд суралцагчдын нийт тоонд соёл урлагийн чиглэлээр суралцаж буй оюутан, сурагчдын тоо.

В. Ахлах анги болон мэргэжлийн, дээд боловсролын түвшинд суралцаж төгсөгчдийн нийт тоонд соёл урлагийн чиглэлээр суралцаж төгссөн оюутан, сурагчдын тоо.

**Зорилго:** Энэхүү үзүүлэлт нь ахлах анги болон мэргэжлийн, дээд боловсролын түвшинд соёлын чиглэлээр суралцагчдын хамрагдалтыг тодорхойлоход оршино.

**Эх үүсвэр:** UNESCO data /UIS/, Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Харьяалах захиргааны байгууллага

**Тооцох аргачлал:** Дараах аргуудаар тодорхойлдог. Үүнд:

А.Ахлах анги болон мэргэжлийн, дээд боловсролын түвшинд суралцагчдын нийт тоонд соёл урлагийн чиглэлээр суралцаж буй оюутан, сурагчдын эзлэх хувь.

В. Ахлах анги болон мэргэжлийн, дээд боловсролын түвшинд суралцаж төгсөгчдийн нийт тоонд соёл урлагийн чиглэлээр суралцаж төгссөн оюутан, сурагчдын эзлэх хувь.

Зөвлөмжид тусгах эсэх: **ТИЙМ**

---

## **“Тогтвортой хөгжлийн зорилго 2030”-ын зорилттой уялдах байдал:**

4.4 2030 он гэхэд ажил эрхлэх, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх холбогдох ур чадвартай, түүний дотор техник, мэргэжлийн ур чадвартай залуучууд, насан хүрэгсдийн тоош [x] хувиар нэмэгдүүлэх /Skills for employment/

4.7 2030 он гэхэд тогтвортой хөгжлийн мэдлэг, тогтвортой амьдралын хэв маяг, хүний эрх, жендерийн тэгш байдал, энх тайван болон хүч үл хэрэглэх соёлыг төлөвшүүлэх, дэлхийн иргэн байх, соёлын олон янз байдал болон тогтвортой хөгжилд соёлын оруулж буй хувь нэмрийг ойлгуулах мэдүүлэх замаар тогтвортой хөгжлийг хөхүүлэх дэмжихэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг бүх суралцагчдад олгох /Skills for sustainable development/

8.3 Бүтээмжтэй үйл ажиллагаа, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдал, инновацыг дэмждэг хөгжлийн чиг баримжаатай бодлогыг хөхүүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох замаар бичил, жижиг, дунд бизнесийг албан ёсны болгож, тэдгээрийн өсөлтийг дэмжих /Jobs, entrepreneurship & innovation/

9.с 2020 он гэхэд мэдээлэл, холбооны технологийн хүртээмжийг гүлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, нэн буурай хөгжилтэй орнуудын хүн амыг хямд үнэтэй интернэтээр хангахыг эрмэлзэх /Access to information technologies/

12.а Хэрэглээний болон үйлдвэрлэлийн илүү тогтвортой бүтцэд шилжих зорилгоор шинжлэх ухааны болон технологийн чадавхаа бэхжүүлэхэд хөгжиж буй орнуудыг дэмжих /Sustainable consumption/

13.3 Цаг уурын өөрчлөлтийг багасгах, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох, цаг уурын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, урьдчилан сэрэмжлүүлэх талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж, хүмүүсийн болон институтийн чадавхыг сайжруулах /Education on climate adaptation/

## **IV.ХҮРТЭЭМЖ БА ОРОЛЦОО /INCLUSION & PARTICIPATION/**

### **18.НИЙГМИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАСАН СОЁЛ /CULTURE FOR SOCIAL COHESION/**

**Тодорхойлолт:** Дараах гурван үндсэн үзүүлэлтийн нийлбэрээр тодорхойлогдоно. Үүнд:

Соёл хоорондын харилцан ойлголцол: Өөр соёл бүхий хүмүүстэй харилцан ойлголцож амьдрахыг эсэргүүцдэггүй хүмүүсийн хувь

Хүн хоорондын итгэлцэл: Бусад хүмүүст итгэж болохыг хүлээн зөвшөөрсөн хүний эзлэх хувь

Жендерийн тэгш байдлын талаарх ойлголт: Жендерийн тэгш байдлыг эергээр хүлээн зөвшөөрдөг хүний эзлэх хувь

**Зорилго:** Энэхүү үзүүлэлт нь улсынхаа соёл, нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд оролцох боломж, иргэний эрхээ эдлэхдээ соёл хоорондын харилцан

---

ойлголцлын түвшнийг үнэлэх, өөр соёл бүхий хүмүүсийн хувь хүний үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрөх байдлыг хэмжих, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хоорондын ялгааг хүндэтгэн үзэх зорилготой юм.

**Эх үүсвэр:** Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Тусгайлсан судалгаа, боломжтой бол соёлын салбарын мэдээллийн систем

**Тооцох аргачлал:** Дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

$$DoC = \sum_{i=1}^k \frac{f_i}{N} / k$$

$f_i$  = итгэж болохыг хүлээн зөвшөөрсөн хүний тоо

$N$  = судалгаанд хамрагдсан хүний тоо

$k$  = хувьсагчийн тоо (а.өөр үндэстэн, б.цагаачид/гадаад ажиллах хүч, в.өөр шашин шүтлэгтэй хүн гэх мэт хувьсагч)

Зөвлөмжид тусгах эсэх: **ҮГҮЙ**

## **19.УРЛАГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ /ARTISTIC FREEDOM/**

**Тодорхойлолт:** Урлагийн эрх чөлөөг дэмжих, уран бүтээлчийн статусыг тодорхойлох.

**Зорилго:** Энэхүү үзүүлэлт нь уран бүтээлчдийн хөгжин дэвших тогтвортой орчныг бий болгосон байдлыг үнэлэхэд чиглэнэ.

**Эх үүсвэр:** UNESCO data, Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Харьяалах захиргааны байгууллага, Тусгайлсан судалгаа, боломжтой бол соёлын салбарын мэдээллийн систем

**Тооцох аргачлал:** Тоон болон тийм/үгүй хариулт бүхий санал асуулга

Зөвлөмжид тусгах эсэх: **ҮГҮЙ**

## **20.СОЁЛЫН ХҮРТЭЭМЖ /ACCESS TO CULTURE/**

**Тодорхойлолт:** Хүн амын тархалттай уялдсан соёлын дэд бүтцийн хүртээмжийг хэлнэ.

**Зорилго:** Энэхүү үзүүлэлт нь соёлын байгууллагын хүртээмж нь иргэдэд хэрхэн хүрэлцээтэй байгааг үнэлэхэд чиглэнэ.

**Эх үүсвэр:** Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Харьяалах захиргааны байгууллага, боломжтой бол соёлын салбарын мэдээллийн систем

**Тооцох аргачлал:** Соёлын салбарын ашиглах боломжтой нийт дэд бүтэц ба

---

соёлын үйлчилгээнд хамрагдах хүсэлтэй иргэдийн хамаарлыг харуулдаг үзүүлэлт. Тухайн орон нутаг дахь төрөл бүрийн зориулалт бүхий байгууламжийн тоо болон оршин суугчдын тоог гаргана. Тухайн улс/хотын хүрээнд байгууламжийн стандарт хазайлт нь бүс нутагтай хэрхэн жигд тархсан байдлаар нь үнэлнэ. Зөвлөмжид тусгах эсэх: **ТИЙМ**

## **21.СОЁЛЫН ОРОЛЦОО /CULTURAL PARTICIPATION/**

**Тодорхойлолт:** Дараах 3 үндсэн дэд үзүүлэлтээр хэмждэг. Үүнд:

Соёлын дурсгалт түүхэн газраар зорчигчдын тоо

Сүүлийн 12 сарын хугацаанд соёлын үйл ажиллагаанд нэгээс доошгүй удаа хамрагдсан хүний эзлэх хувь

Сүүлийн 12 сарын хугацаанд гэрээсээ соёлын үйл ажиллагаанд оролцсон өрх гэрийн эзлэх хувь /цахим хэрэгсэл ашиглах гм/

**Зорилго:** Энэ үзүүлэлт нь гурван үндсэн зорилготой.

- Соёлын дурсгалт газар, байгууламжид зочилсон нийт тоог үнэлэх.

- Соёлын арга хэмжээ, байгууламжид оролцох хүн амын эзлэх хувийг үнэлэх. Гэрээсээ гадуурх соёлын арга хэмжээнд оролцох хүн амын эзлэх хувь нэмэгдэж байна уу эсвэл буурч байна уу гэдгийг чиг хандлагын мэдээллээр тодорхойлно.

- Хүмүүс гэртээ соёлын үйл ажиллагаа, ур чадварт хэр зэрэг оролцож байгааг (хоол хийх, хувцаслах гэх мэт өдөр тутмын дадал зуршлаас бусад) үнэлэх

**Эх үүсвэр:** Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Харьяалах захиргааны байгууллага, боломжтой бол соёлын салбарын мэдээллийн систем, Интернэтийн үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж

Зөвлөмжид тусгах эсэх: **ТИЙМ**

## **22.ОРОЛЦООНЫ ИЛ ТОД БАЙДАЛ/PARTICIPATORY PROCESSES/**

**Тодорхойлолт:** Соёлын бодлого, хөтөлбөр, санал санаачилгыг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад орон нутгийн иргэд, бүх оролцогч талуудын оролцоог хэрхэн хангаж буйг илэрхийлэх

**Зорилго:** Энэ үзүүлэлт нь үндэсний болон бүс нутгийн хэмжээнд соёлын үйл ажиллагаа, бодлого, арга хэмжээ, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд иргэний нийгэм, ялангуяа соёлын салбарын мэргэжилтнүүд, цөөнхөд нээлттэй байгаа боломжийг үнэлэх зорилготой юм.

**Эх үүсвэр:** Харьяалах захиргааны байгууллага, боломжтой бол тусгайлсан судалгаа, соёлын салбарын мэдээллийн систем

**Тооцох аргачлал:** Тоон болон тийм/үгүй хариулт бүхий санал асуулга

Зөвлөмжид тусгах эсэх: **ТИЙМ**

---

**“Тогтвортой хөгжлийн зорилго 2030”-ын зорилттой уялдах байдал:**

9.1 Хүн бүрт тэгш, хүртээмжтэй байх талыг голлон анхаарч эдийн засгийн хөгжил, хүний сайн сайхан аж байдлыг дэмжих чанартай, найдвартай, тогтвортой, уян хатан дэд бүтэц, түүний бүсийн болон хил дамнансан дэд бүтцийг хөгжүүлэх /Quality infrastructure/equitable access/

9.с 2020 он гэхэд мэдээлэл, холбооны технологийн хүртээмжийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, нэн буурай хөгжилтэй орнуудын хүн амыг хямд үнэтэй интернэтээр хангахыг эрмэлзэх /Access to information technologies/

10.2 2030 он гэхэд нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, арьс өнгө, яс үндэс, удам угсаа, шашин шүтлэг, эдийн засгийн болон бусад байр сууриасаа үл хамааран хүн бүрийг нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд эрх тэгш оролцох боломжоор хангаж, дэмжих /Social inclusion/

11.7 2030 он гэхэд хүн бүрийг, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аюулгүй, бүх талын оролцоог хангасан, хүртээмжтэй, ногоон болон нийтийн эзэмшлийн талбайгаар хангах /Inclusive public spaces/

16.7 Бүх түвшинд хурдан шуурхай, бүх талын оролцоог хангасан, оролцооны аргад тулгуурласан, төлөөллийн шийдвэр гаргадаг болох /Participatory decision-making/

16.10 Үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээ хэлэлцээрт нийцүүлэн олон нийтийг мэдээлэл олж авах боломжоор хангах, үндсэн эрх чөлөөг хамгаалах /Fundamental freedoms/

16.a Хүчирхийллээс сэргийлэх, терроризм, гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор бүх түвшинд, ялангуяа хөгжиж буй орнуудын чадавхыг бэхжүүлэх үүднээс олон улсын хамтын ажиллагаагаар дамжуулан үндэсний холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах /Prevention of violence/

16.b Тогтвортой хөгжлийн үл ялгаварласан хууль, бодлогыг хөхүүлэн дэмжиж, мөрдүүлэх /Non-discriminatory policies/

Хүснэгт 39. Тоон болон чанарын үзүүлэлтийн товчоо

Бүлэг хөтөлбөр	Тоон болон чанарын үзүүлэлт	Тодорхойлолт	+/-
<b>I. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН БА ТҮҮНД ДАСАН ЗОХИЦОХ, ДАВАН ТУУЛАХ ЧАДАВХ.</b>	1. Соёлын өвийн зардал.	“Соёлын болон байгалийн бүх өвийг хадгалах, хамгаалах, сэргээн засварлахад зарцуулсан нэг хүнд ногдох нийт зардлын хэмжээг ойлгоно.	+
	2. Соёлын өвийн тогтвортой бодлого.	Соёлын болон байгалийн өв, туршлага, мэдлэг, түүхийн хөдлөх, үл хөдлөх эд өлгийн зүйлийг хамгаалах, удирдах тогтвортой менежментийн тогтолцоог олж тогтоох.	-
	3. Уур амьсгалд дасан зохицох болон даван туулах чадвар.	Уур амьсгалд дасан зохицох, ялангуяа уламжлалт арга барилыг багтаасан даван туулах чадварыг олж тогтоох.	-
	4. Соёлын барилга, байгууламж.	Соёлын барилга, байгууламжийн хуваарилалтыг орон зайн зураглалын дагуу харуулах.	-
	5. Соёл урлагийн задгай талбай.	Соёлын барилга, байгууламжийн хуваарилалтыг орон зайн зураглалын дагуу харуулах.	+
<b>II. Хөгжил дэвшил ба хүртээмж</b>	6. ДНБ-д соёл урлагийн салбарын оруулах хувь.	ДНБ-д төрийн болон хувийн хэвшлийн соёл урлагийн бүтээгдэхүүний эзлэх хувь.	+
	7. Соёл урлагийн хөдөлмөр эрхлэлт.	Нийт хөдөлмөр эрхэлж буй хүмүүст соёл урлагийн болон бүтээлч үйлдвэрлэлийн салбарт ажиллаж буй ажилтны эзлэх хувь хэмжээг хэлнэ.	+
	8. Соёл урлаг дахь бизнес.	Нийт бизнесийн үйл ажиллагаанд соёл урлагийн бизнесийн үйл ажиллагааны хамаарах хандлагыг ойлгоно.	-
	9. Өрх гэрийн зарлага.	Өрхийн нийт зардлаас соёл урлагийн арга хэмжээнд ногдох хувь.	+
	10. Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний хэлэлцээр.	Нийт экспортод соёл урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортын эзлэх хувийг хэлнэ.	+
	11. Соёлын салбарт төрөөс зарцуулж буй санхүүжилт.	Улсын болон орон нутгийн нийт төсөвт соёл урлагийн салбарын төсвийн эзлэх хувь хэмжээг хэлнэ.	+
	12. Соёлын засаглал.	Соёл урлагийн салбарыг хөгжүүлэх засаглалыг үнэлэх.	-
<b>III. Мэдлэг ба ур чадвар</b>	13. Тогтвортой хөгжлийн боловсрол.	Соёл салбарын олон талт байдлыг харуулсан боловсролын шалгуур үзүүлэлтийг хэлнэ.	-
	14. Соёлын мэдлэг.	Соёлын боловсрол олгох болон боловсон хүчнийг бэлтгэх тогтолцоог үнэлэх.	-
	15. Олон хэлний боловсрол.	Бага болон дунд ангиудад зарцуулж буй хэлний боловсрол олгох цагт олон хэлний мэдлэг олгох цагийн эзлэх хувь.	-
	16. Соёл, урлагийн боловсрол.	Сургалтын хөтөлбөрт тусгагдсан нийт цагт дунд ангийн /SCED-2/ эхний хоёр жилд соёлын боловсролын олгоход зориулагдсан хичээлийн цагийн эзлэх хувь.	-
	17. Соёлын сургалт.	А. Ахлах анги болон мэргэжлийн, дээд боловсролын түвшинд суралцагчдын нийт тоонд соёл урлагийн чиглэлээр суралцаж буй оюутан, сурагчдын тоо; В. Ахлах анги болон мэргэжлийн, дээд боловсролын түвшинд суралцаж төгсөгчдийн нийт тоонд соёл урлагийн чиглэлээр суралцаж төгссөн оюутан, сурагчдын тоо.	+
<b>IV. Хүртээмж ба оролцоо</b>	18. Нийгмийн нэгдмэл байдлыг хангасан соёл.	Соёл хоорондын харилцан ойлголцол: Өөр соёл бүхий хүмүүстэй харилцан ойлголцож амьдрахыг эсэргүүцдэггүй хүмүүсийн хувь; Хүн хоорондын итгэлцэл: Бусад хүмүүст итгэж болохыг хүлээн зөвшөөрсөн хүний эзлэх хувь; Жендерийн тэгш байдлын талаарх ойлголт: Жендерийн тэгш байдлыг эергээр хүлээн зөвшөөрдөг хүний эзлэх хувь.	-
	19. Урлагийн эрх чөлөө.	Урлагийн эрх чөлөөг дэмжих, уран бүтээлчийн статусыг тодорхойлох.	-
	20. Соёлын хүртээмж.	Хүн амын тархалттай уялдсан соёлын дэд бүтцийн хүртээмжийг хэлнэ.	+
	21. Соёлын оролцоо.	Соёлын дурсгалт түүхэн газраар зорчигчдын тоо; Сүүлийн 12 сарын хугацаанд соёлын үйл ажиллагаанд нэгээс доошгүй удаа хамрагдсан иргэдийн эзлэх хувь;	+

		Сүүлийн 12 сарын хугацаанд гэрээсээ соёлын үйл ажиллагаанд оролцсон өрх гэрийн эзлэх хувь /цахим хэрэгсэл ашиглах гм/	
	22.Оролцооны ил тод байдал.	Соёлын бодлого, хөтөлбөр, санал санаачилгыг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад орон нутгийн иргэд, бүх оролцогч талуудын оролцоог хэрхэн хангаж буйг илэрхийлэх.	+

“ +/- “ хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтэд ашиглах эсэх

“ + “ ТИЙМ, “ - “ ҮГҮЙ

---

## 12. ДҮГНЭЛТ

---

**1. Соёлын бодлогод тэргүүлэх ач холбогдол өгч Монгол Улсын хөгжлийн бодлогын хамгийн эхний зорилго болгожээ.** Алсын Хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын хамгийн эхний зорилго “Үндэсний нэгдмэл үнэт зүйл”-ийг хангахын тулд ЗГ-аас дунд хугацаанд соёлын салбарын бодлогын тэргүүлэх чиглэлийг нийт хүн амд эх хэл, эх түүх, өв соёлыг төлөвшүүлэх, үндэсний ижилсэл-ондоошлын гүн ухамсар суулгах, бүх нийтэд соёлын боловсрол олгох, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тус тус чиглүүлж байна.

**2. Соёлын зорилтуудыг хэрэгжүүлснээр Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) 2030-ын бусад олон зорилгыг биелүүлэхэд хувь нэмэр болно.** Соёлыг хамгаалах, сурталчлах, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь ТХЗ-ын аюулгүй, тогтвортой хот, чанартай боловсрол, зохистой хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн өсөлт, тэгш бус байдлыг бууруулах, хүрээлэн буй орчныг хамгаалах, жендерийн тэгш байдал, энх тайван, хүртээмжтэй хөгжлийг дэмжих зэрэг бусад олон ТХЗ-д шууд хувь нэмэр оруулах юм.

**3. МУ-ын соёлын салбарын дунд ба урт хугацааны бодлогын зорилго, зорилтуудын үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт хангалтгүй байна.** Алсын хараа 2050, МУ-ыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд заасан соёлын зорилтуудын хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд нь үр дүн, үр нөлөөний шалгуур үзүүлэлт бус гарц, үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжих шинж чанартай шалгуур үзүүлэлтүүд байна.

**4. Соёлын салбарын байгууллагын тогтолцоо тогтворгүй байжээ.** 1992-1996 оны Засгийн газрын бүтцэд Соёлын яамыг шинээр байгуулсан боловч 1996 онд Соёлын яамыг татан буулгасан. 1996-2012 онд соёлын асуудал нь Гэгээрлийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд харьяалагдаж байсан. 2012 онд шинээр байгуулагдсан Засгийн газрын бүтцэд Соёл, спорт, аялал жуулчлалын яам байгуулагдсан боловч 2014 онд татан буугдаж боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээнд харьяалагдах болсон. 2020 оноос ЗГ-ын бүтцэд шинээр Соёлын яамтай болсон. Түүнчлэн орон нутгийн соёлын байгууллагууд соёлын сайдын сайдын эрхлэх асуудлын хүрээнд эсхүл аймгийн Засаг даргын харьяанд ээлжлэн шилжиж иржээ.

**5. Соёлын салбарын (төрийн үйлчилгээний) 3 ажилтан тутмын 1 нь театр, чуулгад, 1 нь сумын соёлын төвд ажиллаж байна.** 2012-2022 оны хугацаанд соёлын байгууллагууд 6,845-7,305 ажилтантай байснаас 54-56 хувь нь эмэгтэйчүүд байв. Нийт ажиллагчдын 35-40 хувь нь театр, чуулгад, 33-38 хувь нь соёлын төвд, үлдэх хувь нь номын сан, музей, киноны болон соёлын захиргааны байгууллагад ажиллаж байна.

**6. Соёлын салбарт ажиллагчдын тоо нь дэлхийн дундаж болон Ази, Номхон далайн бүсүүдийн дунджаас бараг 5 дахин доогуур байна.** ҮСХ-ноос гаргасан



---

эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалд соёлын салбар гэсэн ангилал байхгүй учраас “урлаг, үзвэр, тоглоом, наадмын үйл ажиллагаа” гэсэн эдийн засгийн үйл ажиллагааг соёлын салбартай дүйцүүлэн авч үзвэл, 2022 оны эцэст урлаг, үзвэр, тоглоом, наадмын үйл ажиллагааны салбарт 14.1 мянга ажиллаж байсан нь нийт ажиллагчдын 1.2 хувь болж байна. Энэ үзүүлэлт дэлхийн дунджаар 6.2%, Ази, Номхон далайн бүсийн улсуудын дунджаар 6.7% байна.

**7. Соёлын салбарын төсвийн зарлагын гүйцэтгэл 2012-2022 онд жилд дунджаар 8.4 хувиар өсөж байжээ.** Салбарын зарлагын гүйцэтгэл 2012 онд 93.2 тэрбум төгрөг байсан бол 2022 онд 174.0 тэрбум төгрөг болж 86.8 хувиар нэмэгдсэн. Салбарын зарлагын гүйцэтгэл нь батлагдсан төсвийн хэлбэлзлээс шалтгаалан хэлбэлзэл ихтэй /SD=39.9, R<sup>2</sup>=0.2812/, гэхдээ ерөнхий хандлага эерэг, өсөлттэй / өсөлтийн коэффициент 0.0375/ байна.

**8. 2012-2022 оны хугацаанд батлагдсан төсвийн гүйцэтгэл 2020 онд хамгийн бага буюу 71.6% байсан бол 2022 онд хамгийн өндөр буюу 98.1% байжээ.** Соёлын салбарын төсвийн гүйцэтгэл 2020 онд муу байсан нь дэлхий нийтийг хамарсан КОВИД 19 цар тахлын үеийн хөл хориотой холбоотой. Төсвийн гүйцэтгэл 2022 онд хамгийн сайн гарсан нь хөрөнгийн төсвийн гүйцэтгэл 100 хувьд хүрсэнтэй холбоотой байна.

**9. Сүүлийн 3 жилийн үзүүлэлтээс харахад салбарын төсвийн найдвартай байдал сайн байна.** Салбарын нийт зарлагын гүйцэтгэл сүүлийн 3 жилээс 2 жилд нь 95%-аас дээш байна. Салбарын байгууллагын төрлөөр болон эдийн эдийн засгийн засгийн ангиллаар баталсан төсөв ба гүйцэтгэлийн зөрүүгээр тооцоход сүүлийн 3 жилийн 2 жилд нь зөрүүний хувь 5 хувиас бага байна. Салбарын хөрөнгө оруулалтын зардлын дутуу гүйцэтгэл нь төсвийн гүйцэтгэлд хамгийн их нөлөө үзүүлж байна.

**10. Салбарын төсвийн зарлагын ихэнх хувь нь соёл урлаг хөтөлбөрөөр дамжуулан зарцуулагдаж байна.** Салбарын хөрөнгийн зардлын төсвийг 2020, 2021 онд соёл урлаг хөтөлбөрөөс салгаж “ангилагдаагүй бусад” гэсэн хөтөлбөрт тусгаж байжээ. Харин 2022 оны төсвийн жилд соёлын салбарын хөрөнгийн зардлын төсвийг соёл урлаг хөтөлбөрт оруулан баталсан. 2022 онд соёлын салбарын нийт зарлагын 99.6 хувь нь соёл урлаг хөтөлбөрөөр, 0.4 хувь нь шинжлэх ухаан хөтөлбөрөөр тус тус зарцуулагдсан байна. 2021, 2022 онд хамгийн их төсөв зарцуулсан соёлын арга хэмжээ нь түүхэн ой тэмдэглэх, соёл урлагийг хөгжүүлэх болон гадаадад зохиогдох соёлын арга хэмжээнүүд байна.

**11. Салбарын бүх төсвийг үндсэн нэг хөтөлбөрт баталдаг тул иргэдэд үзүүлж буй соёлын үйлчилгээний үр дүн, гүйцэтгэлийг гарц буюу үйлчилгээний төрөлтэй уялдуулан тодорхойлох боломжгүй байна.** Соёлын үйлчилгээний хэрэглэгч болох иргэд, олон нийтэд театр, чуулгын, сонгодог урлагийн, номын сангийн болон музейн үйлчилгээ, соёлын боловсрол, соёлын өв, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих үйлчилгээг үзүүлэхийн тулд улс, орон нутгийн төсвөөс ямар зориулалт, арга хэмжээнд ямар хэмжээний хөрөнгө зарцуулсныг төсвийн гүйцэтгэлийн мэдээнээс хөтөлбөрөөр нарийн харах боломжгүй байна.

---

**12. Салбарын урсгал зардлын өөрчлөлтөд нөлөөдөг гол зардал нь орон нутгийн соёлын байгууллагуудын төсөв байна.** Салбарын урсгал зардлын дундаж өсөлтийн хувь 2012-2018 онд тогтвортой буюу жилд 3.5 хувь байсан бол 2019-2021 онд орон нутгийн соёлын байгууллагын төсвийг улсын төсвөөс хариуцахгүй болсон учраас урсгал зардал огцом буурч, 2021 онд огцом өссөн байна. 2022 онд Соёлын сайдын төсвийн багцад орон нутгийн байгууллагад олгох урсгал шилжүүлэг батлагдах болсноор урсгал зардал 2021 онтой харьцуулахад огцом буюу 167 хувиар өссөн. Урсгал зардлын сүүлийн жилүүдийн огцом хэлбэлзлийг оруулан тооцвол, 2012-2022 онд урсгал зардал жилд дунджаар 21.4 хувиар өссөн байна.

**13. Салбарын хөрөнгийн зардал өнгөрсөн 11 жилийн хугацаанд өсөж, буурсан хэлбэлзэл ихтэй байв.** 2012-2022 оны хөрөнгийн зарлагын жилийн дундаж өсөлт 30 хувь байна. Хөрөнгийн зардал хамгийн их байсан жил нь Соёлын яам байгуулагдсан 2020 бөгөөд тухайн онд 105.5 тэрбум төгрөгийн хөрөнгийн зарлагын гүйцэтгэлтэй байжээ. Ерөнхийдөө тусдаа Соёлын яамтай байсан 2012-2014, 2020-2022 онуудад хөрөнгийн зардлын хэмжээ өндөр байх хандлагатай байна.

**14. 2012-2022 оны хугацаанд батлагдсан төсвөөс зарцуулагдаагүй үлдсэн төсвийн 25 хувь нь урсгал зардлын төсөв, 75 хувь нь хөрөнгийн зардлын төсөв байжээ.** Соёлын салбарт 2012-2022 онд нийтдээ 1.2 их наяд төгрөгийн улсын төсөв батлагдсанаас 1.1 их наяд төгрөгийн зарлагыг санхүүжүүлж, зарлагын гүйцэтгэл 90% байжээ. 2012-2022 оны салбарын нийт төсвийн зарлагын 57.9 хувь нь урсгал зардал, 42.1 хувь нь хөрөнгийн зардалд зарцуулагджээ. 2020, 2021, 2022 оноос бусад онуудад хөрөнгийн зардлын 16 орчим хувийг тухайн ондоо зарцуулж чадаагүй байна.

**15. Соёлын сайдын урсгал төсвийн 74 хувь нь театр, чуулга, музей, номын сангийн үйлчилгээ болон соёлын төвийн үйл ажиллагаанд зарцуулагдаж байна.** Соёлын сайдын төсвөөс 2022 онд эдгээр байгууллагад 84.0 тэрбум төгрөгийн урсгал зардал олгосон. Урсгал төсвийн зарлагын 15 хувийг Соёл урлагийг хөгжүүлэх сан болон соёлын сайдын шууд зардалд, 11 хувийг яам, агентлаг, бусад захиргааны байгууллагын зардалд зарцуулжээ.

**16. Улсын төсвөөс хамгийн их санхүүжилтийг театр, чуулгын байгууллагад олгодог.** Салбарын төсвийн зарлагын хуваарилалтыг соёлын үйлчилгээний байгууллагуудаар 2022 оноор тооцож үзэхэд улсын төсвөөс олгож байгаа төсвийн хамгийн их буюу 38.7% нь театр, чуулгад, 35.9% нь соёлын төвд, 16.5% нь музейн үйл ажиллагаанд зарцуулагдсан бол төсвийн 8.9% нь номын санд хуваарилагдаж байна.

**17. 2022 онд соёлын салбарын урсгал зардлын 68.7% нь цалин хөлс, НДШ-ийн зардалд зарцуулагджээ.** Харин орон нутгийн өмчит соёлын байгууллагууд нь соёлын сайдаас олгосон 60.8 тэрбум төгрөгийн урсгал шилжүүлгийн 50.7 тэрбумыг буюу 83 хувийг цалин хөлс, НДШ-д зарцуулсан байна. Урсгал зардалд цалин хөлсний зардал өндөр хувийг эзэлж байгаа боловч соёлын салбарт ажиллагчдын цалин хөлс нь улсын дунджаас доогуур, боловсролын

---

салбарынхнаас 12 хувиар, эрүүл мэндийн салбарынхнаас 9.2 хувиар тус тус бага байна.

**18. Орон нутгийн өмчит соёлын байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардал өндөр байна.** Соёлын яамны шууд харьяа төрийн өмчит 34 соёлын байгууллагууд ихэвчлэн Улаанбаатар хот, аймгийн төвд байршдаг бөгөөд урсгал зардлынхаа зөвхөн 5%-6.5%-ийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд зарцуулж байна. Харин аймаг, сум, дүүргүүдэд байдаг орон нутгийн өмчит 420 орчим байгууллага болох соёлын төв, театр, чуулга, музей, номын сангууд нь урсгал зардлынхаа 22.6 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд зарцуулж байна. Энэ нь орон нутгийн өмчит соёлын байгууллагын тоо олон бөгөөд орон нутагт уурын зуухнаас халаалт авдаг дулааны алдагдал ихтэй хуучин барилга байгууламжийн ашиглалтын зардал өндөр байдагтай холбоотой байна.

**19. Соёлын салбарт 2010-2023 оны 14 жилийн хугацаанд 301 соёлын төв баригдсан. 2010-2022 онд нийтдээ 639.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөв батлагдаж, 500 барилгын ажлыг эхлүүлж, 425 барилгыг ашиглалтад оруулж, 534.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлсэн байна.** Нийт 500 төсөл, арга хэмжээг эхлүүлсний 60 хувь нь соёлын төвийн барилгууд байна. Салбарын хөрөнгө оруулалтын 1 барилгын ажлын үргэлжлэх хугацаа дунджаар 4.4 жил байна. Нийт 10 жилээс дээш баригдсан болон баригдаж буй 9 төсөл арга хэмжээ байна.

**20. Соёл урлагийн хөтөлбөрийн үр дүнгийн 5 шалгуур үзүүлэлтийг 2013 оноос хойш өөрчлөөгүй.** Монгол Улсын 2021, 2022, 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар баталсан соёл урлаг хөтөлбөрийн 8 шалгуур үзүүлэлтүүдийн 5 нь 2013 оноос хойш жил бүр баталж байгаа шалгуур үзүүлэлт байна. Түүнчлэн соёл урлаг хөтөлбөрийн төсвийн хэмжээ өөрчлөгдөж байхад уг төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн зорилтот түвшнийг өөрчлөөгүй байна.

**21. Соёлын байгууллагуудын орлого төвлөрүүлэлтэд тавих хяналт сул байна. Мэргэжлийн урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны орлого Ковидын дараа 2022 онд огцом нэмэгдэж, 3 тэрбум төгрөгт хүрсэн.** Орон нутгийн өмчит 25 Хөгжимт жүжгийн театр, чуулгын 2022 оны үйл ажиллагааны өөрийн орлого 379.8 сая төгрөг байсан бол мэргэжлийн урлагийн төрийн өмчит 6 байгууллагын орлого 2.6 тэрбум төгрөг байжээ. Орон нутгийн өмчит 24 Хөгжимт жүжгийн театрын жилийн орлого 379.8 сая төгрөг байгааг 25 театрт хуваахад дунджаар 16 сая төгрөг болж байна. Эдгээр 25 театр нийтдээ наад зах нь 500.0 мянган хүнд үйлчилсэн гэж үзэхэд 1 үзэгчээс 30 төгрөгийн орлого олсон гэж үзэхээр байна. 2022 онд театр, чуулгын үйлчилгээний 1 үзэгчид ногдох дундаж зардал 37,017 төгрөг бөгөөд 100 төгрөгийн зардал гаргаж 9 төгрөгийн орлого олжээ.

**22. 2013-2018 онд музейн салбар жилд 532.8-878.5 сая төгрөгийн орлого олсон бол Ковидын дараа 2022 онд 2.3 тэрбум төгрөгийн орлого олжээ.** Музейн 1 үзэгчид ногдох үйл ажиллагааны зардал 2022 онд дунджаар 17,012 төгрөг байна. Энэ үзүүлэлт театр, чуулгын үйлчилгээний хувьд 37,017 төгрөг гарч байснаас 2

---

дахин бага байна. 2022 онд музейн үйлчилгээнд зарцуулсан 100 төгрөг тутамд 17 төгрөгийн орлого олжээ.

**23. Номын сангийн 1 байнгын уншигчид ногдох үйл ажиллагааны дундаж зардал 24.6 мянган төгрөг байна.** Номын сангийн үйл ажиллагааны 100 төгрөгийн зардал тутамд 2 төгрөгийн орлого олжээ. Номын сангийн үйлчилгээг нь иргэдэд үнэ төлбөргүй үзүүлдэг учраас үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд орлого олох бараг боломжгүй юм. Харин номын сангийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, номын сангаар цахимаар зайнаас үйлчлүүлэх боломжоор үйлчлүүлэгчийг хангах чиглэлээр ажиллах нь хүн амын боловсрол, соёл, хөгжилд үр дүнтэй хувь нэмэр болно.

**24. Сумын соёлын төвүүд нь соёлын салбарын хамгийн өндөр өртөгтэй үйлчилгээ болж байна.** Соёлын төвүүдийн 1 суудалд ногдох жилийн үйл ажиллагааны зардал 2013-2018 оны дунджаар 460 мянган төгрөг, 2022 онд 343.4 мянган төгрөг байжээ. Энэ нь театр, чуулга, музейн нэг үйлчлүүлэгчид болон номын сангийн 1 уншигчид ногдох жилийн үйл ажиллагааны зардлаас өндөр байна. Хэдийгээр зардлын хувьд өртөгтэй ч хүн амд соёлын үйлчилгээг түгээх анхан шатны нэгж учраас зайлшгүй байх шаардлагатай боловч соёлын төвүүдийн үйл ажиллагаа хязгаарлагдмал, хоцрогдсон хэвээр байна.

**25. Монгол Улсын соёлын бүтээлч үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хэмжээ 2020 онд 2.6% байгаа нь дэлхийн дунджаас 3 дахин доогуур байна.** Соёлын бүтээлч үйлдвэрлэл, тоног төхөөрөмж, дагалдах материал болон соёлын холбогдох салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 2020 онд оны үнээр 982.8 тэрбум төгрөг байна. Соёлын салбар 2020 онд нийт 362,209.76 ам.долларын бүтээгдэхүүн экспортолсон. 2010-2020 оны нийт экспортын 47.7% нь соёлын бараа, бүтээгдэхүүн байсан бол 52.3% нь тоног төхөөрөмж дагалдах материал байна. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарт 2020 онд 33.9 мянган хүн ажиллаж байгаагаас 27% нь хувцас загварын, 24% нь өв соёлын, 17% нь дүрслэх урлаг, гар урлалын салбарт тус тус ажиллаж байна. Харин соёлын дижитал инновац, контентын салбарт ажиллагчдын эзлэх хувь дөнгөж 4% байна. Монгол Улсын соёлын салбарын бодлогын тэргүүлэх чиглэл нь үндэсний нэгдмэл үнэт зүйлийг цогцлоох, нийтийн соёлын боловсролыг олгох, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэж байна.



**1. Соёлын салбарын удирдлагын тогтолцоог тогтвортой байлгах.** Соёлын яам байгуулж, удалгүй татан буулгадаг нь салбарын үйл ажиллагаанд доголдол үүсгэж байгаа тул засаглалыг тогтвортой байлгах нь зүйтэй. Салбарын төсөвт хамгийн их дарамт үзүүлдэг боловч сумдад хүн амын тоо цөөн, соёлын үйлчилгээнд төлбөр төлөх боломж орон нутгийн иргэдэд хязгаарлагдмал учраас сумын соёлын төвүүдийг хувийн хэвшил, орон нутгийн засаг засаг захиргааны нэгжид шилжүүлэхийг санал болгохгүй. Харин хүн амтай олонтой томоохон сумдад хувийн хэвшлийн болон орон нутгийн төсвийн санхүүжилтийг соёлын төвд татах зорилгоор орон нутгийн засаг захиргаанд тодорхой хугацаагаар гэрээгээр шилжүүлэх хувилбарыг туршиж үзэж болно. Ялангуяа, улсын төсвөөс татаас авдаггүй аймгуудын сумдын соёлын төвийн үйл ажиллагаанд шинэчлэл хийх нь зүйтэй юм.

**2. Соёлын салбарын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг шинэчлэх.** Соёлын байгууллагуудаас авдаг захиргааны тоо мэдээллийг сайжруулах, албан ёсны статистик үзүүлэлтүүдийг шинэчлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын салбарын хувийн хэвшилд ажиллагчдын тооны статистик мэдээлэл зэргийг тооцдог болох шаардлагатай байна. Түүнчлэн соёлын үйлчилгээний үр дүн, иргэдийн соёлын боловсролын нөхцөл, байдал эсхүл үйлчилгээний хүртээмж, агуулгын талаарх статистикийн түүвэр судалгааг хийх нь зүйтэй байна. ЮНЕСКО-оос гаргасан ТХЗ-той соёлын салбарын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээс наад зах нь 11 үзүүлэлтийг манайд нэвтрүүлэхийг зөвлөж байна.

**3. Соёлын салбарын хөтөлбөрийн төрлийг оновчтой тодорхойлж, зориулалт, арга хэмжээний ангиллыг сайжруулах.** Соёлын салбарын төсвийг ЗГ-ын дунд хугацаанд дэвшүүлсэн бодлого, чиглэлтэй уялдуулан соёл урлаг, соёлын өв, Соёлын бүтээлч үйлдвэрлэл болон соёлын бодлого, удирдлага гэсэн 4 хөтөлбөрөөр төсвийг төлөвлөж, зарцуулах саналтай байна. Түүнчлэн салбарын хөрөнгийн зардлын төсвийг ангилагдаагүй бусад гэсэн хөтөлбөрт дахин тусгалгүй тухайн хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардал нь ямар гарцад чиглэж байгаагаас шалтгаалан холбогдох хөтөлбөрийн зардалд төсвийг тусгуулж байх нь зүйтэй юм. Жишээлбэл, соёлын төвийн барилга барих хөрөнгийн зардлыг соёл урлаг хөтөлбөрт, музейн хөрөнгө оруулалтыг соёлын өв хөтөлбөрт тус тус тусгах боломжтой. Соёлын сайдын шууд зардлуудын төсвийг холбогдох төсвийн хөтөлбөр болгон зардлыг зориулалт, арга хэмжээгээр салгаж төсвийг батлуулан, урьдчилан төлөвлөдөг байх нь зүйтэй байна. Ингэснээр хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж, дэвшүүлсэн зорилтдоо хүрч байгаа эсэхийг хянах боломжтой болно.

**4. Салбарын хөрөнгийн зардлын гүйцэтгэлийг сайжруулах.** Соёлын салбарын төсвийн зарлагын гүйцэтгэлийг анх баталсан төсөвтэй нь харьцуулан үнэлэхэд төсвийн найдвартай байдал “сайн” байна. Гэхдээ салбарын батлагдсан төсөв ба гүйцэтгэлийг байгууллагаар болон эдийн засгийн ангиллаар харахад хөрөнгө

---

оруулалтын зардлын дутуу гүйцэтгэл нь төсвийн гүйцэтгэлд хамгийн нөлөө үзүүлж байна. Барилга байгууламжийн ашиглалтад орох хугацаа төлөвлөснөөс хойшлох нь төсөвт өртөг нэмэгдэх гол хүчин зүйл болж эдийн хувьд үр ашиггүй нөхцөл байдал үүсдэг. Иймд төсөл арга хэмжээний ТЭЗҮ-ийг анхнаас нь зөв тодорхойлж, ач холбогдлоор нь эрэмбэлж, шаардлагатай төсөлд л хөрөнгө оруулалт хийхдээ архитектор дизайны орчин үеийн шийдлийг харгалзан үзэх нь зүйтэй байна.

**5. Соёлын үйлчилгээний байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас олсон өөрийн орлогын бүртгэл, хяналтыг сайжруулах.** Соёлын байгууллагуудыг орлого олоход сэдэлжүүлэх, орлогын бүртгэл, хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Байгууллагын өөрийн орлогоор төсвийн нэмэлт дансанд төвлөрүүлсний дараа уг данснаас зардлыг богино хугацаанд буюу тухай бүр гаргах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна. Учир нь тоглолт зохион байгуулж орлого олох тохиолдолд бэлтгэл ажлыг хангах, хувцас, тайз бэлтгэх зардлыг буцааж богино хугацаанд гаргаж чадахгүй байгаа нь орлогоо байгууллагын дансанд төвлөрүүлэхгүй байх нөхцөл болох эрсдэлтэй байна.

**6. Орон нутгийн соёлын байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг бууруулах шийдлийг санаачлах.** Орон нутагт халаалт, дулааны асуудлыг нүүрсний уурын зуухаар шийдэж байгаа нь өртөг өндөртэй эрчим хүчний эх үүсвэр юм. Зөвхөн соёлын байгууллагуудын хувьд төдийгүй төсөвт үзүүлэх байр ашиглалттай холбоотой зардлын дарамтыг бууруулахын тулд эрчим хүчний хэмнэлттэй дулааны алдагдалтай барилга байгууламж барихад анхаарах, нар, салхины эрчим хүч зэрэг байгальд ээлтэй сэргээгдэх эрчим хүчийг хуримтлуулж ашиглах ухаалаг технологийг нэвтрүүлэхэд онцгой анхаарах нь зүйтэй байна. Энэ чиглэлээр цаашид сэргээгдэх эрчим хүч, ногоон энергийг дэмжигч ОУ-ын байгууллагатай хамтран төсөл хэрэгжүүлэх санаачилга гаргаж болно.

**7. Соёлын үйлчилгээнд дижитал технологийг нэвтрүүлэх, урлагийн үзүүлбэрийн виртуал, онлайн хувилбарыг бий болгох, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах.** Виртуал концерт, шоу зохион байгуулах, онлайнаар музей үзэх, номын сангийн номыг цахимаар унших боломжийг үйлчлүүлэгчид нээх хэрэгтэй байна. Энэ чиглэлээр улсын төсвийн төдийгүй хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах нь зүйтэй байна. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, ялангуяа дижитал контент үйлдвэрлэлийг тэргүүн ээлжид дэмжих нь зүйтэй юм. Үүний тулд боловсон хүчнийг сургах, шинэ бүтээлийн туршилт хийх, соёл урлагийн порталууд, дотоодын контентыг түгээх онлайн платформуудыг бий болгохыг зөвлөж байна. Түүнчлэн соёлын үйлдвэрлэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих шаардлагатай байна.

**8. Соёлын төвийг одоогийн байгаа хүний нөөцөд нь тулгуурлан соёл, мэдээллийн олон нийтийн төв болгож үйл ажиллагааг нь сайжруулах.** Соёлын төв нь хязгаарлагдмал үйл ажиллагаатай, түлш халаалтын зардал өндөртэй захиргааны байшин байх ёсгүй. Харин хүүхэд болон насанд хүрэгчдийн хөл хөдөлгөөнд дарагдсан соёлын олон төрлийн үйлчилгээ үзүүлэх газар байж төсвийн хөрөнгийн үр ашгийг хангана. Иймд соёлын төвийг төрийн байгууллагын хандлагаас олон нийтийн төв байхад чиглүүлэх, хувь уран бүтээлчид, сайн дураар

---

урлагаар хичээллэгч, сонирхогчдыг хөгжүүлэх, иргэд урлагийн бүтээл, зургийн үзэсгэлэнгээ гаргах орон зайг бий болгох шаардлагатай байна. Түүнчлэн бүх насныханд зориулсан хөгжим, дуу, зургийн дугуйлангуудыг хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулж болно.



Bogen, P. (2018). Stronger Arts and Cultural Organizations for a Greater Social Impact. Business Models profiling of Cultural Centres & Performing Arts Organizations. Sweden: Trans Europe Halles, Cretative Lenses.

BOP Consulting. (2021). Cultural and Creative Industries in the Face of COVID-19: An Economic Impact Outlook. Paris: UNESCO.

European Union. (2019). Appendix. Manual on sources and methods for the compilation of COFOG statistics.-Д Luxembourg: Publications Office of the EU.

Hosagrahar, J. (2017). UNESCO Courier. <https://en.unesco.org/courier/april-june-2017/culture-heart-sdgs>-ээс Гаргасан

International Federation of Coalitions for Cultural Diversity. (2021). Report on contribution of civil society to the promotion and protection of the diversity of cultural expressions in Asia-Pacific. Paris: IFCCD.

Lambert, P. &. (2017). Ownership and Governance of Urban PACs. New York: Routledge.

Mulcahey, K. (2000). The Government and Cultural Patronage. Newark: Rutgers University press.

PEFA Secretariat. (2019). Framework for Assessing Public Financial Management. Second Edition. Washington DC: PEFA. PEFA .-ээс Гаргасан

Robinson, M. (2013). Classification for Performance-Based Budgeting: How to Structure Budgets to Enable the Use of Evidence. Washington, DC: World Bank.

Saeima. (2023). Legal Acts of The Republic of Latvia. Legal Acts of The Republic of Latvia: <https://likumi.lv/ta/en/en/id/335863-law-on-culture-centres>-ээс Гаргасан

UNESCO. (2019). Culture 2030 Indicators. Paris: UNESCO.

UNESCO. (2022). Reshaping Policies for Creativity: Addressing culture as a global public good. Paris: UNESCO.

United Nations Conference on trade and Development. (2019). Digital Economy Report 2019. Value Creation and Capture6 Implicaions for Developing Countries. Geneva: UNCTAD.

World Economic Forum. (2018). Creative Disruption: The impact of emerging technologies on the creative economy. Geneva: Word Economic Forum.



---

---

---

Монголын маркетингийн судалгааны ассоциаци. (2021). Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн суурь судалгаа. Улаанбаатар: “Мөнхийн үсэг” ХХК.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр. (2021). Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичиг болон Тогтвортой хөгжлийн зорилго хоорондын уялдаа, тойм шинжилгээ: Үр дүн, дүгнэлт, санал зөвлөмж. Улаанбаатар: НҮБХХ.

Т.Намнан, б. (2021). Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн суурь судалгаа. Улаанбаатар: Соёлын яам.

Хавсралт-1. Соёлын салбарын 2023 оны тодотгосон төсвийн зарлага, зориулалт арга хэмжээний ангилал, байгууллага /сая.төг/

Дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын санд худалдаж авах	Кино урлагийг дэмжих	Музей, түүх, соёлын өвийн сэргээн засварлалт	Музейн үзэмэр худалд ан авах	Оны шилдэг уран бүтээлч найруулагч жүжигчин зураач бүжигчдийг шагнах	Соёл урлагийн олон улсын тэмцээнд Тэргүүн байр эзэлсэн уран бүтээлчдийг шагнах	Соёлын бүтээлч үйлдвэрлэл	Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах	Уран бүтээл хийлтэх	Цахим соёл хөтөлбөр	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	Нийт
<b>Кино урлаг</b>	<b>100.0</b>										<b>100.0</b>
Кино урлагийг дэмжих сан	100.0										100.0
<b>Музей</b>		<b>0.6</b>					<b>91.8</b>	<b>5.4</b>		<b>54.5</b>	<b>152.3</b>
Байгалийн түүхийн музей							0.8			7.9	8.7
Богд хааны ордон музей							4.7			6.2	10.9
Бурхан халдун уул ТХТНХЗ							50.8				50.8
Дүрслэх урлагийн музей							4.1			3.7	7.9
Дэлхийн Өв Орхоны соёлын дурсгалт газар										0.8	0.8
Монгол Алтай хадны ЗЦХЗБ							24.5				24.5
Соёлын өвийн төв							6.9				6.9
Театрын музей		<b>0.2</b>								<b>0.5</b>	<b>0.7</b>
Уран зургийн галерей								2.3			2.3
Үндэсний түүхийн музей		<b>0.4</b>						<b>3.1</b>		<b>5.4</b>	<b>8.9</b>
Хархорин музей										8.9	8.9
Хөшөө цайдам музей										1.0	1.0
Чингис хаан музей										11.8	11.8
Чингис хааны өв соёлын хүрээлэн										3.8	3.8
Чойжин ламын сүм музей										4.4	4.4
<b>Номын сан</b>										<b>2.9</b>	<b>2.9</b>
Үндэсний номын сан										2.9	2.9

	Дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын санд худалдаж авах	Кино урлагийг дэмжих	Мюзей, түүх, соёлын өвийн сэргээн засварлалт	Мюзейн үзэмэр худалд ан авах	Оны шилдэг уран бүтээлч найруулагч жүжигчин зураач бүжигчдийг шагнах	Соёл урлагийн олон улсын тэмцээнд Тэргүүн байр эзэлсэн уран бүтээлчдийг шагнах	Соёлын бүтээлч үйлдвэрлэл	Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах	Уран бүтээл хийлтэх	Цахим соёл хөтөлбөр	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	Нийт
<b>Театр, чуулга</b>									<b>317.4</b>			<b>317.4</b>
Улсын драмын эрдмийн театр									99.6			99.6
Улсын дуурь бүжгийн эрдмийн театр									66.7			66.7
Улсын филармони									36.0			36.0
Улсын хүүхэлдэйн театр									23.3			23.3
Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга									91.7			91.7
<b>Шууд харьяа</b>	<b>28.8</b>			<b>57.7</b>	<b>44.1</b>	<b>9,161.3</b>	<b>100.0</b>	<b>1,720.0</b>	<b>5.8</b>	<b>500.0</b>		<b>12,012.1</b>
Аймаг, нийслэлийн соёл, урлагийн газар						5.4			5.8			11.2
Соёл урлагийн газар	28.8			57.7	44.1							205.6
Соёл, урлаг хөгжүүлэх сан						800.0						800.0
Соёлын сайдын шууд						8,355.9	100.0	1,720.0	319.5	500.0		10,995.4
<b>Нийт</b>	<b>28.8</b>	<b>100.0</b>	<b>0.6</b>	<b>57.7</b>	<b>44.1</b>	<b>9,161.3</b>	<b>100.0</b>	<b>1,720.0</b>	<b>328.5</b>	<b>500.0</b>	<b>57.3</b>	<b>12,584.6</b>

